

Засгийн газрын Үйл ажиллагааны хөтөлбөр

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам

2019 оны жилийн эцэс

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг)	2019 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн	Хэрэгжилтийн хувь
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ӨСӨЛТИЙГ ХАНГАХ БОДЛОГО							
1	2.18.Хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор "Мах, сүүний анхдугаар аян"-ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангана.	4. Сүү, сүүн бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх замаар бага насны хүүхдийн эрүүл мэндийг дэмжих зорилгоор "Үдийн цай" хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн ЕБС-ийн бага ангийн сурагчдад өдөр бүр өгөх сүү, сүүн бүтээгдэхүүнийн хэмжээг 200 граммд хүргэх	2017 - 2020		ЕБС-ийн 114 мянган хүүхэд хамрагдах	Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолоор ерөнхий боловсролын сургуулийн Үдийн цай хөтөлбөрт хамрагдаж байгаа бага ангийн нэг сурагчид ногдох зардлыг 50 хувиар нэмэгдүүлж, 900 төгрөг болголоо. Зардалд шинээр оруулсан нэмэгдэл нь сүү, сүүн бүтээгдэхүүний орц, норм, хэмжээг нэмэгдүүлэхэд зориулагдах бөгөөд үүний үр дүнд 2020 оны нэгдүгээр сараас эхлэн улсын хэмжээнд, хичээлийн жилд 327000 хүүхэд 7 хоногт 2-оос дээш удаа 200 орчим гр хүртэл хэмжээтэй сүү, сүүн бүтээгдэхүүн хэрэглэх нөхцөл бүрдлээ. Энэ үйл ажиллагааг "Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хууль" болон "Үдийн цай хөтөлбөрийг хэрэгжүүлэх журам"-аар тус тус зохицуулж байна.	100%
2	2.25.Мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх, эдийн засгийн	2. Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэл болон малын тэжээл,	2017 - 2020		МАН-н үйлдвэрлэлийн техникийн шинэчлэлийг	Засгийн газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр" батлагдсан. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжүүлэх хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт	Үнэлэх боломжгүй

<p>эргэлтийг сайжруулах, дэвшилтэт техник, технологийн шинэчлэлийг хийх, инновацийг нэвтрүүлэх, түүнчлэн “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлнэ.</p>	<p>хадлан бэлтгэлд техник, технологийн шинэчлэл, инновацийг нэвтрүүлэх, лизингийн үйлчилгээг хөгжүүлэх</p>			<p>15-аас доошгүй хувиар, дэвшилтэт технологи, инновацийн бүтээгдэхүүн нэвтрүүлэлтийг 10 хувиар нэмэгдүүлэх</p>	<p>ажилласан. Хөтөлбөрийн биелэлтийг хангахад чиглэсэн төлөвлөгөө боловсруулж, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/120 дугаар тушаалаар "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг 2019-2023 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулсан байна.</p>	
<p>3 2.26. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”, “Монгол малчин”, “Малжуулах” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.</p>	<p>1. “Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны хэрэгжилтийг зохион байгуулах</p>	<p>2017 - 2020</p>		<p>“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны төлөвлөгөөний хэрэгжилтийг 80 хувьд хүргэх</p>	<p>“Төрөөс малчдын талаар баримтлах бодлого”-ыг хэрэгжүүлэх хоёр дахь үе шатны хэрэгжилтийн 2.1 зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар мал үржүүлэг, малын өвчин, эмгэгээс сэргийлэх оношлуур, вакцин, эм бэлдмэлийн технологи, тэжээлийн жор, технологийн чиглэлээр хэрэгжүүлж байгаа Шинжлэх ухаан, технологийн 9 төслийг Шинжлэх ухаан, технологийн сангаас нийт 931.0 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. Үүнд: 1. 2017-2019 онд хэрэгжих 3 төсөлд 290.0 сая, 2. 2018-2020 онд хэрэгжих 3 төсөлд 314.0 сая, 3. 2019-2021 онд хэрэгжих 3 төсөлд 300.0 сая. төгрөгийг тус тус олгосон байна. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар 2020 оноос эхлэн “Сарлагийн эко хэвшлийн олон янз байдалд өвөрмөц байдлын хамаарал, нөлөөллийг фено, гено шинж тэмдгийн илрэлээр тогтоох нь”, “Хангай, Орхон, Тал нутгийн цагаан үүлдрийн нарийн, нарийвтар ноост хонинд селекцийн эх сүрэг бүрдүүлэх, бүтээмжийг дээшлүүлэх”, “Бэлчээрийн болон эрчимжсэн аж ахуйн төлийн тархмал өвчинтэй тэмцэх өсөлтийн физиологид суурилсан арга, бэлдмэлийн технологи”, “Бог малын мялзан өвчний</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>

					вакцины загвар бэлтгэн турших” төслүүдийг хэрэгжүүлэхээр боллоо.		
4		2. “Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	2017 - 2020		“Монгол малчин” хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах	Монгол малчин” хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж байна. Ажлын хэсгийн хурлаар хөтөлбөрийн төслийг хэлэлцэж, хурлаас гарсан санал дүгнэлтийг хөтөлбөрийн төсөлд тусган боловсруулсан.	Үнэлэх боломжгүй
5	2.28.Мал аж ахуйн мэргэжилтнийг бэлтгэх, давтан сургах, мал аж ахуйн хөгжлийн талаархи олон улсын туршлагыг судлах, нэвтрүүлэх, “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1. Мал аж ахуйн мэргэжилтэн, туслах ажилтныг бэлтгэх, давтан сургах тогтолцоог сайжруулж, хэрэгжилтийг зохион байгуулах	2017 - 2020		МАН-н мэргэжилтэн, туслах ажилтныг бэлтгэх, давтан сургах үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах	Малын генетик нөөцийн тухай хуульд өөрчлөлт орсноор сум бүрд малын эмч ажиллуулах шаардлага үүссэн. Иймд Хөдөө, аж ахуйн их сургуулийн Мал эмнэлгийн сургуулиас шаталсан болон түр сургалтуудыг зохион байгуулж, мал эмнэлгийн чиглэлээр өмнө төгссөн иргэд болон малын эмч нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулах ажлыг зохион байгуулсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны зүгээс тухайн хуулийг дагаж гарах дүрэм, журмуудад санал өгч хамтран ажиллаж байна. Хөдөө аж ахуйн их сургууль нь “Бизнесийн удирдлага”, “Мал эмнэлэг”, “Агрономи”, “Байгаль орчны хяналт үнэлгээ” зэрэг магистрын хөтөлбөрийн элсэлт төгсөлтийг нэмэгдүүлэх зорилгоор 13 хичээлийн хөтөлбөрийг онлайн системд байршуулсан. 2019-2020 оны хичээлийн жилд 78 суралцагч онлайн ба танхимын хосолсон сургалтаар суралцаж байна. Мөн Хөдөө, аж ахуйн их сургууль дээр “Жайка”-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй “Мал эмнэлэг, мал аж ахуйн хүний нөөцийг бэхжүүлэх” төслийн хүрээнд -Хоккайдогийн Их Сургуулийн профессор Юки Очи, Хоккайдогийн Их Сургуулийн профессор М.Хориучи “Сүрьеэ өвчний үүсгэгч, түүнийг илрүүлэх аргууд”, Хоккайдо их сургуулийн профессор Кодай Мотохиро “RT ПСР ажиллуулах зарчим, шинжилгээний аргууд” зэрэг сэдвээр сургалт	Үнэлэх боломжгүй

						зохион байгуулж, эм судлалын лабораторид 1 сар багш оюутнуудад зөвлөгөө өгч ажиллалаа.	
6		3. “Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2017 - 2020		“Малчдыг мэдлэгжүүлэх, мэдээллээр хангах” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах	2019 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны захиалгаар Хөдөө аж ахуйн их сургууль малчдыг мэдлэг, мэдээллээр хангах чиглэлээр "Бог малын ангилагч", "Сүүний үүлдрийн үхрийн аж ахуй", "Малын үржлийн чанар", "Сүргийн бүтцийг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх", "Эко бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх аргачлал" зэрэг сэдвийн хүрээнд сургалтууд зохион байгуулж, 1000 гаруй малчдыг хамруулсан байна. Мөн "Ногоон алт – Малын эрүүл мэнд" төслийн хүрээнд бэлчээр ашиглалт болон малын эрүүл мэнд үүлдэр угсааг сайжруулах чиглэлээр 76.8 мянган малчин өрхийг хамруулсан сургалт зохион байгуулсан.	Үнэлэх боломжгүй
7	2.48.Үйлдвэржилтийн 21:100 хөтөлбөрийг хэрэгжүүлж, импортыг орлох экспортын чиглэлийн	6. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2017 - 2020		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 36 дугаар тогтоолоор “Үйлдвэржилт 21:100” үндэсний хөтөлбөр батлагдан хэрэгжиж байна.	Үнэлэх боломжгүй
8	тэргүүлэх болон жижиг, дунд үйлдвэрлэл, хоршоо, худалдаа, үйлчилгээний салбарын татвар, эрх зүй, бизнесийн таатай орчинг бүрдүүлж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн дотоодын нийт	7. "Үйлдвэржилт 21:100" хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймагт 100 нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэр байгуулахад санхүү, эрх зүйн дэмжлэг үзүүлж ажиллах	2017 - 2020		Үйлдвэрүүдийн үйл ажиллагааг эхлүүлж, туршилт тохируулга хийгдэх, дэд бүтцийн бүтээн байгуулалтын 45-60 хувь нь хийгдэх	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны зүгээс Үндэсний үйлдвэрлэлийн салбарт ажиллах инженер, техникийн ажилтныг түлхүү бэлтгэх, энэ чиглэлээр их, дээд сургуульд элсэгчдийн тоог нэмэгдүүлэх бодлого баримталж байна. Мөн Монгол орны байгалийн болон хөдөө аж ахуйн түүхий эдэд суурилсан үйлдвэрлэлийн чиглэлээрх эрдэм шинжилгээ, инновацийн төсөл болон гарааны компанийн үйл ажиллагааг дэмжин ажиллаж байна. ХХААХҮЯ-ны хувьд: Хөтөлбөрийн 1-р шат /2018-2019/-нд нийт 72 үйлдвэр байгуулахаар төлөвлөснөөс тайлант 3 дугаар улирлын байдлаар Нийт 38 үйлдвэр байгуулагдаж, үйл ажиллагаа	Үнэлэх боломжгүй

	бүтээгдэхүүнд эзлэх хэмжээг нэмэгдүүлнэ.				эхэлсэн, 65 үйлдвэр 10-90 хувийн гүйцэтгэлтэй байна. Улсын төсвөөс үйл ажиллагааны зардалд 259.8 сая төгрөг, орон нутгийн түүхий эд, ажиллах хүчний нөөцөд тулгуурлан үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн, төвлөрлийг сааруулах зорилгоор ЖДҮХС-аас 17.3 тэрбум төгрөгийг 304 аж ахуйн нэгжид, АХБ-ны ХААХХТ-ийн нэмэлт санхүүжилт төслийн хүрээнд 12.7 тэрбум төгрөгийг 17 аж ахуйн нэгжид олгосноор 3758 ажлын байр хадгалан, 1542 ажлын байр шинээр бий болсон байна.	
9	13. Хөнгөн үйлдвэрийн салбарын эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлийн хүрээлэн, төвийн үйл ажиллагааг үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай уялдуулан зохион байгуулж, оновчтой бүтцэд оруулах, хүрээлэнгийн чадавхийг бэхжүүлэх	2017 - 2019		Хүрээлэнгийн чадавхийг бэхжүүлэх, сургалтад хамруулах, тоног төхөөрөмжийг сайжруулахад дэмжлэг үзүүлэх	Шинжлэх ухаан, технологийн их сургууль болон түүний харьяа эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдэд хөнгөн үйлдвэр салбарын чиглэлээр хэрэгжүүлж байгаа шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд монгол хонины ноосны бэлтгэлийн бүсчлэл, түүхий эдийн техникийн үзүүлэлтийг агуулсан өгөгдлийн бааз бий болгох, монгол хонины ноосны ноолуурын орцтой даавууны стандарт, хонины ноосны орцтой төрөл бүрийн зориулалттай даавуу нэхэх, гүйцэтгэн боловсруулах технологи боловсруулах, бог малын болон жижиг арьс боловсруулах технологи, ноосон дулаалгын материалын технологийн судалгаа хийгдэж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн байна. Эрдэм шинжилгээний ажилтан, судлаачдын чадавхыг бэхжүүлэх чиглэлээр 2019 онд 6 сургалт зохион байгуулж, 1315 эрдэм шинжилгээний ажилтан, багш нарыг хамруулсан.	Үнэлэх боломжгүй
10	2.53.Хөнгөн, жижиг, дунд үйлдвэрийн салбарын боловсон хүчнийг бэлтгэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлж “Мэргэжилтэй	1. Хөнгөн болон хүнсний үйлдвэрийн хүний нөөцийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэй	2017 - 2020	Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	Мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэл хийх мэргэжлийн зөвлөлийн анхны хуралдааныг 2019 оны 5 дугаар сарын 9-ний өдөр хийж, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Эм зүйн сургуулийн “Эм найруулагч” техникийн боловсрол олгох хөтөлбөрт хөндлөнгийн үнэлгээ хийсэн шинжээчийн багийн	Үнэлэх боломжгүй

	ажилтан” хөтөлбөр хэрэгжүүлнэ.	ажилтны хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг бусад яамдтай уялдуулан хэрэгжүүлэх				тайланг хэлэлцэж, хуралдааны шийдвэрийг Мэргэжлийн боловсролын магадлан итгэмжлэх комиссоод уламжилсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хөдөө аж ахуй, хүнсний салбарын эрэлттэй мэргэжлийн жагсаалтыг хүлээн авсан. Мөн салбарын яамдаас Тэргүүлэх мэргэжлийн жагсаалт батлуулах Засгийн газрын тогтоолын төсөлд санал авч 2019 оны 7 дугаар сарын 09-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн боловч Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу асуудлыг дахин боловсруулж, хэлэлцүүлэхээр хойшлуулсан. Судалгааг дахин хийж байна. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Үйлдвэрлэл технологийн сургуулийн багш нар “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн ажилтнуудыг чадваржуулах төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, сургалт зохион байгуулах ажлыг амжилттай хэрэгжүүлж байна. Шинжлэх ухаан, технологийн сургуулийн Механик инженерийн сургуулийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд Авто засварчин, гагнуурчин, хүнд машин механызмын оператор, засварчин, үйлдвэрийн тоног төхөөрөмжийн механк, Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд Барилгын модон эдлэлийн мужаан, мебель модон эдлэлийн мужаан, ойн мэргэжлийн ажилтан гэсэн чиглэлээр тус тус мэргэжилтэй ажилтан бэлтгэж байна.	
11		2. “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийг боловсруулан батлуулах	2017 - 2020		Хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх	ХХААХҮЯ-ны ТНБД-ын А-507 тоот тушаалаар баталсан “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажилаж байна. Ажлын хэсэг “Мэргэжилтэй ажилтан” хөтөлбөрийн суурь судалгаа, ажлын төлөвлөгөөг боловсруулсан.	Үнэлэх боломжгүй
12	2.54.Хөнгөн	1. Хөнгөн	2017 -		Технологи	БНХАУ-тай хамтран “Монгол Улсад инкубаторын үйл	Үнэлэх

<p>үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх зорилгоор зөвлөгөө, мэдээлэл, сургалт явуулах мэдээллийн болон инкубатор төвийг тухайн салбарын мэргэжлийн холбоодыг түшиглэн байгуулахыг дэмжинэ.</p>	<p>үйлдвэрийн салбарт тэргүүний дэвшилтэт технологи дамжуулах, нэвтрүүлэх чиглэлээр ажиллаж байгаа хувийн хэвшлийн байгууллагаар төрийн зарим үүргийг гүйцэтгүүлэх, санхүү болон эрх зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах, АХБ, ЕСБХБ-ны төслийн хүрээнд хамтран ажиллах</p>	<p>2018</p>		<p>дамжуулалт, зөвлөгөө мэдээллээр үйлчилсэн 1 гэрээт ажил хийгдэж, технологи нутагшуулах нөхцөл бүрдэх</p>	<p>ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт”, “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг хэрэгжүүлж байна. Инкубатор байгуулах тохижилтын зураг, интериор зургийг боловсруулан, сүлжээ, серверийн тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, зөөх, гаалийн татвараас чөлөөлүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан. Төслийн хүрээнд firewall, server, storage, switch, router зэрэг 20-иод нэр төрлийн сүлжээний тоног төхөөрөмжүүдтэй 100 терабайт мэдээлэл хадгалах боломжтой сервер байгуулагдсан. “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслийн 2019 оны ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажилласан. Технологи дамжуулах төвийн дотоод тохижилтын зураг, интериор зургийг боловсруулсан. Мэдээллийн сан нь монгол, хятад, англи 3 хэл дээр ажиллах боломжтой байхаар Технологи дамжуулах платформын хөгжүүлэлтийг хийсэн. Мөн Монгол Улсын ШУТИС, Япон улсын Хоккайдо их сургууль болон Цукуба их сургууль Монголын хүнсний зарим бүтээгдэхүүний хатаах аргын судалгаа" төслийг хэрэгжүүлж байна. ШУТИС-ийн үйлдвэрлэл технологийн сургуулийн Хөнгөн үйлдвэрлэлийн технологи, инженерчлэлийн салбар, Блю Скай Кашемир ХХК-тай хамтран 2019 оны 11 дүгээр сарын 28-нд профессор, багш оюутнуудад зориулсан үйлдвэр, технологитой танилцуулах өдөрлөг зохион байгуулж, 8 багш, нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи, Нэхмэлийн хими технологи, Хувцас үйлдвэрлэлийн технологи загвар зохион бүтээлийн ангийн 30 гаруй оюутнууд хамрагдлаа. Цаашид оюутны ажил эрхлэлт, дадлагын хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролцсон</p>	<p>боломжгүй</p>
--	---	-------------	--	---	--	------------------

					болно.	
13	2.88.Хот, суурин газруудын газар хөдлөлтийн үйлчлэлийн давтамж, эрчмийг шинэчлэн тогтоож, барилга байгууламжийн төлөвлөлтөд тусгах, ашиглагдаж байгаа барилга байгууламжуудын бат бэх, найдвартай байдлыг сайжруулах арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.	1. Улаанбаатар хот, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдийн 1:10000 масштабтай газар хөдлөлтийн бичил мужлалын зураглалд үндэслэн газар хөдлөлтийн барилгын норм, дүрмийг шинэчлэх	2017 - 2018		Энэхүү арга хэмжээ нь чиг үүргийн хувьд БСШУСЯ-д хамаарахгүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ тул БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр БСШУСЯ-ыг хамтран хэрэгжүүлэгчээс хасуулах санал хүргүүлсэн.	Үнэлэх боломжгүй
14	арга хэмжээг төлөвлөж, үе шаттай хэрэгжүүлнэ.	2. Аймаг, сум, суурин газруудын нутаг дэвсгэрт газар хөдлөлтийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлтийн эрсдэлийг тодорхойлоход чиглэсэн инженер-геологи, гидрогеологи, газар хөдлөлт, техникийн судалгааны ажлыг хийж дуусгах	2016 - 2019		Энэхүү арга хэмжээ нь чиг үүргийн хувьд БСШУСЯ-д хамаарахгүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ тул БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр БСШУСЯ-ыг хамтран хэрэгжүүлэгчээс хасуулах санал хүргүүлсэн.	Үнэлэх боломжгүй
15		3. Барилга	2016 -		Энэхүү арга хэмжээ нь чиг үүргийн хувьд БСШУСЯ-д	Үнэлэх

		байгууламжийг паспортжуулах ажлыг хэрэгжүүлэх	2020			хамаарахгүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ тул БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр БСШУСЯ-ыг хамтран хэрэгжүүлэгчээс хасуулах санал хүргүүлсэн.	боломжгүй
16		4. Газар хөдлөлтөд тэсвэргүй барилгыг буулгаж шинээр барих, ашиглах боломжтой барилгын судалгааг гаргаж, тэдгээрийг үе шаттайгаар бэхэлж хүчитгэх ажлыг зохион байгуулах	2016 - 2020			Энэхүү арга хэмжээ нь чиг үүргийн хувьд БСШУСЯ-д хамаарахгүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ тул БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр БСШУСЯ-ыг хамтран хэрэгжүүлэгчээс хасуулах санал хүргүүлсэн.	Үнэлэх боломжгүй
17		5. Газар хөдлөлтийн лаборатори байгуулах, техник, тоног төхөөрөмж нийлүүлэх, хүний нөөцийг сургаж бэлтгэх ажлыг зохион байгуулах	2017 - 2020			Энэхүү арга хэмжээ нь чиг үүргийн хувьд БСШУСЯ-д хамаарахгүй бөгөөд үндсэн хэрэгжүүлэгч БХБЯ тул БСШУС-ын сайдын 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр БСШУСЯ-ыг хамтран хэрэгжүүлэгчээс хасуулах санал хүргүүлсэн.	Үнэлэх боломжгүй
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГО							
18	3.1.2.Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт	5. Хүн амыг уламжлалт анагаах ухааны аргаар эрүүл мэндээ	2017 - 2018			БСШУСЯ-ны харьяа Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгээс Монголын уламжлалт анагаах ухаан, эм, эмнэлгийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилгаа хийж байна. Боловсролын тухай хуульд нэмэлт,	Үнэлэх боломжгүй

	<p>үнэ төлбөргүй хамруулах, алслагдсан орон нутагт явуулын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлнэ.</p>	<p>хамгаалах, сайжруулах мэдлэг, арга барилтай болгох мэдээлэл, сургалт сурталчилгааг өргөжүүлэх</p>				<p>өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал болон хуулийн төсөлд боловсролын байгууллагын албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд үнэ төлбөргүй хамруулах асуудлыг аймаг, нийслэлийн Засаг дарга, боловсрол, эрүүл мэндийн байгууллагатай хамтран зохион байгуулахаар тусгав. ШУТБГ БСШУСЯ-ны харьяа Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэнгээс Монголын уламжлалт анагаах ухаан, эм, эмнэлгийн талаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилгаа хийж байна. Мөн Уламжлалт анагаах ухаан, технологийн хүрээлэн, Оточ маарамба их сургууль зэрэг байгууллагуудад уламжлалт анагаах ухааны чиглэлээр судалгааны ажлууд хэрэгжүүлэн, бий болсон мэдлэг, үр дүнг эрдэм шинжилгээний хурал, Шинжлэх ухааны ажилтны өдөр болон инновацийн 7 хоног зэрэг үйл ажиллагааны үеэр зохион байгуулагдаж байгаа үзэсгэлэн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.</p>	
19	<p>3.1.7.Эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулж хэрэгжүүлэн эх, нялхсын эндэгдлийг бууруулна.</p>	<p>1. Эх, хүүхдийн эрүүл мэндийн тухай хуулийн төслийг УИХ-д өргөн мэдүүлэх</p>	<p>2017 - 2018</p>			<p>2019 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг баталлаа. Дунд, ахлах ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт "Гэр бүлийн харилцаа", "Монголчуудын удам судар", "Ураг удмаа танин мэдэхийн ач холбогдол", "Эрүүл мэндээ хамгаалах хэрэгцээ, арга зам", "Ирээдүйн эцэг эхийн гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлага", "Гэр бүлийн гишүүдийг асарч, энэрэх", "Гэр бүлийн гишүүдэд туслах, тэднийг хүндлэх, ачийг хариулахын ач холбогдол" зэрэг харилцаа, эрүүл ахуйн сэдвүүд шинээр нэмэгдэж</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>

					сурагчид судалж эхлээд байна.	
20	3.2.1. Малчны хүүхдийг 6-8 насны сонголттойгоор сургуульд элсэн суралцах боломжийг бүрдүүлнэ.	1. Ерөнхий боловсролын сургуульд 6 настай хүүхдээ элсүүлэх малчин эцэг эхийн хүсэлтийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт бий болгож, хэрэгжүүлэх	2016 - 2017		Улсын хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд нэгдүгээр ангид элсэх сурагчдын судалгааг аймгуудаас авч нэгтгэн, шинээр нээгдэх бүлэг, нэмж шаардагдах багшийн тоог гаргалаа. Судалгаагаар энэ хичээлийн жилд 75,0 мянга орчим хүүхэд элсэх бөгөөд 5 дугаар ангийг 1750 орчим бүлэг төгсч, 200 орчим нэгдүгээр ангийн бүлэг шинээр үүснэ. 2019 оны 5 дугаар сард 7 настай элсэхээр 2068 сурагч хүсэлт гаргасныг шийдвэрлэлээ.	100%
21	3.2.2. "Хүүхэд бүр цэцэрлэгт" хөтөлбөрийг хэрэгжүүлж хот суурин газарт хүүхэд бүр цэцэрлэгт хамрагдах боломжийг бий болгоно.	1. Цэцэрлэг барих төр, орон нутгийн болон олон улсын тусламжийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2016 - 2020		Монгол Улсын хэмжээнд 2-5 насны сургуулийн өмнөх боловсролын 312,802 хүүхэд байгаагаас 2019-2020 оны хичээлийн жилд нийт 1,439 цэцэрлэгт 263,333 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 84,1 хувьд хүрч, өмнөх оноос 2,2 хувиар өссөн дүнтэй байна. Улсын төсвийн санхүүжилтээр: 2019 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 91.1 тэрбум төгрөгний төсөвт өртөгтэй, 10020 хүүхдийн хүчин чадал бүхий 76 цэцэрлэг, гадны тусламжаар 225 хүүхдийн хүчин чадал бүхий 2 цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон. Орон нутагт 5345 хүүхдийн хүчин чадал бүхий 50 цэцэрлэг, нийслэлд 4900 хүүхдийн хүчин чадал бүхий 28 цэцэрлэг байна. 2019 онд барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 84 цэцэрлэг байна. Үүнээс: - 70%-95% гүйцэтгэлтэй 22 цэцэрлэг - 50%-59% гүйцэтгэлтэй 14 цэцэрлэг - 30%-49% гүйцэтгэлтэй 19 цэцэрлэг - 3%-29% гүйцэтгэлтэй 29 цэцэрлэг Мөн 2019-2020 оны хичээлийн жилд 8 цэцэрлэгийн 2 их сургууль, 2 цэргийн анги, 4 аж ахуйн нэгж байгууллагын санаачилгаар "салбар бүлэг"	100%

					байгуулж, шинээр 500 хүүхэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдлаа. Гадны тусламж: 2.8 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий хөрөнгө оруулалтаар 275 хүүхдийн хүчин чадал бүхий цэцэрлэгийн барилга ашиглалтад орсон.	
22	2. Хөдөө орон нутагт малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгийн тоог өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх	2017 - 2020			Хөдөө орон нутагт малчдын хүүхдэд зориулсан гэр цэцэрлэгийн тоог өсгөх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2016 онд 200.7 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 67 цэцэрлэгийг, 2017 онд 626.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэглэлтэй 50 цэцэрлэг, 2018 онд 206.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэглэлтэй 28 гэр цэцэрлэг, 2019 онд 57.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмж, хэрэглэл нийлүүлсэн. 2020 онд 340.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 22 гэр цэцэрлэг нийлүүлэхээр төлөвлөж байна. Гэр цэцэрлэгийн хэрэглэгдэхүүнд олон нэр төрлийн тоглоом, хатуу, зөөлөн эдлэл, цахилгаан үүсгүүр, хөргөгч, био 00, хоолны хэрэглэл гэх мэт тоног төхөөрөмж багтаж байна.	100%
23	3. Хувийн хэвшлийн болон байгууллагын цэцэрлэгийн тоог нэмэгдүүлэх	2017 - 2020			Хувийн өмчийн сургуулийн өмнөх байгууллага 2017 онд 500 цэцэрлэгт 32584 хүүхэд хамрагдаж 27394.1 сая төгрөг, 2018 онд 538 цэцэрлэгт 40491 хүүхэд хамрагдаж 34598.3 сая төгрөг, 2019 болон 2020 онд 546 цэцэрлэгт 40293 хүүхэд хамрагдаж 33016.9 сая төгрөгийн хувьсах зардлыг Улсын төсвөөс олгож байна. Байгууллагын 16 цэцэрлэгийн 45 бүлэгт 1527 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна. Үүнээс: энэ хичээлийн жилд 8 бүлгийн 185 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг ажиллаж эхэлсэн. /Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ, Гадаадын иргэн, харьяатын газар, Хэнтий аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Төв аймгийн Баянбуурал амралтын	100%

					газар, TESO Corporation, Соёл урлагийн их сургууль, АШУҮИС/	
24	4. Төрийн өмчийн цэцэрлэгт хүүхдийн хоолны зардлыг төрөөс болон эцэг эх, асран хамгаалагчаас хариуцах хувь, хэмжээг тогтоон хэрэгжүүлэх	2017 - 2020			Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх заалтын дагуу хүүхдийн хоолны зардлын тодорхой хувийг эцэг эхээс санхүүжүүлэх тухай заалтын дагуу 2017 оны 11 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн боловч 2024 он хүртэл хойшлуулсан. Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 50 хувиар нэмэгдүүлэх асуудлыг хэлэлцүүлж батлууллаа. 2020 оны 01 дүгээр сараас эхлэн цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал 2475/3500 төгрөг болж нэмэгдэж байна.	100%
25	5. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой шинэ арга, технологийг судалж, хэрэгжүүлж эхлэх	2016 - 2017			Засгийн газрын 2019 оны "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 183 дугаар тогтоол батлагдсан. Тус тогтоолд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой шинэ, арга технологи, шинэлэг хэлбэрүүдийг бий болгох, дэмжих асуудлуудыг тусгасан бөгөөд тухайлбал, төрийн бус өмчийн цэцэрлэг дээр төрийн өмчийн нэмэлт бүлэг, байгууллагын дэргэдэх цэцэрлэг, зуны цэцэрлэгийн эрх зүйн орчин, зохион байгуулалт, санхүүгийн асуудлыг оновчтой болгох талаар тусгасан болно. Тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 8-ны өдрийн "Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай" А/16 тоот захирамжаар 7 дүүргийн төрийн бус өмчийн 130 цэцэрлэгт 2019-2020 оны хичээлийн жилд нэмэлт элсэлтээр 3087 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж байна.	100%

26	3.2.3.Анги дүүргэлт хэт өндөртэй сургууль, цэцэрлэгийн ачааллыг бууруулж, 3 ээлжтэй сургуулийг 2 ээлжид шилжүүлнэ.	1. Сургууль, цэцэрлэгийн эрэлт, хэрэгцээ өндөр байгаа хот сууринд хөрөнгө оруулалтыг төвлөрүүлж, сургууль, цэцэрлэг, дотуур байр, спорт заалны барилга шинээр барих, өргөтгөх, засварлах дунд хугацааны төлөвлөгөө гаргаж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	2017 - 2020			<p>Ерөнхий боловсролын зарим сургуулийн ачааллыг бууруулж, 2 ээлжид шилжүүлэх ажлын хүрээнд дараах ажлуудыг үр дүнтэй хэрэгжүүлснээр улсын хэмжээнд 3 ээлжээр хичээллэж байгаа сургуулиуд 2 ээлжид бүрэн шилжсэн. Үүнд:</p> <p>1. 2019 онд Улсын хэмжээнд нийт 46 сургуулийг бүрэн ашиглалтад оруулсан. Нийслэлд 10560 хүүхдийн хүчин чадалтай 20 сургуулийн барилга, хөдөө орон нутагт 7230 хүүхдийн хүчин чадалтай 26 сургуулийн барилга ашиглалтад орсон.</p> <p>2. Нийт 27 сургуулийн барилгад 8.4 тэрбумын төсөвтэй их засвар буюу анги танхимын тохижилт, өргөтгөл, барилгын дээвэр, цахилгаан, сантехникийн шинэчлэлийг хийсэн.</p> <p>3. Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд 2019 оны 8 дугаар сарын 21-ний өдөр "Барилга түрээслэх тухай" А/522 дугаар тушаалыг батлан Нийслэлийн засаг даргад хэлүүлснээр нийслэлийн хэмжээнд 2019-2020 оны хичээлийн жилд 11 сургууль сургалтын зориулалтын барилга түрээслэн сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулж байна.</p>	100%
27		2. Улаанбаатар хот, аймгийн төвд шинээр барих орон сууцны хороолол, хотхоны зураг төсөл, ерөнхий төлөвлөгөөнд цэцэрлэг, сургуулийг заавал тусгаж төлөвлөх чиглэлээр холбогдох норм, дүрэмд өөрчлөлт	2017 - 2020			<p>Засгийн газрын 2019 оны 5 сарын 01-ний өдрийн хуралдаанаар "Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын төслийг хэлэлцүүлж, 183 дугаар тогтоолын 4 дүгээр зүйлд "Шинээр барих орон сууцны хорооллын барилгын ажлын холбогдох зөвшөөрлийг олгохдоо сургууль, цэцэрлэгийг хамт төлөвлөн барих талаарх барилгын норм, нормативын баримт бичгийн шаардлагыг мөрдүүлж ажиллахыг аймаг, Нийслэлийн засаг дарга нарт даалгасугай" гэсэн заалтыг тусгасан.</p>	100%

		оруулж, тусгасан нөхцөлд газрын зөвшөөрлийг шийдвэрлэж байх зохицуулалтыг бий болгох					
28	3.2.5.“Байгууллагын цэцэрлэг”-ийн хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, татварын бодлогоор дэмжинэ.	1. Байгууллагын цэцэрлэг байгуулах талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах	2016 - 2017			Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Дүрэм шинчлэн батлах тухай” А/118 дугаар тушаалын хавсралтаар “Хүүхдийн цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм” батлагдсан. Энэхүү тушаалын 2.5.4-т байгууллага, аж ахуйн нэгж өөрийн санхүүжилтээр ажилтан, албан хаагч, оюутан суралцагчийнхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор бие даасан цэцэрлэг байгуулан ажиллуулах асуудлыг тусгалаа. Түүнчлэн “Цэцэрлэгийн дэргэд аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгаар “салбар бүлэг” ажиллуулахад хамтран ажиллах гэрээний үлгэрчилсэн загвар”-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/804 дүгээр тушаалаар баталж эрх зүйн орчныг бүрдүүлэх ажлыг тус тус зохион байгууллаа.	100%
29	3.2.6.Сурагчид дотуур байрандаа эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг сайжруулж, бага ангийн 6-8 настай хүүхдэд зориулсан асаргаа, халамж, хөгжлийн үйлчилгээтэй болгоно.	1. Дотуур байрны орчин, үйлчилгээний чанарыг сайжруулах дунд хугацааны төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх	2016 - 2017			Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны орчин нөхцөл, хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдлыг судалсан судалгааны үр дүнд үндэслэн "Дотуур байрны орчин, үйлчилгээг сайжруулах дунд хугацааны төлөвлөгөө"-г Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/426 дугаар тушаалаар баталсан. Мөн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх” журмыг 2018 оны А/239 дугаар тушаалаар баталсан. Уг журмаар дотуур байранд амьдарч буй хүүхдийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, хамгаалах,	100%

					материаллаг орчин, сэтгэлзүйн харилцааны нөлөөллийн асуудлыг хэрхэн зохицуулах талаар тусгасан. Түүнчлэн дотуур байрны үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд Стандартчилал, хэмжилзүйн газрын даргын 2019 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дугаар тушаалаар “MNS6781:2019. Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын дотуур байрын орчин, үйлчилгээ. Ерөнхий шаардлага”, стандарт батлагдлаа.	
30	2. Дотуур байрны орчин, үйлчилгээний нөхцөл байдлын судалгааг гаргаж, дотуур байрыг халуун ус, угаалгын үйлчилгээ, номын сан, чөлөөт цагаа өнгөрүүлэх хүүхэд хөгжлийн танхим, тоглоомын өрөөтэй болгох	2016 - 2018			"Дотуур байрын орчин, үйлчилгээг сайжруулах дунд хугацааны төлөвлөгөө"-ний хэрэгжилтийг хангах хүрээнд “Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагаанд эцэг эх, асран хамгаалагч, иргэд, олон нийтийн оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэхэд баримтлах үлгэрчилсэн чиглэл”-ийг батлан хэрэгжүүлж байна. Мөн “Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүүхэд хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх” журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/239 дугаар тушаалаар баталлаа. Сургуулийн дотуур байр, бага ангийн багш, нийгмийн ажилтанд зориулсан семинарыг 2019 оны 08 дугаар сард зохион байгуулсан.	100%
31	3. Дотуур байранд бага ангийн хүүхэдтэй ажиллах асрагч-багш, хүүхэд хөгжлийн багш ажиллуулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	2017 - 2020			Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрын орчин, үйлчилгээ MNS 6781:2019 стандарт батлагдсан бөгөөд энэхүү стандартад дотуур байранд амьдарч байгаа 6,7,8 настай хүүхдэд асрагч багш үйлчлэхээр тусгасан. 2019 онд 122 багшийг дотуур байранд ажиллуулж, улсын төсвөөс 824.6 сая төгрөг зарцуулахаар тусгасан.	100%
32	4. Дотуур байрны	2016 -			2019 оны байдлаар ЕБС-ийн дотуур байранд орон	100%

		асрагч багш, хүүхэд хөгжлийн багшийг бэлтгэж, чадавхижуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэх	2017			тооны нийт 85 асрагч багш ажиллаж байна. Эдгээр асрагч багш нар “Бага насны хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтад 100 хувь хамрагдсан. Одоогийн байдлаар орон тооны асрагч багшгүй ЕБС-ийн дотуур байрын тухайд сургуулийн захиргаанаас байрын багш нар ээлжээр 6-8 насны хүүхдээ хариуцан авч ажиллах зохицуулалтыг хийж байна.	
33	3.2.7.Цэцэрлэг, сургуулийн орчин гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, автомашины хурд сааруулагчтай болгоно.	1. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын шаардлагыг боловсруулан, мөрдүүлэх	2016 - 2017			Ерөнхий боловсролын сургууль түүний ойр, орчимд хүүхэд эрсдэлд өртөх тохиолдол нэлээд гарч байгаатай холбогдуулан БСШУСЯ-наас эрсдэлийн үнэлгээг төрийн өмчийн 654 сургуульд хийхэд нийт сургуулийн 11.9-13.5 хувь нь их эрсдэлтэй, 71.0-75.0 хувь нь дунд эрсдэлтэй, 12.0-18.0 хувь нь бага эрсдэлтэй байна гэсэн дүнтэй байна. Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан нийт сургууль эрсдэлээ багасгах арга хэмжээг зохион байгуулснаар нийт сургуулийн 19% гэрэлтүүлэг, 14% хашаа, хайсаа, 19% сургуулийн орчны цардсан зам, талбай, үүдний шатыг, 20% довжооны хэсгийн плитаг аюулгүй болгож, орчны эрсдэлийг багасгасан байна. Дээрх эрсдэлийг бууруулах, сургуулийн аюулгүй байдалд нийтлэг шаардлага тавихын тулд “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал MNS 6782:2019, Ерөнхий шаардлага” боловсруулж, Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2019 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн С/40 дүгээр тушаалаар батлууллаа.	100%
34		2. Судалгаанд үндэслэн сургуулийн аюулгүй орчныг бүрдүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг	2016 - 2017			Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамнаас төрийн өмчийн 654 сургууль, 373 дотуур байранд эрсдэлийн үнэлгээг хийж, дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд: Эрсдэлийн үнэлгээнд хамрагдсан нийт сургуулийн 19% гэрэлтүүлэг, 14% хашаа, хайс, 19% сургуулийн орчны цардсан зам, талбай, үүдний шат, 20% довжооны хэсэг, 26%	Үнэлэх боломжгүй

		баталж, хэрэгжүүлэх			биеийн тамирын талбай, 19% цахилгааны утас, шит, 19% дээвэр, 26% авто зам тэмдэг тэмдэглэгээ, хурд сааруулагч, 19% нь дотор цахилгааны мантаж, 19% сантехникийн шугам хоолой болон анги танхимын халаагуур, 14% цонх, 12% нь хаалга, 11% шат, 22% үүд, коридор, 18% ариун цэврийн байгууламж, 16% цайны газарт засвар үйлчилгээг хийж, нийт 654 сургуулийн орчинг аюулгүй загвар болгож, 305 дотуур байр стандартын дагуу камержуулалт хийсэн. Мөн нийслэлийн ерөнхий боловсролын 16 сургуулийн орчинд нийслэлийн төсвийн 800 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сургуулийн орчин дахь гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, хурд сааруулагчийг байрлуулсан.	
35	3.2.8.Сурагчдыг эх хэлээрээ алдаагүй зөв бичих, ярих, илтгэх, сэтгэх хэрэглээний бүрэн ур чадвартай болгох хэрэгцээнд нийцүүлэн монгол хэлний сургалтын цогц шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	1. Монгол хэл, уран зохиолын хичээлийн агуулга, хөтөлбөр, сурах бичиг болон сургалтын хэрэгжилтэд үнэлгээ хийх	2016 - 2017		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/133 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, сурах бичигт үндэсний уламжлал, ёс заншил, соёлыг сурагчдад өвлүүлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага хангаж буй эсэх, хэл найруулга, зөв бичих дүрмийн шаардлагыг хангаж буй эсэх, түүхийн үнэн бодит байдлыг хангаж буй эсэхэд хөндлөнгийн үнэлгээ хийж дүгнэлт гаргалаа. Мөн МУБИС, Боловсролын хүрээлэнгээс монгол хэл, бичиг, уран зохиолын сургалтын цөм хөтөлбөрт цогц үнэлгээ хийж, дүгнэлт гаргасан. Эдгээр үнэлгээгээр монгол хэл, бичиг, уран зохиолын хичээлийн агуулга, арга зүйг боловсронгуй болгох шаардлагатай гэж дүгнэлээ. 2018 онд Боловсролын Хүрээлэнтэй хамтран Бага боловсролын Монгол хэлний цөм хөтөлбөр болон Монгол хэлний сурах бичигт үнэлгээ хийж, дүгнэлт гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээгээр Ерөнхий боловсролын сургуулийн бага боловсролын Монгол	100%

					хэлний цөм хөтөлбөрийн агуулгыг нарийвчлан авч үзэхэд хэл зүйн чиглэл голлосон, агуулгын залгамж холбоо, анги хоорондын агуулгын гүнзгийрлийг эргэж харах шаардлагатай байна. 2019 онд "Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйл" сэдэвт судалгааг нийт 21 ерөнхий боловсролын сургуулийг хамруулан хийлээ. Тус судалгаагаар монгол хэл, уран зохиолын хичээлийн агуулга, хөтөлбөр, сурах бичиг болон сургалтын хэрэгжилт, түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг тодорхойллоо. Монголын багш нарын "Бага, дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр" үндэсний 3 удаагийн хэлэлцүүлэгт оролцсон нийт 875 багш, мэргэжилтнүүдээр монгол хэлний цөм хөтөлбөрийг хэлэлцүүлж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойллоо.	
36	2. Монгол хэл, бичгийн сургалтын чанарыг сайжруулах цогц бодлогыг боловсруулан баталж, хэрэгжүүлэх	2016 - 2017		2019 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай" 2019 оны А/491 дүгээр тушаалаар 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн 10-12 дугаар ангийн "Монгол бичиг" хичээлийн цагийг тус бүр 35 цагаар нэмэгдүүлж, нэг ангид нийт 70 цагаар судлах эрх зүйн орчныг бүрдүүллээ. Бага, дунд, ахлах ангийн суралцагчдын судалж байсан монгол хэл, уран зохиол, монгол бичгийн сургалтын хөтөлбөрийг засан сайжруулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/492 дугаар "Хөтөлбөр батлах тухай" тушаалаар баталлаа. Сайжруулсан сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчид судалж эхэллээ. Мөн 1-12 дугаар ангид монгол хэл, бичиг, уран зохиолын хичээл зааж буй бүх багш нарт зориулсан "Сайжруулсан сургалтын хөтөлбөрийн арга зүй" сэдэвт сургалтыг улс орон даяар 2019 оны 8 сард зохион байгуулж, 1-12 дугаар	100%	

					ангид монгол хэл, бичиг, уран зохиолын хичээл зааж буй бүх багш нарт зориулан сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зөвлөмж бичиж, хэвлэн түгээлээ.	
37	3.2.9.Боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянан сайжруулж үйлчилгээний чанар, үр дүнг эцэг, эх, суралцагчдын оролцоотой үнэлэх боломжтой болгоно.	1. Бүх шатны боловсролын түвшин, чиглэл тус бүрээр үнэлгээний систем, шалгуур, аргачлалыг хянаж, сайжруулах	2016 - 2017		Бага, дунд боловсролын чанарыг үнэлэх судалгааг 2019 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Энэхүү судалгаа нь бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг оновчтой боловсруулсан даалгавраар үнэлэх, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, тэдгээрийн хоорондын хамаарлыг тогтооход чиглэсэн. Энэ удаагийн үнэлгээнд III, X ангийн сурагчдын 12 хувь, IX ангийн сурагчдыг 100 хувийг хамруулж, шалгуулагчид 4 хичээлийн агуулгаар даалгавар гүйцэтгэн үр дүнг гаргалаа. Судалгааны үр дүнгээр IX ангийн сурагчдын шалгалтын дундаж гүйцэтгэл 37.1 хувь (математик 34.8%, монгол хэл 50.5%, физик 26.1%, англи хэл 26.3%)-тай дүгнэгдсэн бол III анги 49.9%, X анги 31.9%-тай гарсан байна. Суурь боловсролын чанарын үнэлгээний судалгааны үр дүнгээр тэргүүлэх амжилт үзүүлсэн ерөнхий боловсролын 40 сургуулийг тодруулж батламж олгов. Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмын төслийг боловсруулж, журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлав.	100%
38		2. Боловсролын үйлчилгээний үр дүнг хүүхэд, багш, эцэг эх, сурагчдын оролцоотой үнэлэх	2017 - 2020		Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлав. Энэхүү журмын үзэл баримтлал нь байгууллагын тасралтгүй хөгжлийг хангах, үйл ажиллагааны чанар, үр дүнгээ байгууллага нотолгоонд суурилан багш, ажилтан, суралцагч, эцэг	100%

		боломжтой болгох			эх, асран хамгаалагчийн оролцоотой өөрөө үнэлж, бодит байдлаа мэдэх, хариу арга хэмжээ авах, өөрийн үнэлгээний дүн, дүгнэлт бодитой эсэхийг хөндлөнгийн байгууллага баталгаажуулж, цаашид сурах, сургах үйл ажиллагаанд үзүүлэх дэмжлэгийг тодорхойлох, үнэлгээний үр дүнг бусадтай харьцуулах, эрэмбэлэн жагсаах шинж агуулахгүй, үнэлгээ нь тухайн байгууллагын үйл ажиллагааны ахиц, дэвшлийг үнэлэхэд чиглэгдэв.	
39		3. Боловсролын үйлчилгээний үр дүнг сургууль, аймаг, нийслэл, улсын хэмжээнд үнэлдэг тогтвортой механизм бүрдүүлэх	2018 - 2020		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны А/425 дугаар тушаалд заасны дагуу бага, дунд боловсролын чанарыг улсын хэмжээнд үнэлэх судалгааг 2019 оны 3 дугаар сарын 20-21-ний өдрүүдэд зохион байгуулж ажиллалаа. Энэхүү судалгаа нь бага, суурь, бүрэн дунд боловсролын чанарыг оновчтой боловсруулсан даалгавраар үнэлэх, боловсролын чанарт нөлөөлж буй хүчин зүйлсийг илрүүлж, тэдгээрийн хоорондын хамаарлыг тогтооход чиглэсэн. Энэ удаагийн үнэлгээнд III, X ангийн сурагчдын 12 хувь, IX ангийн сурагчдыг 100 хувийг хамруулж, шалгуулагчид 4 хичээлийн агуулгаар даалгавар гүйцэтгэн үр дүнг гаргалаа. Судалгааны үр дүнгээр IX ангийн сурагчдын шалгалтын дундаж гүйцэтгэл 37.1 хувь (математик 34.8%, монгол хэл 50.5%, физик 26.1%, англи хэл 26.3%)-тай дүгнэгдсэн бол III анги 49.9%, X анги 31.9%-тай гарсан байна. Суурь боловсролын чанарын үнэлгээний судалгааны үр дүнгээр тэргүүлэх амжилт үзүүлсэн ерөнхий боловсролын 40 сургуулийг тодруулж батламж олгов. Мөн боловсролын үйлчилгээний нийтлэг, тогтвортой механизм бүрдүүлэх ажлын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааг үнэлэх журмыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/803 дугаар тушаалаар батлав.	100%

					Сургуулийн үйл ажиллагааг 5 чиглэлийн 12 үзүүлэлтэд хамаарах 72 шалгуураар үнэлэхээр боллоо.	
40		4. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний судалгаанд хамрагддаг болох	2017 - 2020		Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага (OECD)-аас хариуцан 3 жил тутамд зохион байгуулдаг PISA (Programme for International Student Assessment) олон улсын судалгааг зохион байгуулахад шаардагдах зардлыг Дэлхийн банкны “Бага боловсролын чанарын шинэчлэл” төслөөс санхүүжүүлэхээр талууд тохиролцож, гүйцэтгэгчээр Боловсролын үнэлгээний төвийг сонгон гэрээ байгууллаа. Гэрээний дагуу судалгаа зохион байгуулах хүрээнд хийх ажлын төлөвлөлтийг бэлтгэл ажил, туршилтын судалгаа, үндсэн судалгаа гэсэн 3 багцад хамруулан хийж, санхүүжүүлэгч талын зөвшөөрлийг авсан. Эдийн засгийн хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагаас судалгаанд оролцох улс орнуудаас 2019 онд цуглуулах нийт 25 асуулга, мэдээллийг Боловсролын үнэлгээний төв боловсруулсныг хянаж зохион байгуулагч талд хүргүүллээ.	100%
41	3.2.10.Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулга, чанарыг дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, өөрийн орны түүх, соёл, өв уламжлалд тулгуурлан шинэчилнэ.	1. Сургалтын стандарт, хөтөлбөр, сурах бичгийн агуулгад үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	2016 - 2017		Монголын багш нарын 7-р их хурал, зөвлөгөөн, үндэсний удаа дараагийн хэлэлцүүлэгт оролцогчдын санал болон Боловсролын хүрээлэнгээс хийсэн үндэсний хэмжээний судалгааны дүгнэлтэд тулгуурлан бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын бүх цөм хөтөлбөрийг сайжруулан боловсронгуй болгож, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар баталлаа. Тус сайжруулсан сургалтын хөтөлбөрөөр 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчид хичээллэж байна. Сайжруулсан сургалтын	100%

					хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2019 оны 8 сард аймаг, дүүрэг бүрд зохион байгуулж ерөнхий боловсролын сургуулийн багш нарыг 100 хувь хамрууллаа. Энэ үеэр сайжруулсан сургалтын хөтөлбөр бүрээр 1-12 дугаар ангийн сурагчдын судалж буй бүх хичээлийн хүрээнд багш нарт зориулсан арга зүйн зөвлөмж боловсруулж, хэвлэн түгээлээ.	
42		2. Сурах бичгийн агуулгыг сайжруулж хэвлүүлэх	2017 - 2020		Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн сайжруулсантай холбоотойгоор бүх ангийн сурах бичгийн агуулгад сайжруулалт хийсэн болно. Энэ хүрээнд I-XII ангийн 146 нэрийн нийт 1,125,020 ширхэг сурах бичиг нөхөн хангалтаар, 23 нэрийн сурах бичиг шинэчилж зохион 576,547 ширхэг хэвлэн нийлүүллээ. Эдгээрээс “Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сурах бичиг төлбөртэй ашиглуулах үйлчилгээний журам”-ын дагуу ерөнхий боловсролын сургуулийн VI-XII ангийн 178,719 сурагчид төлбөртэй ашиглуулахаар VI, VII ангийн 29 нэрийн 1,042,000 ширхэг, VIII, IX ангийн 34 нэрийн 946,000 ширхэг, X-XII ангийн 35 нэрийн 747,030 ширхэг сурах бичгийг сургуулийн номын санд тус тус нийлүүллээ. Үүний үр дүнд ерөнхий боловсролын сургуулийн сурагчид сурах бичгээр бүрэн хангагдаад байна.	100%
43		3. Одоо мөрдөж байгаа 5418:2008 бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлагыг олон улсын нийтлэг	2016 - 2017		Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн чанар, стандартын талаар сүүлийн жилүүдэд хийгдсэн зөвлөх үйлчилгээний тайлан, санал зөвлөмжид үндэслэн “Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавигдах шаардлага MNS 5418:2008” стандартыг шинэчлэх ажил хийгдэж байна. Шинээр боловсруулж байгаа стандартын төсөлд сурах бичгийн агуулга, арга зүй, хэл,	70%

		жишигт үндэслэн шинэчлэх			найруулга, дизайн болон сурах бичгийн хэмжээ, жин, эдэлгээний чанарт тавигдах шаардлагыг илүү тодорхой болгож олон улсын жишигт нийцүүлэхээр тусгаж байна. Стандартын төслийг 2020 онд Стандарт, хэмжил зүйн техникийн хороогоор хэлэлцүүлж, Стандартчиллын үндэсний зөвлөлөөр батлуулна.	
44		4. Цахим сурах бичиг, хэрэглэгдэхүүн, онлайн хичээлд тавих шаардлага боловсруулж мөрдөх	2016 - 2017		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/696 дугаар тушаалын хавсралтаар Цэцэрлэг, ЕБС-ийн Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, загвар боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн батлагдсан. Энэхүү тушаалын хэрэгжилтийн хүрээнд Цэцэрлэг, ЕБС-ийн Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан зөвлөмж, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, загвар боловсруулж, туршина. Азийн хөгжлийн банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын ном, сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоомын хэрэглээний өнөөгийн байдал, хэрэгцээний талаарх түүвэр судалгаа хийх; сургалтын хэрэглэгдэхүүний багцад тулгуурлан сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүний эх бэлтгэл, биет хэрэглэгдэхүүнд тавигдах шаардлагыг боловсруулж, хэлэлцүүлж байна. Мөн интернетэд суурилсан, онлайн сургалтыг хөгжүүлэх нийгмийн захиалга хэрэгцээ, шаардлагатай холбогдуулан гадаад улс орнууд цахим сурах бичиг, хэрэглэгдэхүүн, онлайн хичээлийг ашиглах асуудлыг хэрхэн шийдсэн болон манай улсын бага, дунд боловсролын түвшинд ямар хүрээнд хэрэглэх асуудлыг судалж байна. Цахим	100%

					сурах бичигт тавигдах техникийн болон арга зүйн шаардлагыг боловсрууллаа. Энэ шаардлага нь “Сургалтын цахим объектын ерөнхий болон тусгай шаардлага”, “Сургалтын цахим объектын дидактикийн шаардлага” болон агуулгын форматын стандарт /Веб агуулга – мэдээлэл, хэв загвар, хэлбэржүүлэлт, Зураг, Аудио, Видео, Текстэн баримт бичиг (засвар хийх боломжтой, боломжгүй), Цахим ном, Хэрэглэгчийн талын скрипт хэл/ гэсэн хэсэгтэй. Уг шаардлагыг хилийн чанадад суугаа монгол иргэдийн хүүхдүүдэд зориулсан “Монгол хэл, соёлын цахим сурах бичиг”-ийг бэлтгэн нийлүүлэхэд ашигласан.	
45		5. Программ хангамжийн кодчиллын хичээлийн агуулгыг боловсруулж, бүрэн дунд боловсролын хөтөлбөрт тусгах	2016 - 2020		2019 онд мэдээлэл зүйн сургалтын цөм хөтөлбөрийг засан сайжруулж код бичих агуулгыг тусган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар баталлаа. Сайжруулсан мэдээлэл зүйн сургалтын хөтөлбөрийг 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчид судалж эхэллээ.	Үнэлэх боломжгүй
46	3.2.11.Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт эх орныхоо түүх, соёлыг судлах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийг оруулна.	1. Хүүхдийн бие бялдрын хөгжлийн үзүүлэлтийг шинжлэх ухааны үндэстэй тогтоож хөгжүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн болон хичээлээс гадуурх үйл ажиллагааны	2016 - 2017		БСШУС-ын сайд, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 01 дугаар сарын 02-ны өдрийн А/004/А/01 хамтарсан тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг "Эрүүл мэнд"-ийн сургалтын хөтөлбөр боловсруулж, БСШУС-ын сайдын 2018 оны А/467 дугаар тушаалаар батлуулан ерөнхий боловсролын нийт сургуулийн 4-12 дугаар ангид 2018 оны 9 сараас хэрэгжүүлж эхэллээ. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрийн агуулгыг нийгмийн хэрэгцээ; суралцагчдад тулгамдаж буй асуудалд суурилсан дараах агуулгаар боловсрууллаа. Үүнд: 1. Хувийн ариун цэвэр, орчны эрүүл ахуй 2. Хооллолт, хөдөлгөөн 3. Сэтгэцийн эрүүл мэнд 4.	100%

		арга замыг тодорхойлон хэрэгжүүлэх				Хорт зуршил 5. Бэлгийн ба нөхөн үржихүйн эрүүл мэнд 6. Осол гэмтэл зэрэг болно. Эрүүл мэндийн сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх багш нарт зориулсан сургалт зохион байгуулж, сургалтын хөтөлбөр, зөвлөмжийг 18000 ш хэвлэж, түгээлээ. Боловсролын хүрээлэнгээс "Монгол хүүхдийн хөгжлийн судалгаа"-ны ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдийн 2 дахь шатны судалгаа болон хүүхдийн цогц чадамжийн судалгааг хийж гүйцэтгэлээ.	
47		2. Эрүүл мэнд, гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах	2017 - 2018			2019 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын "Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай" 2019 оны А/390 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчдын судлах "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийг баталлаа. Дунд, ахлах ангийн "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрт "Гэр бүлийн харилцаа", "Монголчуудын удам судар", "Ураг удмаа танин мэдэхийн ач холбогдол", "Ирээдүйн эцэг эхийн гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлага", "Гэр бүлийн гишүүдийг асарч, энэрэх", "Гэр бүлийн гишүүдэд туслах, тэднийг хүндлэх, ачийг хариулахын ач холбогдол" зэрэг сэдвүүд шинээр нэмэгдэж сурагчид судалж эхлээд байна. Мөн сургууль, багш нар нь "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийн дагуу эцэг эхчүүд, асран хамгаалагчдад зориулсан сургалт, зөвлөгөө, харилцан санал, туршлага солилцох ярилцлага, нэгдмэл ойлголт хандлага тогтоох арга хэмжээг хариуцан гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүллээ.	100%
48	3.2.12.Хүүхдийг амьдрах ухаанд сургаж, харилцааны зөв хэвшилтэй,	1. Хүүхдийн амьдрах ухааны чадварыг хөгжүүлэх	2016 - 2017			"Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг 2019-2020 хичээлийн жилд ерөнхий боловсролын бүх сургууль сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна.	100%

	бусдыг хүндлэх, хариуцлагатай, итгэл даах чадвартай болгон төлөвшүүлэх цогц бодлого хэрэгжүүлнэ.	агуулгын хүрээг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, зохион байгуулалтыг хангах					
49	3.2.13.Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх, үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг нэвтрүүлж, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлнэ.	1. Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйланг хичээллүүлэх үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлалыг боловсруулж, санхүүжүүлэх	2016 - 2017			Ерөнхий боловсролын сургуульд секц, дугуйлан зохион байгуулах, санхүүжүүлэх аргачлалыг боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн А/659 дүгээр тушаалаар баталлаа. Сургуульд секц, дугуйланг суралцагчийн хэрэгцээ, сонирхол, багшлах боловсон хүчний нөөц, ур чадвар, орон нутгийн онцлогт тохируулан сургууль, мэргэжлийн байгууллагад түшиглэж, эцэг эх, олон нийтийн оролцоонд тулгуурлан зохион байгуулах зохицуулалтыг хийлээ. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/192 дугаар тушаалаар бага ангийн хүүхдийг эрэмбэлж ялгаа үүсгэсэн, суралцах хүсэл эрмэлзлэлийг бууруулсан, сургалтын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан олимпиад, уралдаан зохион байгуулахгүй байх, хүүхдийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх, ахмад үе, уламжлалаа хүндэтгэх, байгаль орчноо хамгаалах, бие бялдрын хөгжлийг хангахад чиглэсэн багийн уралдаан, тэмцээн үйл ажиллагааг дэмжихийг нийт захирлуудад үүрэг болголоо.	100%
50		2. Хичээл, сургуулиас гадуурх сонгон, секц, дугуйлангийн	2017 - 2020			Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 532 дотуур байр, 820 ерөнхий боловсролын сургуульд давхардсан тоогоор нийт 4008 секц, дугуйлан хичээллэж байна. Суралцагчийн авьяас чадварыг нээн хөгжүүлэх болон сургалтын орчныг	100%

		тоног, төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах			бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Үүнд: 1. 2019 онд шинээр ашиглалтанд орсон, өндөр ачаалалтай үйл ажиллагаа явуулж байгаа нийт 217 ерөнхий боловсролын сургуульд 43791 ширхэг 4,165.5 сая төгрөгийн анги танхим, номын сангийн тавилга, тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу олгосон. 2. 2019 онд 127 дотуур байранд хүүхэд хөгжлийн төв шинээр нээсэн. 3. 2019 оны жилийн эцсийн байдлаар шинээр ашиглалтад орсон болон өндөр ачаалалтай үйл ажиллагаа явуулж байгаа 29 сургуульд 819 ширхэг 199.3 сая төгрөгийн спортын тоног төхөөрөмж, 20 сургуульд 498 ширхэг 171.0 төгрөгийн хөгжмийн тоног төхөөрөмжийг тус тус олгож, сургууль тус бүрд сонгон, секц, дугуйлангууд хичээллэх боломж бүрдсэн.	
51	3.2.14.Ерөнхий боловсролын сургуульд сурагчдын амьдрах ур ухааныг хөгжүүлэх, аюулгүй байдлын сургалтыг нэвтрүүлж, хүүхдийг эрсдэлгүй, осол эндэлгүй, эрүүл, аюулгүй амьдрах чадварт сургана.	2. Аюулгүй байдлын сургалтын агуулга, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж, зохион байгуулах	2016 - 2017		“Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг СӨБ болон ЕБ-ын түвшинд боловсруулан тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшийн гарын авлагын хамт хэвлүүлж улсын хэмжээний нийт сургууль, цэцэрлэгүүдэд хүргэсэн. Тус хөтөлбөрийн агуулга нь газар хөдлөлт, гамшиг осол, халдварт өвчин, байгаль цаг уурын онцгой нөхцөлд өөрийгөө хамгаалах бусдад туслах, эрсдэлийг бууруулах чиглэлээр тухайн насанд тохирсон мэдлэг чадварыг хүүхдэд эзэмшүүлэхэд чиглэсэн. Энэхүү хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор БСШУС-ын сайд болон Монгол улсын Шадар сайдын хамтарсан тушаалыг батлан орон нутагт Төрийн захиргааны байгууллага болон сургууль цэцэрлэг, мэргэжлийн байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, орчин нөхцөлийг бий болгох чиглэлээр ажиллаж байна. “Хөдөлгөөн эрүүл мэнд” суралцахуйн чиглэлийн агуулгад 2 насанд “Насанд хүрэгчдийн болгоомжлуулсан зарим үйлдлийг хийхгүй байх, 2-4	100%

					<p>насанд өөрийн эрүүл мэнд аюулгүй байдлаа хамгаалах үйлдлүүд хийх, 5 насанд гэмтэж болзошгүй үйлдлээс зайлсхийж биеэ хамгаалах мэдлэг чадвар олгох агуулгыг сургалтын төлөвлөлтөд тусган хэрэгжүүлж байна. Түүнчлэн “Аюулгүй амьдрах ухаан” сургалтын хөтөлбөрийг 2019-2020 хичээлийн жилд ерөнхий боловсролын бүх сургууль сургалтын нэгдсэн хөтөлбөрийн дагуу 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна.</p>	
52		<p>3. Ердийн хэв шинжтэй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах нийгэм, сэтгэлзүй, боловсрол, сургалтын таатай орчныг бүрдүүлэх талаар холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэх</p>	2017 - 2018		<p>Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны (MNS 6558:2015) стандартын 6.1.2-т Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай нь тэдний онцлогт тохирсон байхаар тусгасан болно. Тус стандартын өөрийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулж, асуулгыг Боловсролын удирдлагын мэдээллийн системд байршуулж, 1,439 цэцэрлэгээс сургалтын орчны өөрийн үнэлгээг нэгтгэх ажил хийгдэж байна.</p> <p>"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам"-ыг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны С/292 дугаар тушаалаар баталлаа. Энэхүү журмын хэрэгжилтийг хангах хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг оношлох үнэлгээг хийж, тухайн хүүхдийн хөгжлийг дэмжсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах арга зүйн сургалтыг ЕБС-ийн 80, насан туршийн боловсролын 210 багшийг хамруулан зохион байгуулснаар ерөнхий боловсролын 60 сургууль, албан бус насан туршийн боловсролын аймаг, дүүргийн 30 төвд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах хүний нөөцийн чадавх бүрдээд байна.</p>	100%

53	3.2.15.Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд хүүхдийг хүнлэг, эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, хүмүүжил олгох агуулгыг тусган хэрэгжүүлнэ.	1. Сургалтын агуулга, хөтөлбөр, сурах бичиг, хичээлээс гадуурх үйл ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээ хийж, хүүхдийг эх оронч, үндэсний ухамсар, бахархалтай иргэн болж төлөвшүүлэх үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлж хэрэгжүүлэх	2016 - 2017			Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтэд Боловсролын хүрээлэнгээс 2018-2019 онд хийсэн судалгаа, 2019 оны 3 дугаар сард БСШУС-ын яамнаас зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгийн үр дүнд тус тус үндэслэн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг сайжруулах асуудлыг тодорхойлсон. Дээрх дүгнэлтэд тулгуурлан сайжруулалтыг хийж БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/494 дүгээр тушаалаар баталсан. Тус хөтөлбөрийн “Байгаль, нийгмийн орчин” суралцахуйн чиглэлээр бага насны хүүхдэд өөрийн амьдардаг нутаг орны онцлог, хүмүүсийн ажил хөдөлмөр, өөрийгөө ямар үндэстэн болох, бусад үндэснээс юугаараа ялгаатайг мэдэж Монгол үндэстний онцлог, заншлыг эзэмшиж түүгээр бахархах үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий агуулгыг 2-5 насанд эзэмшүүлэхээр нас тус бүрээр тодорхойлон хэрэгжүүлж байна. Түүнчлэн Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны А/371-А787 дугаар хамтарсан тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад эх оронч үзэл, хүмүүжил олгох, эх орныхоо тусгаар тогтнол, түүх, хэл соёлоороо бахархах учир холбогдлыг ойлгуулан таниулах сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг хамтран баталлаа.	100%
54	3.2.16.Сурагчдад эх орноо хайрлах, хүрээлэн байгаа орчноо хамгаалах мэдлэг, хүмүүжил	1. Хүүхдийн хүмүүжил, зан суртахууны төлөвшлийн асуудлыг сургууль	2016 - 2017			Сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөр, хөтөлбөрийн хэрэгжилтэд Боловсролын хүрээлэнгээс 2018-2019 онд хийсэн судалгаа, 2019 оны 3 дугаар сард БСШУС-ын яамнаас зохион байгуулсан үндэсний хэлэлцүүлгийн үр дүнд тус тус	100%

	олгоно.	дээр хэрэгжүүлэх ажлын чиглэл, шаардлагыг хууль тогтоомжид тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах			үндэслэн сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөрийг сайжруулах асуудлыг тодорхойлсон. Дээрх дүгнэлтэд тулгуурлан сайжруулалтыг хийж БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/494 дүгээр тушаалаар баталсан. Тус хөтөлбөрийн “Байгаль, нийгмийн орчин” суралцахуйн чиглэлээр бага насны хүүхдэд өөрийн амьдардаг нутаг орны онцлог, хүмүүсийн ажил хөдөлмөр, өөрийгөө ямар үндэстэн болох, бусад үндэснээс юугаараа ялгаатайг мэдэж Монгол үндэстний онцлог, заншлыг эзэмшиж түүгээр бахархах үзлийг төлөвшүүлэх зорилго бүхий агуулгыг 2-5 насанд эзэмшүүлэхээр нас тус бүрээр тодорхойлон хэрэгжүүлж байна. Түүнчлэн Батлан хамгаалахын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны А/371-А787 дугаар хамтарсан тушаалаар “Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад эх оронч үзэл, хүмүүжил олгох, эх орныхоо тусгаар тогтнол, түүх, хэл соёлоороо бахархах учир холбогдлыг ойлгуулан таниулах сурталчилгааны ажлыг хамтран зохион байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүн”-ийг хамтран баталлаа.	
55	3.2.17.Ерөнхий боловсролын сургуулийн сурагч ажил, мэргэжлээ сонгох, суралцах сургуулиа сонгох, элсэн суралцах бэлтгэлийг хангах талаар ажил мэргэжлийн зөвлөгөө	1. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох талаар шийдвэр гаргаж, холбогдох	2017 - 2018		Ерөнхий боловсролын сургуулийн 8-9, 10-12 дугаар ангийн нийт суралцагчдад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйл ажиллагаа хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан “Ажил мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх багшийн чадамж” хөтөлбөр боловсруулсан. Өмнөх хичээлийн жилд нийт ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад ажил мэргэжлийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааны хөтөлбөр, сургалтын модуль, сургалтын хэрэглэгдэхүүн, “Ажил мэргэжлийн чиг баримжаа”	100%

	үзүүлдэг үйлчилгээг бий болгоно.	ажилтны ажлын байрны тодорхойлолтод өөрчлөлт оруулах				дасгал ажлын ном, “Ажил мэргэжлээ сонгох нь” сорилын номыг шинээр боловсруулж, түгээн хэрэгжүүлсэн. Мөн сургууль дээр ажил мэргэжлийн сургалт, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулах сургуулийн удирдлагын гарын авлага, эцэг эхийг хүүхдээ ажил мэргэжлээ зөв сонгоход идэвхтэй, үр дүнтэй оролцох, хүүхдэдээ хэрхэн туслах зөвлөмжийг тус тус түгээсэн. БСШУС-ын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/692 тоот тушаалаар Ерөнхий боловсролын сургуулийн захирлын албан тушаалд тавих нийтлэг шаардлага, үндсэн чиг үүрэг, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлахдаа суралцагчийн хичээлээс гадуурх үйл ажиллагаа, хүүхэд хамгаалал, төлөвшилтийн чиглэлээрх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах талаар тодорхой заалтуудыг оруулсан.	
56		2. Ажил мэргэжлийн зөвлөгөө, үйлчилгээг зохион байгуулах ажлын агуулга, хөтөлбөрийг боловсруулж мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах	2017 - 2018		БСШУС-ын сайдын 2019 оны "Хөтөлбөр батлах тухай" А/756 дугаар тушаалаар "Насан туршийн боловсрол" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэллээ. Хөтөлбөрт Насан туршийн боловсролын салбарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өсвөр үеийнхэнд хөдөлмөр, мэргэжлийн чиг баримжаа олгох Зөвлөгөө-мэдээллийн төвийн 21 аймаг, 9 дүүргийн Насан туршийн төвийг түшиглэн байгуулах төслийг Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлэхээр тусгасан. Түүнчлэн Бүгд Найрамдах Франц Улсын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд ШУТИС, МУИС-д "Карьер хөгжлийн төв"-ийг 2019 оны 12 сард байгуулж, үйл ажиллагааг эхлүүлсэн. Монголын ажил олгогч 24 байгууллагатай хамтран “Хүний нөөцийг чадваржуулах сургалт, хэлэлцүүлэг”, “Тохирох ажилд нь зөв хүнийг-2019” төслийг хэрэгжүүлж МУИС-ийн 283 оюутан, ШУТИС-	100%	

					ийн 250 оюутан тустус хамрагдсан байна. Эдгээр сургалтаар оюутнуудад өөрийн зан чанар, хандлага, ур чадвараа таньж мэдэх арга, товч намтар буюу өөрийн танилцуулга бичих арга зүй, ажилд орох өргөдөл, хувийн карьер төлөвлөлтөө хэрхэн хийх талаар мэдээлэл өгсөн байна. "Миний боловсрол-Миний ирээдүй" сэдэвт их, дээд сургуулийн 800 гаруй оюутны чуулга уулзалтыг 2019 оны 11 дүгээр сард зохион байгуулсан.	
57		3. Ажил, мэргэжлийн зөвлөгөө өгөх онлайн үйлчилгээг бий болгох талаар холбогдох мэргэжлийн болон ТББ-уудтай хамтран ажиллах	2017 - 2018		МУИС-ийн төгсөгчдийн ажлын байран дахь хандлага, ур чадварыг тодорхойлж тестийн үнэлгээ /хариу/-тай профайл үүсгэж, сургалт зөвлөгөө өгч, icageer.mn хөдөлмөр зуучлалын сайтад 587 суралцагчийн мэдээллийг байршуулсан байна. Мөн 47 байгууллагын нээлттэй ажлын байр, түүнд тавигдах шаардлагууд, байгууллагын соёлын талаарх танилцуулга, үзэсгэлэнг зохион байгуулсан байна.	70%
58	3.2.18.Төрийн өмчит их, дээд сургууль, коллежийг хувьчлахгүй. Дээд боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төрийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх,	2. Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөр батлан хэрэгжүүлэх	2017 - 2020		Үр дүнд суурилсан боловсролыг хөгжүүлэх бодлого /дээд боловсрол/-ыг БСШУС-ын сайдын 2018 оны А/533 дугаар тушаалаар баталсан. Бодлогын баримт бичигт 4 зорилт дэвшүүлсэн. 1.Үр дүнд суурилсан боловсролын арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр боловсруулах үйл ажиллагааг чанаржуулах; 2.Оюутан төвтэй суралцахуйн үйлийг дэмжсэн сургалтын орчин, нөөц бүрдүүлэх, цахим сургалтын технологийн хэрэглээг нэмэгдүүлэх; 3.Их, дээд сургууль, коллежийн профессор, багш нарын мэргэжил, заах арга зүйн чадамжийг дээшлүүлэх; 4.Сургалтын чанар, үр дүнг хэмжих үнэлгээ, чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх зэрэг болно. Энэхүү бодлого (БСШУС-ын сайдын 2018 оны А/533 тушаал)-ын 4.1.6-д заасны дагуу дээд	100%

	стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.				боловсролын сургалтын хөтөлбөрийн боловсруулалтад үнэлгээ хийж, санал, дүгнэлт боловсруулах ажлын хэсгийг БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/405 дугаар тушаалаар байгуулан 60 их, дээд сургуулийн 536 бакалаврын хөтөлбөрт үнэлгээ хийж, сургууль бүрд чиглэл, зөвлөмж болгон өгсөн. Ажлын хэсгийн 9 багийн тайланд хөтөлбөрийн ерөнхий 10 чиглэлээр дүн шинжилгээ хийн гарсан үр дүнг "CDIO-2019" эрдэм шинжилгээний хурлаар 2019 оны 12 дугаар сарын 05-ны өдөр хэлэлцүүлсэн.	
59	3. "Судалгаанд суурилсан их сургууль" үндэсний хөтөлбөр батлан, хэрэгжүүлэх	2017 - 2020			Үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын 2018 оны 9 дүгээр сарын 05-ны өдрийн 282 дугаар тогтоолоор батлуулсан. Их сургуулиуд үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд МУИС нь "МУИС-ийн судалгааны их сургуулийн хэрэгжүүлэх төлөвлөгөө 2019-2024" төслийг боловсруулсан.	100%
60	4. Дээд боловсролын салбарын хүний нөөцийг тасралтгүй хөгжүүлэх	2017 - 2020			АНУ-ын Харвардын Анагаах ухааны сургуулийн багш нарын чадавх бэхжүүлэх Т2С (Training to Teacher) сургалтын хөтөлбөрийг Монгол Улсад хэрэгжүүлэн дахин үргэлжлүүлэх гэрээнд АНУ-ын Харвардын их сургуулийн захирал болон БСШУСЯ-ны ТНБДарга гарын үсэг зурсан. Улмаар БСШУСЯ-ны ТНБД-ын 2019 оны 11 дүгээр сарын 05-ны А/251 дүгээр тушаалаар тус төсөлд хамрагдах багш-эмчийн сонгон шалгарууллатыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдан сонгон шалгалгаруулалтыг хийж 28 байгууллагын 101-н Эмч-Багш нарыг шалгаруулсан. - БСШУС-ын 2019 оны 11 дүгээр сарын 18-ны А/754 дүгээр тушаалаар Дээд боловсролын сургалтын байгууллагын Багшийн хөгжлийг дэмжих төвийг байгуулах, үйл ажиллагааг жигдрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, тус төвийн үйл	100%

					ажиллагаанд шаардлагатай төсөв 596.500.0 төгрөгийг батлуулан сургалт арга зүйг зохион байгуулах, судалгааг шинжилгээг эхлүүлэн ажиллаж байна. - 2019 оны 6-12 сард CDIO-н 3 удаагийн сургалтаар нийт 413 багшийг чадавхижуулж үүнд 53,8 сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн. - 2019 оны 8, 11, 12 сард болсон магадлан итгэмжлэлийн 3 удаагийн сургалтаар нийт 433 шинжээчийн мэргэжил ур чадварыг дээшлүүлэн үүнд 91,8 сая төгрөг зарцуулсан. - Зайн танхимын болон онлайн цуврал 4 сургалт 6-12 сард зохион байгуулагдсан бөгөөд үүнд МУБИС, Архангай, Завхан, Дорнод, Ховд аймгийн дээд боловсролын сургалтын байгууллагын нийт 1384 багш нар хамрагдсан. Дээрх 4 сургалтыг 150,6 сая төгрөгөөр санхүүжүүлэн удирдлага, багш, албан хаагчдад тус тус зохион байгуулан сургагч багш нарыг хамрууллаа.	
61		5. Дээд боловсролын байгууллага, хөтөлбөрийг олон улсын магадлан итгэмжлэлд үе шаттайгаар хамруулахад дэмжлэг үзүүлэх	2017 - 2020		Монгол Улсын боловсролын их сургуулийн Багш байгалийн ухаан (физик, хими, газар зүй, биологи) - ын 4 хөтөлбөр, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Үйлдвэрлэлийн технологийн сургуулийн бакалавр "Нэхмэлийн үйлдвэрлэлийн технологи" - ын 1, магистр "Нэхмэлийн үйлдвэрлэлийн хими, технологи"-ын 2 хөтөлбөр буюу нийт 7 хөтөлбөрийг Германы ASIIN байгууллагаар магадлан итгэмжлүүлсэн.	100%
62	3.2.19.Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах	1. Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх эрдэм шинжилгээ, судалгааны зардлыг үе	2017 - 2020		2019 онд тус салбарын улсын төсвийн санхүүжилт 37 тэрбум 269 сая төгрөгөөр батлагдаж, өмнөх оныхоос 2 тэрбум 645,7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Эрдэм шинжилгээ, судалгааны ажилд Засгийн газраас зарцуулсан санхүүжилтийн Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь 0,18% болж өссөн. Монгол	100%

	санхүүжилтийг нэмэгдүүлнэ.	шаттайгаар нэмэгдүүлэх			Улсын Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдааны 11 дүгээр тэмдэглэлийг хэрэгжүүлэх зорилгоор “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 328 дугаар тогтоолд шинжлэх ухаан, технологийн салбарын санхүүжилтийг төлөвлөлтийн дагуу жил бүрийн улсын төсөвт тусгах; Шинжлэх ухаан, технологийн парк байгуулах ажлыг эрчимжүүлж, шаардагдах хөрөнгийг гадаадын зээл тусламжид хамруулах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах, “Шинжлэх ухаан, технологийн төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” Засгийн газрын 379 дүгээр тогтоолд шинжлэх ухаан, технологи, инновацийн менежментийг боловсронгуй болгох, оюуны өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулахад чиглэсэн тодорхой арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн.	
63	3.2.20.“Боловсролын зээлийн сан” шинээр байгуулж, оюутан, суралцагчид үндэсний тэтгэлэг, зээл, буцалтгүй тусламжийн үйлчилгээг үзүүлэх тогтолцоог ил тод, нээлттэй болгож, хүртээмжийг нэмэгдүүлнэ .	1. “Боловсролын зээлийн сан” шинээр байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжүүлэх	2016 - 2020		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/124 дүгээр тушаалаар баталсан ажлын хэсэг Боловсролын зээлийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгддөг эрх зүйн баримт бичгийн хэрэгжилттэй танилцан судалж, цаашид авах арга хэмжээний санал боловсруулан Засгийн газрын тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулах саналыг яамдаас санал авч бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай Монгол Улсын их хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалыг БСШУССайд, Сангийн сайд, хууль	100%

					зүй, дотоод хэргийн сайд нар хамтран баталалаа.	
64	3.2.21.Өрхийн 3 ба түүнээс дээш хүүхэд нь их, дээд сургуульд зэрэг суралцаж байгаа бол санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.	1. Холбогдох тогтоол, журамд өөрчлөлт оруулж хэрэгжүүлэх	2017 - 2020		2016 оны 10 дугаар сарын 05 -ны өдрийн 111-р тогтоолоор "Нэг өрхийн 3 болон түүнээс дээш хүүхэд дээд боловсролын сургалтын байгууллагад бакалаврын зэргийн боловсрол эзэмшихээр зэрэг суралцаж байгаа тохиолдолд 1 хүүхдийн сургалтын төлбөр олгоно гэж эрх зүйн орчинг бүрдүүлж 2019-2020 оны хичээлийн жил болон 2019 оны санхүүгийн жилийн дүнгээр 298 оюутанд 591 сая төгрөг сургалтын төлбөрт буцалтгүй тусламжаар олгогдоод байна.	100%
65	3.2.22.Үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг олгоно.	1. Үндэсний тэтгэлэг 70200 төгрөгийг сурлагын амжилтыг үндэслэн олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх	2016 - 2020		Засгийн газрын шийдвэрээр зогсоосон.	Үнэлэх боломжгүй
66	3.2.23.Оюутны дотуур байрны хүртээмжийг хоёр дахин нэмэгдүүлнэ.	1. Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын оюутны байрны хүчин чадлыг нэмэгдүүлэх	2017 - 2020		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/654 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг төрийн болон хувийн өмчийн их дээд сургууль, коллежийн харьяаны 53 дотуур байрны үйл ажиллагаанд судалгаа хийж, дүгнэлт гаргасан. 2019 онд Монгол Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн 540 оюутны дотуур байрыг шинээр барих-2.5, АШУҮИС-ын 1200 оюуны дотуур байр сургуулиас бүх санхүүжилт хийгдэж байна. АШУҮИС-ийн шинэ хотхонд 1200 оюутны дотуур байр 2020 онд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Монгол Германы хамтарсан ашигт малтмал технологийн их сургуулийн 540 оюутны	100%

					дотуур байрны ажлыг Нийслэлд шилжүүлсэн. Соёл урлагийн их сургууль оюутны дотуур байрны 3 давхар барилгыг 4 давхар болгон өргөтгөх барилгын ажил дуусаж, Барилга ашиглалтад оруулах Улсын комиссын дүгнэлт 2019 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр гарсан. Өргөтгөлийг сургуулийн төсвөөр хийсэн бөгөөд 771,0 сая төгрөг зарцуулсан.	
67	3.2.24.Оюутнууд харьяалал харгалзахгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болно.	1. Оюутан залуучуудын эрүүл мэндийг дэмжих сарын аяныг жил бүр зохион байгуулах	2017 - 2020		2019 онд "Эрүүл Оюутан-Эерэг хандлага" уриатайгаар Эрүүл мэндийн аянг 10 дугаар сарын 1-нээс 11 дүгээр сарын 25-ны хооронд зохион байгууллаа. Аянд зориулсан цаг үеийг эхлүүлэх үеэр олон нийт, оюутан суралцагчдад зориулсан хэвлэлийн баг хурлыг хүргэж ажилласан. Монгол улсад 2018-2019 оны хичээлийн жилд 94 их дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаагаас нийт 157,625 оюутан суралцаж байгаагийн 92.6 хувь нь нийслэлд, 7.4 хувь нь хөдөө орон нутгийн салбар сургуулиудад суралцаж байгаагийн аяны хүрээнд оюутнуудын 79 хувь нь хамрагджээ.	100%
68	харгалзахгүйгээр эрүүл мэндийн үйлчилгээ авдаг болно.	2. Оюутанд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлэх зохицуулалт хийх	2017 - 2020		Эрүүл мэнд, БСШУСС-ын 2019 оны 1 дүгээр сарын А/87, А/112 дугаар тушаалаар "Оюутан, суралцагчдад үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зарим арга хэмжээний тухай" Эрт илрүүлгийн 6 төрлийн эрүүл мэндийн үзлэгт хамруулах боломжоор ханган 2019 оны эцсийн байдлаар нийт оюутны 90 гаруй хувь нь хамрагдлаа. Эрүүл мэндийн үйлчилгээ, даатгалын талаар мэдээллийг оюутнуудад өгөх талаар сургуулиуд болон АШУҮИС, Монголын оюутны холбоотой хамтран мэдээлэл сурталчилгааны ажлыг БСШУСЯ-ны нээлттэй өдөрлөг, үзэсгэлэн уулзалтад оролцогчдод гарын авлага материал тарааж урьдчилан сэргийлэх үзлэгүүдийг хийж үйлчилсэн болно.	100%

69	3.2.25.Өндөр хөгжилтэй орнуудын их, дээд сургуулиудад бакалавр, магистр, докторын сургалтад элсэгчдийг ил тод, нээлттэй сонгон шалгаруулж, суралцагчдын тоог 2 дахин нэмэгдүүлнэ.	1. Сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод зохион байгуулах арга хэрэгслийг боловсронгуй болгох	2017 - 2020		Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу тухайн орны Элчин сайдын яамдтай хамтран сонгон шалгаруулалтыг ил тод, хөнгөн шуурхай, боловсронгуй болгох зорилгоор доорх арга хэмжээг хэрэгжүүллээ. - Бүртгэлийг 100 хувь онлайн хувилбарт шилжүүллээ. - Бүртгэлийн давхардлыг арилгах зорилгоор БНХАУ, ОХУ, Унгар, Солонгос, Вьетнам, Польш, Турк зэрэг 16 орны элчин сайдын яамтай хамтран, хяналт тавьж ажиллаж байна. ЭСЯ-тай хамтран тэтгэлгийн мэдээллийг олгож байна. - Сонгон шалгаруулалтын мэдээллийг яам, их, дээд сургууль, коллежийн болон олон нийтийн цахим хуудсаар нээлттэй зарлаж, олон улсын боловсролын яармаг, нээлттэй хаалганы өдөрлөгүүдэд мэдээлж ажилласан. БНХАУ, ОХУ, ИБУИНВУ-ын боловсролын яармагуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, оролцсон болно. Цаашид: - Тэтгэлэгт хамрагдах хүсэлтэй иргэдэд Олон нийттэй харилцах байгууллагуудтай хамтран тэтгэлгийн мэдээлэл зөвлөмж өгөх талаар ажиллаж байна. Энэхүү арга хэмжээнд ЭСЯ-ны төлөөллийг оролцуулж ажиллахаар тохиролцсон. - Тэтгэлэгт тэнцсэн оюутнуудад нэгдсэн журмаар уулзалт-мэдээлэл зохион байгуулж зөвлөгөө өгөх, хариуцлагын тангараг өргүүлэх ажлыг санаачлан хэрэгжүүлэн ажилласан. - Боловсролын удирдлагын мэдээллийн системээр дамжуулан гадаадад сурах оюутныг бүртгэдэг мэдээллийн системийн тогтолцоог бүрдүүлнэ. Мөн ГХЯ болон “Хилийн чанад дахь монголчуудын зөвлөл” ТББ-тай хамтран Гадаад суралцаж буй оюутнуудад зөвлөмж өгч ажиллаа.	100%
70		2. Өндөр хөгжилтэй оронд оюутан суралцуулах	2016 - 2020		Өндөр хөгжилтэй оронд Бакалаврын хөтөлбөрийг 2019 оноос ахин хэрэгжүүлж дэлхийн шилдэг сургуульд 40 оюутан, магистр, докторын зээлийн хөтөлбөрөөр Боловсролын Зээлийн Сангийн	100%

		мэргэжлийн чиглэл болон суралцагчдын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг холбогдох улсуудтай хамтран ажиллах гэрээ, конвенцид тусган ажиллах				зээлийн хүрээнд 51 оюутанд зээл олгосон. Мөн хоёр улсын хамтын ажиллагааны хүрээнд Украин Улсын Засгийн газрын тэтгэлэгийн оюутны тоог жил тутам 25 болгож 10 квотоор нэмэгдүүллээ, зогсонги байдал орсон байсан Бүгд Найрамдах Румын Улсын Засгийн газрын тэтгэлгээр 2019 онд 3 оюутан илгээж ахин сэргээж жил бүр 2-4 оюутанг хамруулахаар тохиролцсон, Лаос улсын ЗГ-ын тэтгэлэгт хөтөлбөрөөр ирэх 2020 оноос жилд 10 хүүхэд суралцуулахаар тохиролцож үндсэн квотыг 2 оор нэмэгдүүлсэн. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Засгийн газрын тэтгэлгээр суралцах оюутны тоог 50 квотоор нэмэгдүүлж нийт 150 иргэдийг жил бүр суралцуулахаар тохиролцсон.	
71	3.2.26.Оюутанд суралцах хугацаандаа цагийн ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох “Орлоготой оюутан” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1. “Орлоготой оюутан” хөтөлбөр батлан хэрэгжүүлэх	2017 - 2020		Хөтөлбөрийг хэрэгжүүлэх	Орлоготой оюутан хөтөлбөрийн хүрээнд Оюутны санаачилгын тэтгэлэгт төслийг 2019 онд 2 удаа зохион байгуулж 1-р ээлжинд 38 төслийг 254 гаруй сая төгрөг, 2 -р ээлжийн 19 төслийн 97 оюутанд 132 сая төгрөгийн тэтгэлэг олгогдсон. Оюутны санаачилгат төслийг сонгон шалгаруулахад тухайн сургуулийн тохижилт, орчин сайжруулах, материаллаг төслүүдээс илүү нийгэм, олон нийтэд чиглэсэн шинэ санаа инноваци болохуйц бусдад үр өгөөжөө өгөх төслүүд шалгарсан болно. Мөн орлоготой оюутанг дэмжих хүрээнд байгууллага, оюутны хооронд ажил гүйцэтгэх гэрээг байгуулж дадлага ажлыг хууль эрх зүйн чиглэлээр 14 оюутан, барилгын инженер хөтөлбөрөөр суралцаж буй 3 оюутан, менежментийн чиглэлээр суралцаж буй төгсөх ангийн 4 оюутанг цагийн ажил эрхлэх боломжийг ханган, оюутны мэргэшлийн ур чадварыг нь нэмэгдүүлэх, орлогын эх үүсвэртэй болох боломж бүрдүүлэн БСШУСС-ын 2019 оны 08 сарын 01-ний өдрийн А/486 тушаалаар 48,9 сая гаруй төгрөгөөр санхүүжүүлэн дэмжин ажилласан. 2019 оны	100%

					байдлаар 20 мянга гаруй оюутан цагийн болон үндсэн ажлын байртай болон ажиллаж байгаа нь үйлчилгээний байгууллагууд оюутан, суралцагчтай хамтран ажиллах, ажлын байрны эрэлт хэрэгцээ, шаардлага жилээс жилд өсөн нэмэгдэж байгаа ба ажил гүйцэтгэх гэрээг тухайн байгууллага оюутан болон сургуультай нь хамтран байгуулж тодорхой хэмжээний орлого бүрдүүлэхүйц ажлын байраар хангасан байна.	
72	3.2.27.Нээлттэй мэдлэг, боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг үргэлжлүүлж, орчин үеийн мэдээлэл, технологийн ололтод тулгуурласан насан туршийн боловсролын тогтолцоог эрчимтэй хөгжүүлнэ.	1. Бүх нийтийг тоон бичиг үсэгтэн болгох үндэсний хөтөлбөр боловсруулан баталж, хэрэгжүүлэх	2017 - 2020		Үндэсний хэмжээнд 2, 3 дугаар улиралд Насан туршийн боловсролын багш, захирал, сургалтын менежер, орон нутгийн удирдлага, шийдвэр гаргагчид нийт 620 багш, боловсон хүчнийг "Насан туршийн боловсролын үйлчилгээний хүртээмж чанар" сэдэвт сургалтад хамрууллаа. Энэхүү сургалтаар бүх нийтэд бичиг үсгийн боловсрол эзэмшүүлэх, хүн амд тоон бичиг үсгийн чадвар олгох агуулгыг оновчтой болгох арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүнийг боловсронгуй болгох, шинээр бүтээх асуудлыг хэлэлцүүлж, боловсрол судлал, мэдээллийн технологийн мэргэжлийн багш нар хичээл заалаа. 2019 оны 9, 10 дугаар сард насанд хүрэгчид, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах чадвар эзэмшүүлэх, тэдэнд бичиг үсгийн боловсрол олгох, мэдээллийн технологийн орчинд аюул эрсдэлгүй суралцах чадвар олгох арга зүйн сургалтад давхардсан тоогоор 2905 багш хамрагдлаа.	Үнэлэх боломжгүй
73		2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, насанд хүрээгүй хүүхэд, ахмад настны мэдээлэл,	2016 - 2020		2019 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн БСШУС-ын сайдын А/173 тоот тушаалаар “Багш нарт зориулсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, ахуйн баримжаа, цахим орчинд аюул, эрсдэлгүй сурах чадвар олгох сургалтын модуль Боловсролын хүрээлэн боловсруулан 2 удаагийн	Үнэлэх боломжгүй

		харилцаа холбооны технологийн зөв зохистой хэрэглээ нэмэгдүүлж, интернэтийн орчинд хамгаалах боломжийг бүрдүүлэх			сургалтаар 100 багшийг хамрууллаа. “Сэтгэцийн эрүүл мэнд”, “ICF”, “Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулах арга зүйд сургах нь”, “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хөгжүүлэх, нөхөн сэргээх, засан сайжруулах, ахуйн баримжаа олгох” зэрэг цуврал сургалтад давхардсан тоогоор 200 орчим багш, эцэг эх хамрагдлаа. Ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж байгаа I-XII ангийн бүх сурах бичгийг цахим хэлбэрээр www.econtent.edu.mn , www.meds.gov.mn веб хуудсанд байршуулж, хэрэглэгчдэд нээлттэй ашиглуулж байна. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид сурах бичгийг тохиромжтой хэлбэрээр ашиглах боломжийг бий болгох чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудыг дэмжин хамтран ажиллаж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн зайны сургалтын үйл ажиллагаанд зориулж НТБҮТөвийн веб сайт, тоног төхөөрөмжийг шинэчиллээ. Шинэчилсэн веб сайт нь Apache v2.4, PHP v7.0, MySQL v5 дээр суурилсан, Frontend буюу client-дээ HMTL5, Javascript, CSS сангуудыг ашигласан шинэ системээр ажиллана. Ингэснээр аль ч төрлийн төхөөрөмжөөс манай веб сайт руу хандалт хийхэд алдаа заахааргүй тохируулан, шинэчилсэн. Веб сайтад 118 видео хичээл байршуулаад байна.	
74	3.2.28.Дүрслэх урлаг, уламжлалт урлахуйн ухааныг хөгжүүлж, гадаад, дотоодод түгээн сурталчлах бодлогыг хэрэгжүүлнэ.	1. Үндэсний болон түүхэн агуулга бүхий дүрслэх урлагийн бүтээлийн уралдааныг жил бүр зохион байгуулах	2017 - 2020		1.Засгийн газрын 2006 оны 115 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор 2019 оны дүрслэх урлагийн шилдэг бүтээлийн шалгаруулалтыг зохион байгууллаа. БСШУС-ын Сайдын 2019 оны А/657 дугаар тушаалаар 2019 онд Улсын санд худалдан авах шилдэг бүтээлээр А.Очирболд “Ухамсар”/ган баримал/, Б.Отгонтүвдэн “Авга ах” /уран зураг/, Г.Эрдэнэбилэг “Муза” /уран зураг/, Л.Гантөмөр “Чонон тууль” /хүрэл баримал/, Б.Содномдаржаа “Тавган дээрх соёл” /холимог техник/ 5 бүтээлийг	100%

					<p>шалгаруулж, улсын санд худалдан авч дүрслэх урлагийн сан хөмрөгийг баяжуулав.</p> <p>2.Итали Улсын Венеци хотноо зохион байгуулагддаг Дүрслэх Урлагийн 58 дахь удаагийн олон улсын биенналь, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад-зохион байгуулагдсан дүрслэх урлагийн олон улсын НордАрт үзэсгэлэн, ЮНЕСКО, Европын Холбооны дэмжлэгтэйгээр Бүгд Найрамдах Чех Улсын Прага хотноо зохион байгуулагдсан олон улсын тайз, дэлгэц, архитектур, дизайны PQ-2019 наадамд санхүүжилтийн дэмжлэг тус тус үзүүлж Монголын уран бүтээлчдийг оролцууллаа.</p> <p>3. Монголын хүүхэлдэй урлал, шуумал урлал, гар урлалын үзэсгэлэнг Азийн ардын урлагийн наадмаар гаргаж сурталчиллаа. 4.Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин хотноо Монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны гишүүн Г.Ган-Өлзийгийн "Хөх тэнгэрийн орноор" монголын байгаль, үндэсний ахуй соёлыг харуулсан гэрэл зургийн үзэсгэлэнг БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгууллаа.</p>	
75	3.2.29.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, Инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулан гаргана.	1. Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулж, батлах	2016 - 2017		<p>“Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого”-ыг Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор баталсантай холбогдуулан УИХ-ын 1998 оны 55 дугаар тогтоолыг хүчингүй болгох зорилгоор “Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” УИХ-ын тогтоолын төслийг УИХ-ын 2018 оны 5 дугаар 03-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанд хэлэлцүүлж, УИХ-ын 28 дугаар тогтоолоор баталгаажуулсан. Ингэснээр Засгийн газрын 2017 оны 295 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого” хэрэгжиж эхлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн. “Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл</p>	100%

					ажиллагааны төлөвлөгөө /2018-2025 он/-ний төслийг боловсруулж, БСШУС-ын сайдын “Үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” 2018 оны А/443 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байна. "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 379 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхээр ажиллаж байна.	
76		2. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг шинэчлэн боловсруулж, батлах	2016 - 2017		Инновацийн талаар төрөөс баримтлах бодлогыг Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 233 дугаар тогтоолоор баталсан. Тус бодлогыг хэрэгжүүлэх I шатны арга хэмжээний төлөвлөгөөг БСШУС-ын сайдын 2019 оны "Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/145 дугаар тушаалаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрөөс инновацийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх I шатны арга хэмжээний төлөвлөгөөг 2019-2021 онуудад хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд 4 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг шат дараатайгаар хэрэгжүүлж эхлээд байна.	100%
77		3. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2017 - 2018		Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нарын санаачлан боловсруулсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 2019 оны 10 дугаар сарын 14-ний нэгдсэн чуулганаар хэлэлцэж, Засгийн газраас санаачлан боловсруулсан Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамтатган хэлэлцэхээр шийдвэрлэсэн. Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын Байнгын хорооны хурал болон нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэхэд бэлтгэх Ажлын хэсгийг УИХ-ын	70%

					гишүүн А.Ундраа ахлан ажиллаж байна.	
78		4. Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2017 - 2018		УИХ-ын чуулганы 2019 оны 12 дугаар сарын 20-ны хуралдаанаар Инновацийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэн батлав. Хууль батлагдсанаар инновацийн үйл ажиллагаа, дэд бүтэц, түүнд оролцогч талуудын эрх үүргийн хуваарилалт тодорхой болж, талуудын оролцоо тэгш хангагдах, төрөөс олгож буй санхүүжилтийн дэмжлэгийг оновчтой болгох, инновацийн үйл ажиллагаан дахь төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагаа, түншлэл өргөжин тэлэх зэрэг эрх зүйн таатай орчин бүрдэх юм. Үүний зэрэгцээ аж үйлдвэрт инновацид суурилсан бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн нэр төрөл олширч, хувь хэмжээ нэмэгдэн мэдлэг, технологи шингэсэн бүтээгдэхүүний экспортыг дэмжих, улмаар зах зээлд нэвтрүүлж эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэнэ.	100%
79		5. Шинжлэх ухаан, технологийн паркийн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2017 - 2018		Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3-т заасны дагуу БСШУС-ын сайд, ХЗДХ-ийн сайдын хамтарсан шийдвэрээр "Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хууль"-ийн үзэл баримтлалыг 2019 оны 10 дугаар сарын 18-ний өдөр батлуулсан. Уг үзэл баримтлалд үндэслэн Шинжлэх ухааны паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг боловсруулж, ШУА, эрдэм шинжилгээний хүрээлэн, төрийн өмчийн 6 их сургууль, МХАҮТ /аж ахуйн нэгжээс нэгтгэн ирүүлэх/, ГЕГ, ТЕГ, ОӨГ-аас санал авахаар хүргүүлсэн. Мөн яамны веб-д байршуулж, иргэд, олон нийт, мэргэжлийн судлаачдаас онлайнаар санал авах ажлыг 2019 оны 10 дугаар сарын 24-өөс 11 дүгээр сарын 24-ний өдрийг дуусталх хугацаанд нээлттэй зохион байгуулж, саналыг хуулийн төсөлд бүрэн тусгалаа.	70%

					Хуулийн төсөлд 12 яамнаас санал авч байна. 2020 онд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх зөвшөөрлийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 15.3-т заасны дагуу авч хэлэлцүүлэх, УИХ-д өргөн мэдүүлэх ажлыг зохион байгуулна.	
80	3.2.30.Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлах	1. Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, батлах	2018 - 2019		“Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх хөтөлбөр-II”-ийг Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, түүнд баримтлах нийтлэг журмын дагуу боловсруулж бусад төрийн захиргааны төв байгууллагуудаас санал авсан бөгөөд Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т хүргүүлсэн. Уг хөтөлбөрийн төсөлд мэргэжлийн байгууллага, эрдэмтэн судлаачид, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, холбогдох мэргэжлийн агентлагаас санал авч төсөлд тусгасан болно.	70%
81	3.2.30.Үндэсний инновацийн тогтолцоог хөгжүүлэх бодлогыг тууштай баримталж, инноваци, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлж, экспортыг нэмэгдүүлнэ.	2. Инновацийн бүтээгдэхүүн бий болгох, үйлдвэрлэл явуулах таатай орчин бүрдүүлэх	2016 - 2020		Засгийн газрын 2018 оны 234 тогтоолын хавсралтаар “Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт” батлагдсан. Энэхүү жагсаалт нь гарааны компани байгуулах журмын дагуу байгуулагдаж, бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүд инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл явуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжөөр хангагдаж, ажлын байр шинээр бий болох, импортыг орлох, экспортод чиглэсэн, зах зээлд шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, улмаар инновацийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа өргөжин, татварын суурь бэхжиж, улс орны эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.	100%
82		3. Инноваци, гарааны	2017 - 2020		“Инновацийн үйл ажиллагаанд оролцогчид грант олгох журам”-ын дагуу инновацийн төслийг сонгон	100%

		бизнесийг дэмжих зорилгоор төсөл хэрэгжүүлэх			шалгаруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын сайдын 2019 оны А/326 тоот тушаалаар 2019 онд инновацийн грант 5, технологийн туршилт зүгшрүүлэлтийн 18 төсөлд нийт 600 сая төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэсэн. “Гарааны бизнесийг дэмжих, инновацийн соёлыг төлөвшүүлэх, гарааны бизнес эрхлэгчдийн мэдлэг, чадавхийг сайжруулахад чиглэсэн гарааны компани, инновацийн мэргэжилтнүүдэд зориулсан “Гарааны компани, инновацийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 9 дүгээр сарын 19-21 хооронд амжилттай зохион байгууллаа. “Гарааны бизнесийг дэмжих, инновацийн соёлыг төлөвшүүлэх, гарааны бизнес эрхлэгчдийн мэдлэг, чадавхийг сайжруулахад чиглэсэн гарааны компани, инновацийн мэргэжилтнүүдэд зориулсан “Гарааны компани, инновацийн хүний нөөцийг чадавхжуулах сургалтыг 2019 оны 9 дүгээр сарын 19-21 хооронд амжилттай зохион байгууллаа. Сургалтын сургагч, чиглүүлэгч багшаар Start компанийн багш нар болон БНХАУ-ын гарааны компани, инкубаторын удирдагч зочин багш Чэн хун цай, Чэн жүн нар урилгаар оролцож, 34 их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын дэргэдэх гарааны компаниуд, 30 орчим хамтын оффисуудад бойжиж буй багуудын төлөөлөл болон инновацийн мэргэжилтэн, судлаачдыг хамрууллаа. 3 өдрийн сургалтаар энтрепренершип, хөрөнгө оруулалт, бизнес модель, стартапын эко систем, компанийн бүтэц, соёлыг хэрхэн төлөвшүүлэх, гарааны бизнесийг дэмжих, инкубацийг хөгжүүлэх зэрэг сэдвүүдээр хэлэлцүүлэг, сургалт явагдан санал бодлоо чөлөөтэй солилцов.	
83		4. МБСБ-ын судлаачид, багш,	2017 -		Шинжлэх ухаан технологийн сан, Оюуны өмчийн газар хооронд “Хамтран ажиллах гэрээ”-г 2019 оны	Үнэлэх

		суралцагчид, төгсөгчдийн инноваци, бүтээлийн оюуны өмчийг хамгаалах, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжих төсөл хэрэгжүүлэн, эдийн засгийн эргэлтэд оруулах	2020			07 дугаар сарын 10-ны өдөр байгуулж, цаашид Монгол Улсын оюуны өмчийн харилцаа, эрх зүйн зохицуулалтаар шинжлэх ухааны салбарын эрдэмтэн, судлаачдын биет болон биет бус оюуны бүтээлийг патентжуулж улмаар эдийн засгийн эргэлтэд оруулах хамгийн том хөшүүрэг болох оюуны өмчийн үнэлгээний ажлыг тогтмолжуулах, лицензээр ашиглах, технологи дамжуулах тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар болсон. Шинжлэх ухаан, технологийн сан “Монгол эрдэмтэн мэдээллийн сан”-д 2019 оны 11 дүгээр сарын байдлаар шинжлэх ухааны 5 салбараар 5654 эрдэмтэн бүртгэлтэй байгаагаас нийт эрдэм шинжилгээний ажлын 4830 төсөл, судалгаа боловсруулалтын ажил 4093, диссертац, авто-реферат гэхэд 4000 гаруй бүртгэлтэй байна.	боломжгүй
84	3.2.31.Шинжлэх ухааны салбар, эрдэмтэд, хүрээлэнгүүдтэй хамтран шинэ технологи нэвтрүүлсэн хувийн аж ахуйн нэгжүүдийг урамшуулах механизм бий болгоно.	1. Үндэсний инновацийн шагналын журам боловсруулж, хэрэгжилтийг хангах	2017			Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 49 дүгээр тогтоолоор “Үндэсний инновацийн шагнал олгох журам” батлагдсан. Энэхүү журмаар Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан инновацийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд үндэсний инновацийн шагнал горилох бүтээлийг нэр дэвшүүлэх, материал хүлээн авах, сонгон шалгаруулах, шагнал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.	100%
85	3.2.32.Оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлж, монгол хүний эзэмшиж байгаа зохиогчийн эрх, патентыг	1. Оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	2018 - 2020			Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайд болон Оюуны өмчийн газрын даргын 2019 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн А/12 тоот хамтарсан тушаалаар “2019-2020 онд шинжлэх ухаан, технологийн салбарын оюуны өмчийн үнэлэмжийг нэмэгдүүлэх төлөвлөгөө”-г батлан хэрэгжүүлж байна.	100%

86	хамгаалах асуудлыг олон улсын түвшинд хүргэж, сурталчлах ажлыг идэвхжүүлнэ.	2. Судалгаа боловсруулалтын ажлын үр дүнд бий болсон оюуны өмчийн мэдээллийн сан бүрдүүлж хамгаалах, сурталчлах ажлыг идэвхижүүлэх	2017 - 2020		<p>Монгол эрдэмтэн судлаачид, гарааны компаниудын инновацийн бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор цахим худалдааны Scientific E-SHOP платформыг Шинжлэх ухаан, технологийн сан дээр хөгжүүлэн ажиллаж байна. Их дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаачдын туршилт, судалгааны ажлын үр дүнд бий болж, Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж байгаа инновацийн бүтээгдэхүүнүүдийн жагсаалтыг гаргаж Төрийн худалдан авалтын нэгдсэн системийн цахим худалдаанд хамруулах чиглэлээр ажиллаж байна. 2019 оны 5 дугаар сард зохион байгуулсан Инновацийн долоо хоногийн арга хэмжээний үеэр “Инновацийн үзэсгэлэн-2019” зохион байгуулж инноваци нэвтрүүлж буй байгууллагуудын төлөөлөл болох 63 байгууллагын 400 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд танилцууллаа. 2019 оны 9 дүгээр сарын 6-7-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-д зохион байгуулагдсан “3 дахь удаагийн Монгол-Хятадын ЭКСПО”-ийн үеэр Монгол, Хятадын шинжлэх ухаан, технологи, инновацийн хамтын ажиллагааны түвшинг ахиулах, хоёр орны хамтарсан төслийн үйл ажиллагааг дэмжих, хоёр орны голлох үйлдвэрлэл болон ирээдүйтэй салбарын технологийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Монгол-Хятадын технологи дамжуулалт, инновацийн хамтын ажиллагааны хоёрдугаар форумыг хамтран зохион байгууллаа. Монгол-хятадын хамтарсан төслийн хүрээнд бий болсон судалгааны үр дүн болон ШУТСанд бүртгэлтэй технологи, бүтээгдэхүүнээс арга хэмжээний үеэр зохион байгуулагдсан үзэсгэлэнд танилцууллаа. 2019 оны 09-р сард БНХАУ-ын Манжуур хотод зохион байгуулагдсан Хойд бүсийн олон улсын шинжлэх ухаан, технологийн 16 дугаар олон улсын үзэсгэлэнг</p>	100%
----	---	--	-------------	--	---	------

					хамтран зохион байгуулж, оролцлоо. БНХАУ-ын Шинжлэх ухаан технологийн яамтай хамтран “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах”, “Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт” төслүүдийг хэрэгжүүлж байна.	
87	3.2.33.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарт олон улсын жишигт нийцсэн барилга, байгууламж, лабораторын орчин нөхцөл бүхий дэд бүтцийг бий болгохыг дэмжинэ.	1. Эрдэм шинжилгээний байгууллагуудын лабораторийн орчныг сайжруулж, тоног төхөөрөмжийг орчин үеийн судалгааны шаардлагад нийцүүлэн шинэчлэх	2017 - 2020		Эрдэм шинжилгээний байгууллагуудын лабораторийн орчныг сайжруулж, тоног төхөөрөмжийг орчин үеийн судалгааны шаардлагад нийцүүлэн шинэчлэхэд Улсын төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй. 2014 оноос эхлэн ШУТИС-д Японы Засгийн газрын 7.5 тэрбум иений хөнгөлөлттэй зээлээр санхүүжиж байгаа “Инженер технологийн дээд боловсрол” төслийн хүрээнд 2018 онд ШУТИС-д сургалт, судалгааны лабораторийн 382.1 сая иений, МУИС-ийн судалгааны лабораторит 288.0 сая иений өртөгтэй тоног төхөөрөмжийг тус тус нийлүүлсэн. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Дээд боловсролын шинэчлэлийн төсөл”-ийн санхүүжилтээр 2018 онд Монгол Улсын их сургуульд орчин үеийн судалгааны шаардлагад нийцсэн 3 тэрбум төгрөгийн өртөг бүхий Лазерын лабораторийг байгуулсан. 1. Шинжлэх ухааны судалгааны лаборатори, спортын танхим бүхий цогцолборын барилга угсралтын ажил 2012 онд эхэлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай явагдаж байна. Нийт авсан санхүүжилт 3.9 тэрбум төгрөг. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.1.2 дугаарт үлдэгдэл санхүүжилт 286.0 сая төгрөг батлагдсан ба барилга угсралтын ажил 2020 оны 1 дүгээр сард дуусч, ашиглалтад орно. 2. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд үндсэн чиглэлд тусгагдсан шинжлэх ухааны	100%

					судалгааны төв, лабораторийг шинээр байгуулахад зориулан улсын төвийн хөрөнгө оруулалтаар 1 мал эмнэлгийн хүрээлэнгийн лабораторийн барилга, 1 биологийн идэвхит бэлдмэлийн үйлдвэрлэл, туршилт, судалгааны төвийг ашиглалтад оруулсан. 3. Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй Шинжлэх ухааны академийн нэгдсэн байрын өргөтгөлийн барилга гүйцэтгэгчээр “Хөх бүрдний эх” ХХК шалгарч, барилгын угсралтын ажлыг гүйцэтгэж байна. Барилгын гүйцэтгэл 30 гаруй хувьтай бөгөөд 2020 оны III улиралд ашиглалтад орно.	
88		2. Туршилтын үйлдвэр, технологи дамжуулах төв, бизнес инкубатор зэрэг инновацийн дэд бүтэц байгуулах ажлыг зохион байгуулах	2017 - 2020		БНХАУ-тай хамтран “Монгол Улсад инкубаторын үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон мэдээллийн серверийн бүтээн байгуулалт”, “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслүүдийг хэрэгжүүлж байна. Инкубатор байгуулах тохижилтын зураг, интерьер зургийг боловсруулан, сүлжээ, серверийн тоног төхөөрөмжүүдийг тээвэрлэх, зөөх, гаалийн татвараас чөлөөлүүлэх зэрэг холбогдох арга хэмжээг авч ажилласан. Төслийн хүрээнд firewall, server, storage, switch, router зэрэг 20-иод нэр төрлийн сүлжээний тоног төхөөрөмжүүдтэй 100 терабайт мэдээлэл хадгалах боломжтой сервер байгуулагдсан. “Хятад-Монголын Технологи дамжуулах төвийн платформыг байгуулах” төслийн 2019 оны ажлын нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажилласан. Технологи дамжуулах төвийн дотоод тохижилтын зураг, интерьер зургийг боловсруулсан. Мэдээллийн сан нь монгол, хятад, англи 3 хэл дээр ажиллах боломжтой байхаар Технологи дамжуулах платформын хөгжүүлэлтийг хийж байна. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг инкубатор төв, дундын оффис,	100%

					технологи дамжуулах төвүүдийн нэгдсэн судалгааг гаргасан.	
89	5. Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ судалгааг цөм технологи, тэргүүлэх чиглэлийн хүрээнд хөгжүүлэх	2016 - 2020			Зам тээврийн яамнаас 2019 онд ирүүлсэн цөм технологийн төслийн 4 саналаас 1 төслийг сонгон Салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна. Мөн БСШУСЯ-ны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр энэхүү арга хэмжээг чиг үүргийн дагуу ЗТХЯ үндсэн хэрэгжүүлэгчээр хариуцуулж, БСШУСЯ-ыг хасуулах санал хүргүүлсэн.	40%
90	6. Зам, тээврийн салбарын эрдэм шинжилгээ, туршилт судалгааны байгууллагатай болох ажлыг эхлүүлэх	2017 - 2019			2019 онд ЗТХЯ-ны харьяа Зам тээврийн хөгжлийн хүрээлэн байгуулах асуудлыг "Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын тогтоолын төсөлд тусган боловсруулж яамдаас санал авсан. Тогтоолын төслийг Сангийн яам зөвшөөрөөгүй тул дэмжигдээгүй болно.	Үнэлэх боломжгүй
91	9. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийг сонгон шалгаруулж, шинэ инновацийг нэвтрүүлэн, нутагшуулах бааз бий болгох	2016 - 2020			Эрүүл мэндийн тухай хуулийн "37.4.Оношилгоо, эмчилгээний зориулалтаар шинээр гарч байгаа болон био технологи, нано технологи, инновацийн технологид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээнд судалгаа, шинжилгээ явуулах, турших, баталгаажуулах, бүртгэх, мэдээлэх, тусламж, үйлчилгээнд нэвтрүүлэх үйл ажиллагааг зохицуулах журмыг эрүүл мэндийн болон шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална" гэж заасны дагуу ЭМЯ-тай хамтран боловсруулсан. Тус журмыг Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн "Журам батлах тухай" А/253/А/348 дугаар хамтарсан	Үнэлэх боломжгүй

					тушаалаар батлуулж, ХЗДХЯ-нд хүргүүлэн бүртгүүлэн мөрдүүлж эхэлсэн. ЭМЯ-ны захиалгаар Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв дээр "Үр хөврөлийн удамзүйн оношилгоо ба эр бэлгийн эсийн хөгжлийн эхэн үеийг үр тогтоох эмчилгээнд ашиглах технологийг нэвтрүүлэх", "Хүүхдийн бөөрний мэс заслын тусламж үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх" шинжлэх ухаан, технологийн захиалгат төслийг 2019 оноос хэрэгжүүлж эхлэхээр БСШУС-ын сайдын 5-р сарын А/324 дугаар тушаалаар батлав.	
92	10. Уул уурхай, шинжлэх ухааны чиглэлд бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх хүрээнд Шинжлэх ухаан, танин мэдэхүйн мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн асуудлыг шийдвэрлэх	2018			ЦЭК-ын ажлын албанаас Шинжлэх ухаан, танин мэдэхүй төв байгуулах зорилго бүхий байгуулсан ажлын хэсэг нэг удаа хуралдаж, тус төвийг музейн жишгээр БСШУСЯ-ны харьяанд байгуулахаар санал гарган албан бичгээр ирүүлсэн. Тус төвийн байрны асуудал, ТЭЗҮ-г батлуулах зардал төсөв манай яамны төсөвт батлагдаагүй, түүнчлэн сул байр байшин, талбай байхгүй тул хэрэгжүүлэх боломжгүйг уламжилсан хариуг албан бичгээр хүргүүлсэн болно. 2018 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 1/5556 дугаар албан бичиг хүргүүлсэн. 2019 оны 9-р сард хуралдсан Шинжлэх ухааны ажилтны улсын анхдугаар их хурлаас гарсан зөвлөмжийг үндэслэн "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 379 дүгээр тогтоол баталсан. Уг тогтоолын 1.3-т тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх хүрээнд Шинжлэх ухааны хүрээлэнгүүдийн цогцолборын барилга барих зураг төсөлд шинжлэх ухааны музей байгуулах асуудлыг тусган ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй
93	11. Шинжлэх ухаан, танин мэдэхүйн	2017			ШУА-ийн Одон орон, геофизикийн хүрээлэнгийн "Од эрхсийн ордон", Палеонтологи, геологийн хүрээлэнгийн Хүннү молл дахь "Үлэг гүрвэлийн	Үнэлэх боломжгүй

		мэдээллийн төв байгуулах барилга, байгууламжийн дотоод зураг төсөл, үзүүлэн бэлтгэх, макет, үзвэрүүдийг хийх, тохижилт болон бусад арга хэмжээг зохион байгуулах				үзэсгэлэн" үйл ажиллагаагаа явуулж олон нийтэд үйлчилж байна. ШУА-аас Нийслэлийн боловсролын газартай хамтран Эрдмийн аян хөтөлбөрийг дээрх үзэсгэлэнгүүдийг түшиглэн 2015 оноос хойш хэрэгжүүлж, 3000-аад хүүхэд, багачуудад үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлээд байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2016 оны А/178 дугаар тушаалаар Х.Цогтбаатар удирдагчтай "Палеонтологийн олдвороос хуулбар хэв хийх" нэр бүхий инновацийн төсөл хэрэгжиж дууссан. 2020 онд төслийн тайлангаа хүлээлгэн өгнө.	
94	3.2.34.Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуульд үндэслэн хувийн хэвшлийн оролцоонд тулгуурласан Хамтын хөрөнгө оруулалтын санг байгуулж, инновацийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх тааламжтай бүтцийг бүрдүүлнэ.	1. Төр, хувийн хэвшлийн хамтарсан хэлбэрээр инновацийн үйл ажиллагааг санхүүжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлж, хамтын хөрөнгө оруулалтын сан байгуулах санал боловсруулах	2017		Хөрөнгө оруулалтын саналыг хууль эрх зүйн үндэслэл, практик шаардлага, тулгамдсан асуудал, ач холбогдол, үр дүн дүгнэлт агуулгын хүрээнд боловсруулсан. 2013 онд батлагдсан "Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль", Санхүүгийн зохицуулах хорооноос 2014 онд гаргасан "Хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн болон үйл ажиллагааны журам батлах тухай", "Хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, хамтын хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай журам ", "Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам" зэрэг нь "Хамтын хөрөнгө оруулалтын сан"-г үүсгэн байгуулах эрх зүйн орчинг бүрдүүлж байна. Инновацийн үйл ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэхэд чиглэсэн төр хувийн хэвшлийн хамтын түншлэлд тулгуурласан менежментийн компани байгуулж, тус компанид төвлөрсөн санхүүжилт, хөрөнгө оруулалтыг үндэсний хэмжээний инновацийн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд нэвтрүүлэх, олон улсад өрсөлдөх чадавхийг нэмэгдүүлэх зэрэг нийгэм, эдийн засгийн олон талт	70%	

					үр ашигтай, ач холбогдолтой юм.	
95	3.2.35.Шинжлэх ухаан, технологи, инновацийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх бодлого баримтална.	1. Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх	2017 - 2020		“Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөр”-ийг Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн, Засгийн газрын “Үндэсний хөтөлбөр батлах тухай” 162 дугаар тогтоолоор батлав. Хөтөлбөрийг 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлнэ. 2019 оны 9 дүгээр сард МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан Шинжлэх ухааны ажилтны улсын анхдугаар их хурлын салбар хуралдаанаар шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх асуудлыг хэлэлцсэн. Тус салбар хуралдаанаас гарсан саналуудыг нэгтгэн, ангилж хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган боловсрууллаа. Төлөвлөгөөг “Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай” Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/826 тушаалаар баталсан.	100%
96		2. Нийгмийн мэдээллийн сүлжээг ашиглах зохистой хэрэглээг бий болгох	2016 - 2020		МУИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төвийн дэргэд 60 гаруй сая төгрөгийн өртөг бүхий “Дижитал профессорын студи”-ийг байгуулан, ашиглалтад оруулж, 7 хичээлийн нийт 90 гаруй цагийн видео хичээлийг бичиж бэлтгээд байна. Тус сургуулийн онлайн сургалтыг хөгжүүлэх зорилгоор Японы Нээлттэй их сургууль (Open University of Japan)-ний хамтран ажиллах санамж бичиг байгуулан, эхний шатны 20 гаруй сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэлэг техник хэрэгслийг студид суурилуулсан нь онлайн хичээлийн бичлэгийн чанарыг сайжруулах, засварлах ажлыг хурдтай гүйцэтгэх бүрэн боломжийг бүрдүүлэв. МУИС-ийн Багшийн хөгжил, цахим сургалтын төв нь багшийн хөгжил, нээлттэй	Үнэлэх боломжгүй

					боловсролын чиглэлээр олон улсад үйл ажиллагаа явуулдаг “Professionaland Organizational Development” (PODNETWORK), “International Society for Technology in Education” (ISTE) гэсэн 2 мэргэжлийн байгууллагын гишүүнээр элсэн, тэдгээр байгууллагын гишүүн их дээд сургуулиудын багшлахуй, суралцахуйн төв, онлайн сургалтын төвүүдтэй хамтран ажиллах боломж бүрдэв.	
97	3.2.36.Салбарын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх өндөр технологийн судалгаа ба хөгжил, инновацийн болон зөвлөх, нэвтрүүлэх үйлчилгээний үйл ажиллагааны суурь бүтцийг хөгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	1. Шинжлэх ухааны паркийн захиргаа байгуулж, холбогдох дүрэм журмыг боловсруулах	2018 - 2020		Засгийн газрын 2017 оны “Шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулах тухай” 19 дугаар тогтоолоор инноваци, өндөр технологийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх, шинжлэх ухааны паркийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдэл байгуулагдсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд жил бүр “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн захиралтай үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээ байгуулан, баталгаажуулж, түүний хэрэгжилт гүйцэтгэлийг ханган ажиллаж байна. “Шинжлэх ухааны паркийн захиргаа” шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэлийн нэгдлийн захирлын 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн гэрээний биелэлт, тайланг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлаар хэлэлцүүлэв.	100%
98		2. Шинжлэх ухааны паркийг байгуулах ТЭЗҮ-ийг боловсруулах	2018 - 2020		Шинжлэх ухааны паркийн техник эдийн засгийн урьдчилсан судалгааг Монгол Улсын шинжлэх ухаан, технологи, инновацийн хөгжлийн өнөөгийн байдал, бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан парк байгуулснаар бий болох үр нөлөө, эдийн засгийн хэрэгцээ шаардлага, гадаад орнуудын туршлага, холбогдох судалгаанд үндэслэн боловсруулсан.	100%

					Судалгааны ажлууд дээр үндэслэн "Монгол Улсад Шинжлэх ухааны парк байгуулах техник, эдийн засгийн үндэслэл" боловсруулах ажлын /техникийн/ даалгаврыг боловсруулсан. Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд 2019 оны 12 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд БНХАУ-д айлчлал хийсэн. Айлчлалын хүрээнд зохион байгуулагдсан Монгол Улсын Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, БНХАУ-ын Шинжлэх ухаан, технологийн сайд Ван Жи Ган нарын уулзалтаар Монгол Улсад Шинжлэх ухааны паркийн байгуулах нарийвчилсан төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулахад БНХАУ дэмжиж ажиллахаа илэрхийлсэн.	
99	3.2.37.Нээлттэй лабораторид суурилсан био, нанотехнологийг хөгжүүлж, оюуны багтаамж өндөртэй, экспортын чиг баримжаатай бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлнэ.	1. Салбар дамнасан өндөр технологийн нээлттэй лабораторийг байгуулах	2016 - 2020		Салбар дамнасан өндөр технологийн нээлттэй лабораторийг байгуулахад Улсын төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгагдаагүй. Эрдэм шинжилгээний зориулалт бүхий дундын нээлттэй лаборатори байгуулах ажлын эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор Шинжлэх ухаан, технологийн салбарын нээлттэй лабораторийн үйл ажиллагааг зохицуулах журмыг "Шинжлэх ухаан, технологийн тухай хууль", "Төрөөс шинжлэх ухаан, технологийн талаар баримтлах бодлого"-д нийцүүлэн эцэслэн боловсруулсан. Салбар дундын нээлттэй лабораторийн зарчмаар ажиллуулахаар төлөвлөж байгаа "Шинжлэх ухааны байгууллагуудын судалгааны лаборатори, спорт танхим" бүхий цогцолборын барилга угсралтын ажил 2012 онд эхэлсэн бөгөөд ажлын гүйцэтгэл 95 хувьтай явагдаж байна. Нийт авсан санхүүжилт 3.9 тэрбум төгрөг. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын XII.4.1.2 дугаарт үлдэгдэл санхүүжилт 286.0 сая төгрөг батлагдсан ба барилга угсралтын ажил 2020 оны 1 дүгээр сард дуусч,	100%

					ашиглалтад орно.	
100		2. Био, нанотехнологийг хөгжүүлэх зорилтот шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх	2018 - 2020		Био, нанотехнологийг хөгжүүлэх зорилтот шинжлэх ухаан, технологийн төсөл хэрэгжүүлэхээр төсвийн саналд тусган СЯ-нд хүргүүлсэн боловч төсөв батлагдаагүй. Өмнөх онуудаас биотехнологийн чиглэлээр улсын захиалгат төсөл -30, цөм технологийн 3 төсөл, нанотехнологийн чиглэлээр суурь судалгааны 1 төсөл хэрэгжиж байна. Төслийн явцын мониторингоос харахад судалгааны үйл ажиллагаа хэвийн, үр дүн сайтай хэрэгжиж байна.	70%
101	3.2.39.“Монгол контент” бүтээгчдийг дэмжих бодлого баримтална.	1. “Монгол уран бүтээл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2018 - 2020		Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Соёл, урлагийг дэмжих сангаас 2019 онд дараах төсөл, хөтөлбөр шалгаруулж санхүүжилтийн дэмжлэг үзүүллээ. Үүнд: 1."Хөхөө шувууны домог" бүрэн хэмжээний хүүхэлдэйн жүжгийн төсөлд 10 сая. 2."Монгол Хатад" 3 ангит баримтат киноны төсөлд 40 сая. 3."Бөөгийн домог" уран сайхны киноны төсөлд 25 сая. 4. "Бүнээ Сүнээ хоёр" хүүхдийн олон ангит анимейшн киноны төсөлд 25 сая, 5. "Монгол Уламжлалт эрүүл хүнс" баримтат киноны төсөлд 10 сая. 6. "Монгол хүү" киног орос, англи хэл рүү дуу оруулах" төсөлд 40 сая. 7."Зая гэгээнтэн" төсөлд 10 сая. 8. "Их домог аугаа соёл" бүтээлч төсөлд 25 сая төгрөгийн санхүүжилтийн дэмжлэгийг тус тус үзүүлж хэрэгжилтийг ханган ажиллалаа. Мөн ЗГХА Соёл, урлагийн газар, Монголын Үндэсний Олон Нийтийн Радио Телевизтэй монгол уран бүтээлчдийн хосгүй үнэт бүтээлийг үзэгч түмэн, үр хойчдоо үнэт өв болгон Алтан сан хөмрөгт бичүүлэн үлдээх зорилгоор ДБЭТ, УДЭТ, ҮУИТ, Улсын Филармони, Хүүхэлдэйн театрын бүрэн хэмжээний тус бүр нэг бүтээлийг 2019 онд бичүүлэх төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангалаа.	100%

102	3.2.40.Сансрын холбооны үндэсний хиймэл дагуул төслийг хэрэгжүүлж, газар сансрыг холбосон үндэсний харилцаа холбооны сүлжээ байгуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хамгаална.	3. Хиймэл дагуулын систем бий болгох чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх ажлыг үе шаттай авч хэрэгжүүлэх	2017 - 2019		<p>“Мазаалай” хиймэл дагуул сансарт хөөрсний хоёр жилийн ойг тохиолдуулан МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нано хиймэл дагуул хөгжүүлэх лаборатори, МУИС-ийн Инноваци, Технологи дамжуулах төв хамтран “Нано Хиймэл Дагуул ба Шинэ боломж” бизнес уулзалт, арга хэмжээг амжилттай зохион байгууллаа. “ИННОВАЦИЙН ҮЗЭСГЭЛЭН-2019”-д оролцож, МУИС-ийн Мазаалай хиймэл дагуулын төсөл шилдгээр шалгарсан. МУИС-ийн ШУС-ийн Нано хиймэл дагуул хөгжүүлэлтийн лабораторийн судлаач Т.Төртогтох “Тэмүүлэл” хиймэл дагуулын төслийг танилцууллаа. “Тэмүүлэл” төсөл нь Шинжлэх ухааны судалгаа, технологийн туршилтыг сансарт хийх боломжтой кубсат ангиллын хиймэл дагуул бөгөөд Сансрын технологийг эзэмших, өндөр технологийг дотооддоо бүтээх, энэ салбарын боловсон хүчнийг бэлтгэх, эрдэм мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх зорилготой төсөл юм. Уулзалтад БСШУСЯ, ШУА, МУИС, ШУТИС, ШМТДС, ТЗДС, ХУУИС, ХХМТГ, НШУУИГ, МJEED, Рио Тинто групп, ДДэшТВ ХХК, Скайтел ХХК, Вагнер Ази ХХК, Төрийн банк, Богд Банк, МонМэп ХХК зэрэг төрийн болон эрдэм шинжилгээний байгууллага, компани, хиймэл дагуулын мэдээлэл ашигладаг, сансар судлалтай холбоотой олон байгууллагуудын төлөөлөл, хувь хүмүүс, бизнесийн байгууллагын төлөөлөгчид хүрэлцэн ирж санал солилцон, хэлэлцүүлэг өрнүүллээ. 2018-2019 оны хичээлийн жилд ШУС-ийн Физикийн тэнхимийн дэргэд Зайнаас тандан судлал ба сансар судлалын лаборатори байгуулагдаж ажиллаж байна.</p>	Үнэлэх боломжгүй
103	3.2.41.Байгаль, эдийн засаг, нийгэм, хууль, эрх зүй зэрэг салбарын шинжлэх	1. Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний	2017 - 2020		Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд "Шинжлэх ухааны академийн нэгдсэн байрын өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр "Хөх	70%

	ухааныг хөгжүүлэх, тухайн салбарын эрдэмтдийн болон хүрээлэнгийн үйл ажиллагааг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.	хүрээлэн, Палеонтологи, геологийн хүрээлэн, Шинжлэх ухааны академийн нэгдсэн байрны өргөтгөлийн барилгын ажлыг хийж гүйцэтгэх				бүрдийн Эх" ХХК шалгарч, барилга угсралтын ажил нь 3 дугаар давхрын карказ цутгалтын ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 30 гаруй хувьтай. 2020 оны улсын төсөвт 2000.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна. Монгол Улсын 2016-2020 оны төсвийн тухай хуулийн саналд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн, Палеонтологи, геологийн хүрээлэн барих хөрөнгийг тусгах санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна.	
104		2. Эрдэм шинжилгээний байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулж, их засварын ажлыг хийж гүйцэтгэх	2017 - 2020			Эрдэм шинжилгээний байгууллагуудын орчин нөхцөлийг сайжруулах, их засварын ажилд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын саналыг боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн боловч 2018 онд тус салбарт хөрөнгийн зардал батлагдаагүй. 2019 оны улсын төсөвт шинжлэх ухааны салбарын их засварын ажилд 294.6 сая төгрөг төсөвлөж 4 эрдэм шинжилгээний хүрээлэнг засварласан байна. 2020 оны улсын төсөвт шинжлэх ухааны салбарын их засварын ажилд 127.5 сая төгрөг батлагдсан.	100%
105		3. Докторын болон докторын дараах судалгаа, шинжилгээний ажлыг хүрээлэнгүүдэд хэрэгжүүлж, сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдлийг хангах	2018			Судалгааны их сургууль үндэсний хөтөлбөр, "Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх" үндэсний хөтөлбөр батлагдаж докторын болон докторын дараах судалгаа, шинжилгээний ажлыг хүрээлэнгүүдэд хэрэгжүүлэх замаар сургалт, эрдэм шинжилгээний ажлын нэгдлийг хангах асуудлыг шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэн. 2019 оны 9 дүгээр сард МУ-ын Ерөнхий сайдын ивээл дор зохион байгуулсан Шинжлэх ухааны ажилтны улсын анхдугаар их хурлын салбар хуралдаанаар шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг хөгжүүлэх асуудлыг хэлэлцсэн. Тус салбар хуралдаанаас	100%

					гарсан саналуудыг нэгтгэн, ангилж хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан. Төлөвлөгөөг "Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай" Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн тушаалаар баталлаа.	
106	3.2.42.Соёлын тухай хуулийг шинэчлэн баталж, киноны тухай, музейн тухай хуулийг боловсронгуй болгон хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	1. Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулах	2017		Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг төслийг боловсруулж БСШУС-ын сайдын 2019 оны 06 дугаар сарын 07-ны 1а/5215 албан бичгээр яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 9-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, 2019 оны 8 дугаар сарын 16 өдөр УИХ-д өргөн барьсан.	70%
107		2. Музейн тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2018		Музейн тухайн хуулийн үзэл баримтлалыг 2019 оны 7 дугаар сарын 10-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар батлуулсан. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн хуулийн төслийг боловсруулан, зардлын тооцоо болон үр нөлөөний судалгааны ажлын тайланг бэлтгэж байна.	70%
108		3. Киноны тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2017		"Кино урлагийг дэмжих тухай" хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулсан. Мөн Хуулийн төслийг боловсруулж Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 04 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.	70%
109		4. Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг	2018		Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж өргөн мэдүүлэх Соёлын өвийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэн 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.	70%

		боловсруулж, батлуулах				Хуулийн төсөлд нэмж тусгах 9 хэсэг, заалт, 16 хэсэг заалтад үг үсэг нэмж хасах, 29 хэсэг заалтын найруулгыг өөрчлөх, 1 бүлэг, 9 хэсэг заалтыг хасахаар тусгасан. Мөн энэ хуульд нийцүүлэн Газрын тухай болон Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсруулсан.	
110		5. Номын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, батлуулах	2018			Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагаж өргөн мэдүүлэх Номын сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулж Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 9-ний хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн.	70%
111		6. Соёлын өвийг хамгаалах, сэргээн засварлахад шаардлагатай бараа, ажил, үйлчилгээ худалдан авах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох	2017			Улсын Их Хурлын 2019 оны хаврын чуулганаар баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуулийн 34.1.2 дахь заалтын эрх гэсний дараа "соёлын биет өвийг" гэсэн утгыг нэмж оюуны өмчийн эрх, соёлын биет өвийг хамгаалах шаардлагаар гэрээний зохицуулалтыг боловсронгуй болгосон. Ингэснээр соёлын өвийг бүртгэх, судлах, хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах, худалдах, худалдан авах зэрэг соёлын биет өвийг хамгаалахтай холбоотой бараа, ажил, үйлчилгээг хөнгөн шуурхай зохион байгуулах эрх зүйн орчин бүрдсэн.	100%
112	3.2.43.Орчин үеийн музейн стандарт шаардлагыг хангасан байгалийн түүхийн музейг шинээр барина.	1. Музейн барилгын зураг төсвийг боловсруулж, барилга угсралтын ажлыг эхлүүлэх	2017 - 2020			Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн хуралдаанд "Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд Байгалийн түүхийн музейн шинэ барилгын талаар танилцуулга"-ыг боловсруулан, "Их тэнгэр"-ийн аман дахь газрын асуудлыг шийдвэрлүүлэх тэмдэглэлийг гаргуулсан.	100%

					Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 4 дүгээр сарын 23-ны өдрийн 165 дугаар тогтоолоор Байгалийн түүхийн музейн шинэ барилгын зураг төсөл боловсруулахад шаардлагатай 400.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас шийдвэрлүүлсэн. Барилгын зураг төсөв боловсруулах тендерт "Хатанбаатар" ХХК шалгарч ажлыг гүйцэтгэж байна. Түүнчлэн Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Байгалийн түүхийн музей барилга барих төсөл, арга хэмжээг 94.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2020 онд санхүүжих дүн 26.9 тэрбум төгрөгөөр баталсан.	
113	3.2.44.Үндэсний болон сонгодог урлаг, нүүдлийн соёл иргэншлийг төрийн ивээлд байлгаж, хүний нөөцийг бэлтгэх, хөгжүүлэх бодлогыг тодорхойлох, мэргэжлийн боловсон хүчнээр хангах, уран бүтээл туурвих, уран бүтээлчдийг урамшуулах санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, монгол хэл, бичгийн соёлыг хадгалах, хамгаалах, судлах, хөгжүүлэх,	1. Уран бүтээлийн үйлдвэрлэл дэх зохиогчийн эрхийн урамшуулал, түүний хэм хэмжээг тогтоосон эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож хэрэгжүүлэх	2018 - 2019		Оюуны өмчийн газартай хамтран Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд цахим болон харилцаа холбооны бусад сүлжээ, өргөн нэвтрүүлэг, олон суваг дамжуулагч, дуу хөгжим, дуу авиа бүхий дүрст бүтээлийн эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зохицуулалтыг тусгалаа. Хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2019 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар хэлэлцэж, УИХ-д өргөн барихаар шийдвэрлэсэн. Хуулийг шинэчлэн баталснаар дагаж гарах журмын төсөлд Уран бүтээлийн үйлдвэрлэл дэх зохиогчийн эрхийн урамшуулал олгох асуудлыг тусгаж хэрэгжилтийг хангах болно.	70%
114	урамшуулах санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох, монгол хэл, бичгийн соёлыг хадгалах, хамгаалах, судлах, хөгжүүлэх,	2. "Сонгодог урлаг-III" үндэсний хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг хангах	2017 - 2020		а) Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/236 дугаартай тушаалаар "Сонгодог урлаг-III" /2018-2023/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг баталлаа. Төлөвлөгөөнд 5 жилийн хугацаанд 6 зорилтын хүрээнд 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 91 бүтээгдэхүүн	100%

	<p>түгээн дэлгэрүүлэх, ном, бүтээл туурвих, соён гэгээрүүлэх монгол өв соёлын дархлааг бий болгох талаар цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.</p>				<p>үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2019-2023 онд нийт 15,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоо гарсан болно. б) Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны 03 дугаар сарын 25-ны “Чиглэл хүргүүлэх тухай” а/2210 дугаартай албан бичгээр “Сонгодог урлаг-III” үндэсний хөтөлбөрийг тогтоолын хамт 21 аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, уг тогтоолын 2 дугаар заалтад байгаа “орон нутагт дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон”-ыг уламжилж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг өглөө. в) БСШУС-ын сайдын 2019 оны "төлөвлөгөө батлах тухай" А/268 дугаар тушаалаар "Сонгодог урлаг-III" үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2018-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн баталлаа. Үндэсний хөтөлбөрт 6 зорилт 30 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээрх зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 91 бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр тусгагдан батлагдаад байна.</p>	
115	<p>3. Хүүхэд залуучуудад монгол ахуй, монгол өв соёлыг өвлүүлэх, дархлааг бий болгох, уран бүтээлийг дэмжих чиглэлээр үе шаттай арга хэмжээг</p>	2017 - 2020			<p>Засгийн газрын 2007 оны 280 дугаар тогтоолоор баталсан "Хүүхдэд зориулсан уран бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлэх" журмыг хэрэгжүүлэх зардал 2019 оны улсын төсөвт тусгагдаагүй улмаас хэрэгжилтийн ажил тасрахад хүрч байна. Иймд 2019 оныг Хүүхдэд зориулсан үзвэрийг дэмжих жил болгон зарлаж үйл ажиллагаа явуулж байна. Үүнд: “Музейн боловсрол”, “Хүүхэд залуучуудын уншлагыг дэмжих аян”, “Монгол наадгай”, “Урлаг + хүүхэд + боловсрол” аян өрнүүлэн ажиллаж байна. 1. Музейн боловсрол аяны хүрээнд Монголын түүх, соёл, зан заншил, үндэсний бахархалт үнэт зүйлсийг</p>	100%

		хэрэгжүүлэх			сурталчлан таниулах чиглэлээр 10 музей 11 тусгай үзэсгэлэн, 12 музей 14 боловсролын ажил 1 эрдэм шинжилгээний хурал зохион байгуулсан байна. Энэ өдрүүдэд музейгээр 48119 хүүхэд, 47410 том хүн, 1080 гадаадын иргэн, нийт 96609 хүн үйлчлүүлсэн байна. 2. "Монгол наадгай аян"-ы хүрээнд "Дэлхийд данслагдсан монгол өв-Монгол наадгай" Олон Улсын эрдэм шинжилгээний хурал, үндэсний тоглоом наадгай цуглуулагч, тоглоом наадгай үйлдвэрлэгч байгууллага иргэдийн хамтарсан үзэсгэлэн өдөрлөг, зохион байгууллаа. Өдөрлөгт 14 аймгийн өвлөн уламжлагч, нийслэлийн 4 дүүргийн 6 сургуулийн 5-7 дугаар ангийн 300 гаруй хүүхэд хамрагдаж, үндэсний тоглоом наадгайгаар тоглож суралцлаа. 3. "Урлаг + хүүхэд + боловсрол" аяны хүрээнд Улаанбаатар хотод зөвлөгөөн зохион байгууллаа. "Хүүхэд театр боловсрол" зөвлөгөөнд Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газар, Байгаль орчны яамны харъяа Цэнгэг усны нөөц, байгаль хамгаалах төв зэрэг байгууллагууд хамтран ажиллаж, хүүхдийн уран бүтээл туурвигчид, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих чиглэлээр ажиллаж буй төрийн болон төрийн бус байгууллагуудын 150 хүний төлөөлөл оролцлоо. Зөвлөгөөнд оролцогчид болон хүүхэд багачуудад Улсын Хүүхэлдэйн театр, Баянхонгор аймгийн хүүхдийн Тэмүжин театр, Орхон аймгийн Хүүхэд залуучуудын театрын уран бүтээлчид уран бүтээлийн дээжээс танилцууллаа.	
116		4. Монгол хэл, бичгийн соёлын судалгааг дэмжин жилд 10-аас доошгүй бүтээлийг	2017 - 2020		2019 оны эхний улиралд Соёл, урлагийг дэмжих санд Монгол хэл, бичгийн соёлын судалгааны чиглэлээр 36 нэрийн /1.3 тэрбум төгрөг/ ном бүтээлийг хэвлүүлэх хүсэлт ирсэн. Соёл, урлагийн дэмжих сангийн орон тооны бус мэргэжлийн зөвлөлийн 2019 оны хурлаар хэлэлцүүлсэн. "Зая	100%

		хэвлүүлэх			гэгээнтэн", "Ёст хаан Аригбөх", "Туульс хайлдаг уулс", "Хүн, араатан, бурхдыг сонсох ном", "Испани өгүүллэг, туужийн дээжис", "Дэлхийд тархсан Монгол өв" цуврал 4 боть каталоги, "Утга зохиолын судлал шинжлэл" цуврал 3 боть, "Алтан соёмбын эзэд", "Дэлхийн соёл", "Монголын хүүхдийн уран зохиолын судалгаа", "Монгол хэлцийн толь", "Монголын сүүлчийн эзэн хаан Богд Жавзандамба хутагт", П.Бадарчийн уран бүтээлийн 3 боть ном, "Долоон эгшиг, "Амьтад" зэрэг номыг хэвлэхэд 189,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэв.	
117	3.2.45.Улаанбаатар хотод ажиллаж байгаа төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн зориулалттай театр, соёлын төвүүдийн барилгын нөхцөл байдлыг үнэлж, мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах боломжийг судалж, хэрэгжүүлнэ.	1. Нийслэл хот дахь төрийн өмчийн мэргэжлийн урлагийн байгууллагууд болон Соёлын төв өргөө, Үйлдвэрчний эвлэлийн соёлын төв ордон, Нийслэлийн Залуучуудын соёлын төв зэрэг соёл, урлагийн зориулалтаар баригдсан барилга байгууламжийн ашиглалтын байдалд үнэлгээ хийх	2017		Нийслэл хот дахь төрийн болон орон нутгийн өмчийн соёл урлагийн зориулалттай барилгын тайзны ашиглалтад үнэлгээ хийж, мэргэжлийн соёл, урлагийн байгууллагуудыг уран бүтээл туурвих, тоглолт зохион байгуулах боломжийг судалж, хэрэгжүүлэхээр ажлыг эхлүүлж Соёлын төв өргөө, Улаанбаатар чуулгын байрны ашиглалтад судалгаа хийлээ. Соёлын төв өргөө тайзаа жилдээ 220 удаагийн тоглолт, 142 удаагийн бэлтгэл сургуулилт нийт 362 удаа буюу ашиглалт 99,1%, Улаанбаатар чуулга жилдээ 97 удаагийн тоглолт, 112 удаагийн бэлтгэл сургуулилт, захиалгат ажилд 189 удаа нийт 398 удаа буюу ашиглалт 100 % байна. Нийслэлийн Засаг даргатай зөвшилцөж Соёлын төв өргөө, Улаанбаатар чуулгын тайзыг мэргэжлийн урлагийн байгууллагууд шаардлагатай тохиолдолд чөлөөтэй ашиглаж байхаар шийдвэрлэлээ.	100%
118	3.2.46.Жил бүр	1. Жил бүр улсын	2017 -		2019 онд төр нийгмийн нэр зүтгэлтэн Монгол Улсын	100%

	үндэсний бахархал, эх оронч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэсэн түүхийн сэдэвтэй кино, тайз дэлгэц, утга зохиолын томоохон хэмжээний мэргэжлийн түвшний 1 бүтээл туурвихад санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.	захиалгаар түүхэн сэдэвт уран сайхны, бүрэн хэмжээний кино туурвих	2020			баатар Ю.Цэдэнбалын тухай "Түүхэн удирдагч" уран сайхны кино хийхэд Соёл, урлагийг дэмжих сангаас 800.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлэн кино бүтээх ажлыг эхлүүллээ. Киног бүтээх ажлыг "Хүмүн фильм" ТББ гүйцэтгэж байгаа бөгөөд 2019 оны 10 дугаар сарын 01-ний байдлаар зураг авалт дуусаж эвлүүлгийн ажил гүйцэтгэгдэж байна. Кино бүтээх ажлыг "Хүмүн фильм" ТББ гүйцэтгэж байгаа бөгөөд кино уран бүтээлийг бүрэн дуусгахад шаардлагатай хөрөнгийг Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн "Хөрөнгө гаргах тухай" 380 дугаар тогтоолоор батлуулан 500.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагад олгох, ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулан ажиллаж байна.	
119	3.2.47.Соёл урлагийн аялал жуулчлал хөгжүүлэх, гадаадад монголын үндэсний соёл урлагийг сурталчлах, үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн,	1. "Соёлын бүтээлч үйлдвэрлэл" хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2016 - 2020			Соёл, урлаг дэмжих сангаас санхүүжих төсөл, хөтөлбөрийн шалгаруулалтын үндсэн агуулгад тус үндэсний хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх талаар тусган хэрэгжилтийг ханган ажиллаж байна. "Соёлын үйлдвэрлэл" үндэсний хөтөлбөрийг 2019, 2020 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө батлуулж, соёлын үйлдвэрлэлийн үндсэн болон хамаарах салбар, бүтээгдэхүүний талаарх судалгааны ажлыг эхлүүллээ. Мөн хөтөлбөрийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардалд Соёл, урлагийг дэмжих сангаас 218.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон.	100%
120	үйлчилгээг бий болгох талаар тусгайлсан бодлого хэрэгжүүлнэ.	2. Монгол Улсын соёлын өдрийг гадаадад, бусад орны соёлын өдрийг өөрийн оронд зохион байгуулах	2017 - 2020			ОХУ-д Монгол Улсын соёлын өдрүүдийг зохион байгууллаа. /2019 он/ ОХУ-ын Санкт-Петербург хотноо Монголын соёлын өдрүүдийг дэлхийд гайхагддаг Капелла театрт 2019 оны 06-р сард амжилттай зохион байгууллаа. Соёлын өдрүүдийн хүрээнд Өнөөдрийн Улаанбаатар" гэрэл зургийн үзэсгэлэн, Кировын нэрэмжит цэцэрлэгт хүрээлэнд "Цагаан шөнө" задгай театрын тоглолт, "Петербург	100%

					<p>Монгол судлалын ууган төв болох нь” эрдэм шинжилгээний хурал, гар бичмэлийн үзэсгэлэн, Санкт-Петербургийн Улсын Их Сургуулийн Дорно дахин судлалын дээд сургуулийн Монгол, Төвд судлалын тэнхимийн төгсөгчдийн ёслолын арга хэмжээ, Рерихийн музейд Улаанбаатар хотын түүхээс сэдэвлэсэн гэрэл зургийн үзэсгэлэн, Петр хааны музей “Кунц камер”-т Халхголын байлдааны ялалтын 80 жилийн ойд зориулсан гэрэл зургийн үзэсгэлэн, “Мөнх хөх тэнгэрийн орон” дүрслэх урлагийн үзэсгэлэнг тус тус зохион байгууллаа. БНХАУ-д Монгол Улсын соёлын өдрүүдийг зохион байгууллаа. /2019 он/ Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай дипломат харилцаа тогтоосны 70 жилийн ойн хүрээнд монголын соёлын өдрүүдийн цуврал арга хэмжээ БНХАУ-ын Бээжин хотноо 2019 оны 12-р сарын 01-10-ны өдрүүдэд зохион байгууллаа. Соёлын цуврал арга хэмжээгээр монголын кино уран бүтээлчдийн “Итгэл”, “Алсын удирдлага”, “Халуун зүрх”, “Түцний охид” зэрэг 4-н уран сайхны киног Бүх хятадын кино архивын дэргэдэх кино танхимд болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотод нэгэн зэрэг нээлтийг хийж хятадын зах зээлд монгол киног албан ёсоор гаргах үүдийг нээлээ. Мөн Бээжин хотын Урлагийн үндэсний төвийн концертын танхимд Монгол Улсын Үндэсний урлагийн их театрын 50 гаруй уран бүтээлчид хятадын уран бүтээлчдийн хамтарсан тоглолт, Хятадын олон улсын соёлын солилцооны төвд монголын гэрэл зурагчдын нэгдсэн холбооны гишүүн Г.Ган-Өлзийгийн монголын онгон байгаль, дөрвөн улирлын өнгө аяс, манай ард түмний эрт, эдүгээгийн бүхий л төрхийг давтагдашгүй содон өнцгөөс авч чадсан “Хөх тэнгэрийн орноор” гэрэл зургийн үзэсгэлэн тус тус зохион байгуулагдлаа.</p>	
--	--	--	--	--	--	--

121		1. Музей, номын сангийн стандартыг шинэчлэн батлуулах	2018			1. Улсын стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн С/30 дугаар тогтоолоор "Архив, номын сангийн өв санг хадгалж хамгаалахад тавигдах шаардлага" MNS:ISO 11799:2019, "Номын сангийн орчны нөхцөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага" MNS 5472:2019 стандартууд тус тус батлагдсан. 2. Музейн стандартыг Музейн тухай хууль батлагдсаны дараа хууль тогтоомжтой уялдуулан батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.	70%
122	3.2.48.Музейн хадгалалт, хамгаалалтын шаардлагыг олон улсын стандартад хүргэж, хэрэгжилтийг хангана.	2. Улсын болон орон нутгийн 10 музейг стандартын шаардлага хангасан сан хөмрөгтэй болгох	2019 - 2020			2018 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 80.0 сая төгрөг хуваарилж, Монголын Үндэсний музейн 3 сан хөмрөг, Баян-Өлгий аймгийн 4 сан хөмрөг, Сэлэнгэ аймгийн музейн 3 сан хөмрөгийг стандарт шаардлагад нийцүүлэн засаж, шаардлагатай тавилга, техник хэрэгсэл, дохиоллын систем суурилуулсан. 2019 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 80.0 сая төгрөг хуваарилж, Монголын Уран зургийн галерейн уран зургийн сан хөмрөг, Монгол Цэргийн музейн уран зургийн сан хөмрөг, Монгол Улсын Үндэсний Номын сангийн үнэт ховор номын сан хөмрөгийн өрөөг засварлан шаардлагатай тоног төхөөрөмжийг суурилуулсан. 2019 оны 12 дугаар сарын байдлаар 6 музейн 13 сан хөмрөгийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулсан.	100%
123	3.2.49.Хөдөө орон нутагт хэрэгцээ, шаардлага, үйлчилгээний чанар, үр дүнтэй уялдуулан соёл урлагийн барилга	1. Орхон, Баянхонгор, Өмнөговь аймгийн музейн барилгыг шинээр барих	2017 - 2019			Өмнөговь аймгийн музейн барилгыг "Оюу толгой" ХХК-ий "Говийн оюу" хөгжлийг дэмжих сангийн 5.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 6 дугаар багийн нутаг дэвсгэрт музейн барилга угсралтын ажлыг эхлүүлсэн. Зураг төслийг "Балданс" ХХК 2009 онд гүйцэтгэсэн. Музейн барилга угсралтын ажлыг	70%

	байгууламжийг барих ажлыг үе шаттай зохион байгуулна.				<p>"Аглут" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2019 оны 12 сарын байдлаар барилга угсралтын гүйцэтгэл 90 орчим хувьтай явагдаж байна.</p> <p>Баянхонгор аймгийн музейн барилгын зураг төсөл болон техникийн нөхцөл, барилга барих газрын асуудлыг бүрэн шийдвэрлэж бэлтгээд байна. 2018 онд барилгын зураг төсвийг боловсруулах ажлыг "Лайк констракшн" ХХК орон нутгийн төсвийн 67.0 сая төгрөгөөр гүйцэтгэсэн болно. Музейн барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд шаардагдах 5,068.3 мянган төгрөгийг 2018, 2019, 2020 оны Улсын төсөвт тусгуулахаар яамны төсвийн багцад тусгуулан Сангийн яаманд хүргүүлсэн ч шийдвэрлэгдээгүй.</p> <p>Орхон аймгийн музейн барилгын зураг төслийг "Ин-диз" ХХК 2008 онд гүйцэтгэсэн. Өнөөдрийн байдлаар орон нутгийн Засаг даргын Тамгын газраас зураг төсөлд дахин магадлал хийх ажлыг гүйцэтгэж байна. Барилга барих газар болон техникийн нөхцөлийг бүрэн шийдвэрлэсэн. Музейн барилга угсралтын ажлыг эхлүүлэхэд шаардагдах 3,192.6 мянган төгрөгийг 2018, 2019, 2020 оны Улсын төсөвт тусгуулахаар яамны төсвийн багцад тусгуулан Сангийн яаманд хүргүүлсэн ч хасагдсан.</p>	
124		2. Архангай, Дундговь, Завхан, Төв аймгийн хөгжимт драмын театрын барилгыг барьж дуусгах	2017 - 2019		<p>Архангай аймгийн Хөгжимт драмын театрын барилга /Акми холдинг/ угсралтын ажил 80%-тай явж байна. Барилгын нийт төсөв 9.9 тэрбум төгрөг, 2019 онд 2.7 тэрбум төгрөг тусгагдсан, 2020 онд 3543.8 сая төгрөг батлагдсан. Хөгжимт драмын театрын барилга (Төв, Зуунмод сум) ажлын гүйцэтгэгч "Рендер БАУ" ХХК 2018 оны 8 дугаар сард улсын комисст хүлээлгэн өгсөн. Завхан аймгийн Хөгжимт драмын театрын барилга /Эл Би Си ХХК/ угсралтын ажил 80%-ийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Барилгын төсөв 9.9 тэрбум төгрөг, 2019 онд 4.1 тэрбум төгрөг тусгагдсан. БАУ хэвийн үргэлжилж байна. 2020 оны төсвийн</p>	70%

					төсөлд тусгагдаагүй нэмэлт санхүүжилт болох 3,495.3 сая төгрөгийг 2020 оны төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэх шаардлагатай. Дундговь аймгийн Хөгжимт драмын театрын барилга угсралтын зогссон "Суурь" ХХК-ийг шүүхэд шилжүүлэхээр шийдвэрлэсэн. Барилгын төсөв 6.8 тэрбум төгрөг, 2019 онд 2.0 тэрбум төгрөг тусгагдсан. Барилга угсралтын ажил 20 орчим хувьтай.	
125	3. Увс, Ховд, Булган аймгийн Хөгжимт драмын театр, Говьсүмбэр аймгийн чуулгын барилгыг шинээр барих	2018 - 2020			Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Аймгийн хөгжимт драмын "Ойрад" театрын барилга /Увс, Улаангом сум/ төсөл, арга хэмжээ 6.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдаж, орон нутагт тендерийн үйл ажиллагааг зохион байгуулж 2019 оны 9 дүгээр сарын 18-нд, "Дөрт Уул" ХХК шалгарч суурь цутгалтын ажил дууссан. Барилга угсралтын ажил 20 орчим хувьтай. 2020 оны Улсын төсөвт 4800.0 сая төгрөг тусгагдан батлагдсан. Говьсүмбэр аймагт чуулгын барилга барих хөрөнгийн асуудал шийдэгдээгүй тул Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Боржигон чуулгын гаднах талбайн тохижилт /Говьсүмбэр, Сүмбэр сум/ төсөл, арга хэмжээний 106.0 сая төгрөг батлагдаж, Харвайн толгой ХХК-иар их засварын ажлыг гүйцэтгэж, бүрэн ашиглалтад оруулсан. Ховд, Булган аймгийн Хөгжимт драмын театрын барилга барих хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	70%
126	4. Зарим дүүргийн соёлын ордон, сумын соёлын	2018 - 2020			Монгол Улсын 2019 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 2019 онд 6070 суудалтай, 46.7 тэрбум төгрөгийн өртөг бөхий 23 соёлын төв орон нутагт	70%

		төвийн барилгыг шинээр барьж ашиглалтад оруулах				шинээр ашиглалтад орсон. 2019 оны эцсээр барилга угсралтын ажил үргэлжилж байгаа 48 соёлын төв байна. - 70%-95% гүйцэтгэлтэй 8 соёлын төв, - 50%-69% гүйцэтгэлтэй 7 соёлын төв, - 30%-49% гүйцэтгэлтэй 11 соёлын төв, - 5%-29% гүйцэтгэлтэй 22 соёлын төв. Нийт 16 соёлын төвийн барилгад 3.3 тэр бум төгрөгийн төсөвт өртөг бүхий их засварын ажлыг хийж гүйцэтгэсэн.	
127		5. Урлагийн шилдэг уран бүтээл, номын сан, музейн зөөврийн үйлчилгээг алслагдсан аймаг, сум, дүүргийн хүн амд хүргэж үйлчлэх	2017 - 2020			Улсын Драммын Эрдмийн театрын шилдэг уран бүтээл "Тэнгэрийн хүү" түүхэн туульсийн, "Бүсгүйн зурвас", "Би эндээс явахгүй" орчин цагийн, "Бардам туулай" хүүхдийн жүжгийг 2019 оны 04 дүгээр сарын 24-27-ны өдрүүдэд Дорнод аймгийн Чойбалсан хотод , 04 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд Хэнтий аймгийн Чойбалсан хотод тоглож, нийт 7490 үзэгчийг хамруулсан. Тус тоглолтыг зохион байгуулахад 27.0 сая төгрөгийг зарцуулсан. Мөн Улсын дуурь, бүжгийн эрдмийн театрын шилдэг уран бүтээлийг 4-6 дугаар сард, Монгол Улсын Хүүхэлдэйн театрын уран бүтээлийг 09 дүгээр сард үзэгч олонд хүргэлээ. Төв, орон нутгийн 23 зөөврийн номын сан алслагдсан дүүрэг, сум, баг, эмэгтэйчүүдийн болон хүүхдийн хорих ангид 4775 уншигчид 6320 номоор үйлчилсэн байна.	100%
128	3.2.50.Соёл, урлагийг дэмжих сан байгуулна.	1. Соёл, урлагийг дэмжих сан байгуулах	2017 - 2020			Соёл, урлагийг дэмжих санд 2019 онд 2 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд тус сангаас санхүүгийн дэмжлэг үзүүлэх төслийн шалгаруулалтыг 2019 оны 03 дугаар сарын 04-ийг хүртэл зарлаж, төслийг хүлээн авч шалгаруулалтыг явуулсан. 2019 онд 212 нэрийн 27,0 тэрбум төгрөгийн төсөл сонгон шалгаруулалтад ирсэн. Соёл, урлагийг дэмжих сангийн орон тооны бус зөвлөлөөс 64 нэрийн 2,0	100%

					тэрбум төгрөгийн өртөг бүхий төслийг сонгон шалгаруулан хэрэгжүүлж, төслийн тайланг хүлээн авч дүгнэлээ.	
129	3.2.51.Чойжин ламын сүм музейг шинэчлэн засварлаж, Тоньюкукын цогцолборыг хамгаалах, музей байгуулах, Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалах, сэргээн засварлах, Эзэнт гүрэн музей байгуулах ажлыг зохион байгуулна.	1. Чойжин ламын сүмийг сэргээн засварлах	2017 - 2020		2017, 2018 онд Монголын Урлагийн зөвлөлтэй хамтран сүмийн цогцолборт археологийн, ургамлын нөмрөг болон мөөгөнцөрийн, геологийн, агаарын бохирдлын зэрэг 9 төрлийн эрсдлийн судалгааг гүйцэтгэн, эрсдлээс урьдчилан сэргийлэх, эрсдлийн нөлөөллийг бууруулах, арилгах талаар зөвлөмж боловсруулж хэвлүүлсэн. 2019 онд Эм Си Эс компанийн "Өв эрдэнэ" хөтөлбөрийн хүрээнд Чойжин ламын сүмийн цогцолборын тохижилтын ажлын зураг, төслийг боловсруулж, 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын даргаар батлуулсан. Төлөвлөгөөнд туссаны дагуу сүмийн цогцолборын 650 м2 явган хүний замыг шинэчлэх, зүлэг мод бут тарих, далд усалгааны систем болон шөнийн гэрэлтүүлэгийг суурилуулсан. Эдгээр арга хэмжээнд "Өв эрдэнэ" хөтөлбөрөөс нийт 400.0 орчим сая төгрөгийн санхүүжилтийг хийсэн. Чойжин ламын сүм музейн Занхан ба гол сумийн хоорондох залгаа танхимын дээврийг 178.2 сая төгрөгөөр сэргээн засварлаж, 2019 оны 8 дугаар сард ашиглалтад оруулсан. Чойжин ламын сүм музейн иж бүрэн сэргээн завсар, тохижилтын ажлын зураг төслийг боловсруулах ажлын эхлүүлэх шийдвэрийг 2019 оны 10 дугаар сард гарган ажиллаж байна. 2020 оны сайдын их засварын задаргаанд батлагдана.	100%
130		2. Тоньюкукын цогцолбор дурсгалыг хамгаалж, музей байгуулах	2017 - 2019		Музейн барилгын зураг төслийн ажил гүйцэтгэгч /Туркийн компани/-ийн буруугаас болж барилгын зураг бүрэн дуусаагүй тул барилга угсралтын ажлыг 2020 онд эхлүүлэх талаар Туркийн талаас мэдэгдсэн. Музейн барилга угсралтын ажилд	40%

					шаардагдах хөрөнгийг хоёр талын байгуулсан санамж бичгийн дагуу Туркийн Хамтын Ажиллагааны Агентлагаас санхүүжүүлэх бөгөөд урьдчилсан байдлаар 3,500.0 сая доллар төсөвлөөд байна.	
131		3. Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалж, музей байгуулах	2017 - 2020		Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийн хамгаалах чиглэлээр Монакогийн итгэлцлийн сангийн дэмжлэгтэйгээр “Майхан уулын Шороон бумбагар археологийн дурсгалыг хадгалах, хамгаалах, тогтвортой менежмент бий болгоход боловсон хүчнийг чадавхжуулах, олон нийтийн ухамсрыг нэмэгдүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд дурсгалт газарт хадгалалт хамгаалалтын чиглэлээр туршилт судалгааны ажил гүйцэтгэж, орон нутгийн ард иргэдэд дурсгалын нөхцөл байдлыг таниулж сурталчлах ажлыг зохион байгуулсан. Мөн ТИКА-ийн Улаанбаатар дахь хөтөлбөр зохицуулах газартай хамтран хэрэгжүүлж байгаа “Шороон бумбагарын бунхант булш, ханын зургийг хамгаалах” төслийн хүрээнд 2016-2019 онд дурсгалт газар руу эрчим хүчний агаарын шугам татах, дурсгалын орчимд ус зайлуулах далд хоолой суурилуулах, худаг гаргах зэрэг ажлыг хэрэгжүүлсэн. Бунхант булшийг авран хамгаалах зорилгоор буцаан булах, дэргэд нь музей-лаборатори байгуулах ажилд санхүүгийн болон мэргэжилтний туслалцаа үзүүлэх талаар Туркийн талтай урьдчилсан байдлаар тохирч, холбогдох мэдээ, тооцоо судалгааг хүргүүлээд байна.	70%
132	3.2.52.Биеийн тамир, спортын эрх зүйн орчинг боловсронгуй болгож нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх,	1. Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон холбогдох	2016 - 2018		Засгийн газрын 2019 оны 8 дүгээр сарын 21-ний өдрийн 335 дугаар тогтоолоор "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг батлуулсан.	100%

	үндэсний спортын өв соёлыг хөгжүүлэх, өвлөн уламжлах бодлого,	журмыг боловсруулан батлуулах					
133	тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлнэ.	2. Биеийн тамир, спортын цогц хөтөлбөрийг хуульд нийцүүлэн шинэчлэн баталж, хэрэгжилтийг хангуулах	2017			Засгийн газрын 2019 оны 8 дүгээр сарын 21-ний өдрийн 335 дугаар тогтоолоор "Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг батлуулсан.	100%
134		3. Үндэсний, багийн, өвлийн спортыг хөгжүүлэх ЗГ-ын төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх	2017			Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2014 оны 27 дугаар, 2015 оны 144 дүгээр зарлигийн хүрээнд өвлийн болон үндэсний спортыг хөгжүүлэх төлөвлөгөөний төслийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газар болон Спортын холбоодын дунд хэлэлцүүлэн саналыг авч боловсруулсан. Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2. дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын сайд эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, тэдгээрээс батлан гаргасан бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангана" гэж заасны дагуу БСШУС-ын сайдын 2017 оны А/423 дугаар тушаалын өвлийн болон үндэсний спортыг хөгжүүлэх төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний санхүүжилтийг Биеийн тамир, спортын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тухайн жилийн батлагдсан төсвийн хязгаарт багтаан санхүүжүүлж байна. Төлөвлөгөөнд үндэсний спортын чиглэлээр бодлогын түвшинд дэмжлэг үзүүлэх зорилгоор 8 арга хэмжээ, багийн спортын чиглэлд 13 арга хэмжээг тусган хэрэгжүүлж байна.	100%

135	4. Дотоодын болон олон улсын тэмцээн наадмын төрөл, чанарыг сайжруулан, тогтолцоог боловсронгуй болгох, спортыг эдийн засгийн эргэлтэд оруулах эрх зүйн орчин бүрдүүлэх	2017 - 2019			БСШУС-ын сайдын 2019 оны А/137 дугаар тушаалаар Монгол Улсад олон улсын 13 тэмцээн зохион байгуулж 1.3 тэр бум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Олон улсын тэмцээн зохион байгуулах 13 спортын холбоодтой ажил гүйцэтгэх гэрээ байгуулан ажиллаж байна. Одоогийн байдлаар тэмцээнүүд амжилттай зохион байгуулагдан дууссан бөгөөд гэрээний дагуу үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлан тооцоог хийж гэрээний акт үйлдэн үлдэгдэл санхүүжилтийг олгосон.	100%
136	5. Ерөнхий болон дээд боловсролын сургалтын байгууллагын биеийн тамирын хичээлийн хөтөлбөр агуулгыг боловсронгуй болгох	2017 - 2018			Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн төслийг харьцуулан судалж, дүгнэлт, санал гаргаж, Биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт нэмэлт өөрчлөлтийг оруулах төслийг боловсруулан 1-12 ангийн Биеийн тамирын хичээлийн агуулга, үнэлгээ шинэчлэгдэн БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/492 тоот тушаалаар батлан хэрэгжүүлж байна.	100%
137	6. Зарим үндэсний шигшээ багийн үйл ажиллагааг спортын мэргэжлийн холбоодтой хамтран хэрэгжүүлэх зохицуулалтыг хийх	2016 - 2020			Үндэсний шигшээ багийг спортын 16 төрлөөр спортын холбоодтой 2019 онд Улсын төсвөөс санхүүжүүлэх гэрээ байгуулан өдөр тутмын үйл ажиллагааны хүрээнд тамирчдын бэлтгэл цугларалтад гарах, олон улсын чанартай тэмцээн оролцох онгоцны билет захиалга, цалингийн зардлыг спортын холбоонд шилжүүлэн ажилласан.	100%

138	3.2.53.Спортын төв ордныг шинэчилж, олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн тартанан зам, өвлийн спортын ордон барина.	1. Спортын төв ордныг одоогийн сууринд шинэчлэн барих	2017 - 2019			Монгол Улсын 2016-2020 оны төсвийн тухай хуулийн саналд Спортын ордон шинэчлэн барих хөрөнгийг тусгах санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна. Мөн БСШУСЯ-ны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр энэхүү арга хэмжээг төлөвлөгөөнөөс хасуулах санал хүргүүлсэн.	Үнэлэх боломжгүй
139		2. Олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн тартанан зам барих	2017 - 2019			Олон улсын стандартад нийцсэн хөнгөн атлетикийн тартанан зам 2018 онд нийслэлд /Налайх дүүрэгт/ ашиглалтад орсноор улс, олон улсын чанартай тэмцээнүүд зохион байгуулагдаж байна.	100%
140		3. Олон улсын стандартад нийцсэн 400 метр тойрог зам, төвдөө 30м*60м хэмжээтэй "Өвлийн спортын ордон" барих	2017 - 2019			Монгол Улсын 2016-2020 оны төсвийн тухай хуулийн саналд Спортын ордон шинэчлэн барих хөрөнгийг тусгах санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна. Олон улсын стандарт нийцсэн хоккейн талбай бүхий 1000 хүний суудалтай цогцолборын барилга Нийслэлийн Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдөр ашиглалтад орсон. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор "Олон улсын залуучуудын спортын ногоон наадам"-ын хүрээнд Нийслэлийн Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт Дэлхийн стандартад нийцсэн иж бүрэн цогцолбор өвлийн спортын "Мөсөн өргөө" ордон баригдаж байна.	100%
141		4. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын ордон барих	2017 - 2019			БСШУСЯ-ны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр энэхүү арга хэмжээг үндсэн хэрэгжүүлэгчээр БСШУСЯ-ыг хасч, ХНХЯ-ыг оруулах саналтай байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын ордон барихад Монголын талаас хариуцах ажлын төсөв нь ХНХС-ын төсвийн багцад	Үнэлэх боломжгүй

					байгаа тул хасуулах саналтай байна.	
142	3.2.54. Спортын эрдэм шинжилгээ, спортын анагаах ухааныг хөгжүүлэх, тамирчдын бэлтгэл сургуулилт хийх таатай орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	1. Төгсөлтийн дараах сургалт, мэргэшлийн тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх	2017		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/839 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Спортын сургалт-дасгалжуулалтыг удирдах, спортын тэмцээнд оролцуулах үйл ажиллагаа эрхлэх, эрх олгох журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөлөөллийн хэсэгчилсэн шинжилгээ хийж, 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4150 дугаарт бүртгэгдсэн. Дасгалжуулагчийн төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрийг боловсруулж Биеийн тамир. спортын газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн А/60 тоот тушаалаар "Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулах орон тооны бус зөвлөл"-ийг байгуулан ажиллаж байна. Дасгалжуулагчийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг удирдан зохион байгуулах орон тооны бус зөвлөлийн анхдугаар хурлыг 03 дугаар сарын 29-ний өдөр хуралдаж зөвлөлийн 2019 оны ажлын төлөвлөгөө, төсвийн төсөл, сургалтын хөтөлбөр, хичээлийн хөтөлбөрийн төслийг хэлэлцэж, гишүүдийн саналыг тусган дахин боловсруулж, 4 дүгээр сарын 10-ны зөвлөлийн ээлжит бус хурлаар хэлэлцэж баталлаа.	100%
143		2. Биеийн тамир, спортын шинжлэх ухааны бие даасан бүтэц бий болгох	2018 - 2020		Засгийн газрын 2018 оны 11 сарын 14-ний өдрийн 47-р тэмдэглэлээр “Спортын шинжлэх ухааны төв байгуулах тухай” тэмдэглэл гарч Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан яамдаас санал авч нэгтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр тусгагдсан. Энэ дагуу “Спортын шинжлэх ухааны төв байгуулах тухай” Засгийн Газрын тогтоолын төсөл боловсруулж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 09	70%

					дугаар сарын 12-ны 1а/8130 тоот албан бичгээр Засгийн газрын гишүүдээс санал авч нэгтгэн, ЗГХЭГ-т Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Мөн спортын судалгаа, шинжилгээ, сорил, тест хийх үйл ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 270.0 сая төгрөгийн доод үе мөчний хөл эргометр, дээд үе мөчний гар эргометр, тамирчдын сэтгэл зүйн байдлыг тодорхойлох эгоскопи, хүний биеийн гадаргуу ба бүтцийг тодорхойлох багаж, биеийн баланс тодорхойлох багажаар хангаж, өмнөх онуудад хийгддэг байсан 3 төрлийн судалгаа, шинжилгээ, сорил, тестийг шинээр 9 төрлөөр нэмэгдүүлсэн. Судалгаа, шинжилгээ, сорил, тестэд нийт 410 өндөр зэрэглэлийн тамирчдыг хамруулж, дасгалжуулагч, спортын холбоо, клубд зөвлөгөө, зааварчлагчаа өгч ажилласан.	
144	3. Спортын төрлүүд болон дасгалжуулагч, арга зүйчдийн үйл ажиллагааны стандартыг боловсруулж, хэрэгжүүлэх	2017 - 2020			Спортын орчин, хэрэглэл, материал, сургалтын стандартыг боловсруулж, батлуулах ажил үргэлжилж 2018 онд 13 стандартыг батлуулсан. Бадминтон, буудлага спорт, хөнгөн атлетик, жүдо бөхийн стандартын эхний төслийг спортын холбоодтой хамтран боловсруулсан. "Биеийн тамирын арга зүйчид мэргэжлийн зэрэг олгох журам"-ыг боловсруулж, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/319, А/176 тоот хамтарсан тушаалаар батлан, хэрэгжүүлж байна.	100%
145	4. Үндэсний шигшээ багийн /өсвөр, оюутан, залуучууд, насанд хүрэгчид/ үйл ажиллагааг	2017 - 2019			БСШУС-ын сайдын 2018 оны А/167 дугаар тушаалаар "Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх, спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам"-ыг баталсан. Үндэсний шигшээ багийг спортын 17 төрлөөр 160 тамирчин, дасгалжуулагчтайгаар бүрдүүлж гэрээгээр төрийн зарим чиг үүргийг	100%

		нэгдсэн зохион байгуулалтад оруулж, сургалт-дасгалжуулалтын уялдааг хангах				гэрээгээр гүйцэтгэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Биеийн тамир, спортын газраас насанд хүрэгчид, залуучуудын шигшээ багийг улсын төсвөөс санхүүжүүлэх гэрээг спортын 16 холбоотой байгуулан, жилийн эхэнд сургалт дасгалжуулалтын нэгдсэн төлөвлөлтийг баг тус бүр дээр жил, улирлаар задлан баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Өсвөрийн шигшээ багийн сургалт дасгалжуулалтын төлөвлөгөөг аймгийн Биеийн тамир, спортын газраас батлан салбар спортын холбоотой хамтран хэрэгжүүлж байна.	
146		5. Спортын салбарын мэдээллийн технологийн сан байгуулах	2017 - 2019			Салбарын мэдээллийн портал www.sport.gov.mn цахим хуудсыг өргөжүүлж, биеийн тамир, спортын салбарын үйл ажиллагааны мэдээлэл нэгдсэн байдлаар мэдээлэлийн санд орж цахимжсан. Үүнд 21 аймаг, 9 дүүргийн Биеийн тамир, спортын газар, спортын холбоод хамрагдсан. Улсын хэмжээнд анх удаа Биеийн тамир, спортын салбарын улсын тооллогыг зохион байгуулж, спортын “data base”-ийн мэдээлэл, мэдээллийн урсгал, зураглал гаргах ажлын хэсгийг БТСГ-ын даргын 2017 оны А/140 дүгээр тушаалаар байгуулж, цахим сангийн бүтэц, хамрах хүрээ, мэдээлэл, мэдээллийн урсгалыг бий болгосон. ТЭЗҮ-ийг боловсруулсан.	100%
147	3.2.55.“Спортыг дэмжих сан” байгуулна.	1. Спортыг дэмжих сан байгуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх	2017			Засгийн газрын 2017 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 23 дугаар тогтоолоор “Спортыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах журам”-ыг баталсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Бүрэлдэхүүн батлах тухай” 2019 оны 03 дугаар сарын 19-ний А/105 дугаар тушаалаар “Спортыг дэмжих сан”-ийн удирдах зөвлөлийг байгуулсан. Удирдах зөвлөлийн хуралдаанаар иргэд, спортын холбоод, төрийн болон төрийн бус байгууллагаас ирүүлсэн нийт 86 төслийг хэлэлцэн дүгнэлт гаргасан.	100%

					Ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн БСШУСайдын 2019 оны 05 дугаар сарын 03-ны А/286 дугаар тушаалаар 21 төсөл, арга хэмжээнд 1.3 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн үйл ажиллагааг эхлүүлсэн. Гэрээ байгуулсан төслүүд дээр хяналт шинжилгээ дотоод аудитын газраас хяналт хийж байна. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 9 дүгээр сарын 12-ны өдрийн А/578 дугаар тушаалаар өвлийн спорт, нийтийн биеийн тамирын чиглэлээр 11 төсөлд 621.586.900 төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн. Санхүүжилтийг ЗГХА БТСГ-т шилжүүлж, тухайн байгууллагатай гэрээ хийж, хяналт тавин ажилласан.	
148	3.2.56.Нийтийн биеийн тамир, иог, бясалгал, зохистой хөдөлгөөн /фитнес/-ээр хичээллэх, өвчнөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулна.	1. Нийтийн биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн үйлчилгээ эрхэлдэг байгууллагын үйл ажиллагааг магадлан итгэмжлэх арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх	2017 - 2019		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/178, А/144 дүгээр хамтарсан тушаалаар “Спортын клубийг магадлан итгэмжлэх журам, шалгуур үзүүлэлт, үйлчилгээний төлбөрийн хэмжээ тогтоох тухай” журам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны А/187 тоот тушаалаар “Спортын клубийг магадлан итгэмжлэх хараат бус шинжээчийн үйл ажиллагааны журам”-ыг тус тус батлуулсан. Магадлан итгэмжлэлийн журмын дагуу биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 29 спортын клубийг магадлан итгэмжлэлд хамруулж, 13 спортын клуб магадлан итгэмжлэгдсэн.	100%
149		2. Хүн амын бие бялдрын хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үйл ажиллагааг	2017 - 2020		Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорилын стандарт боловсруулах Биеийн тамир, спортын газрын даргын 2019 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн А/170 тоот тушаалаар ажлын хэсэг шинээр байгуулагдан судалгааны ажил хийж байна. Энэхүү сорилд 2018 онд 218761 хүн, 2019 онд 339346 хүн	100%

		тогтмолжуулж, үзүүлэлтийг сайжруулах				хамрагдсан байна.	
150		3. Иргэдэд биеийн тамир, спортоор хичээллэж эрүүл мэндээ хамгаалсны төлөө эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох ажлыг эхлүүлэх	2017 - 2018			Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн А/178.А/144 тоот хамтарсан тушаалаар "Спортын клубийн магадлан итгэмжлэх журам, магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлт, магадлан итгэмжлэх үйлчилгээний төлбөрийн хэмжээг тогтоох журам"-ыг баталсан журмыг Нийгмийн эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт хүргүүлж тус байгууллага нь биеийн тамир, спортоор хичээллэж эрүүл мэндээ хамгаалсны төлөө магадлан итгэмжлэгдсэн спортын клубт хичээллэгч иргэдэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал олгох журам"-ын баталсан. Магадлан итгэмжлэлд хамрагдсан 4 спортын клубын материалыг ЭТД-ын Ерөнхий газарт хүргүүлсэн.	100%
151	3.2.57.Үндэсний соёл, урлагийг шинэ шатанд гаргах зорилгоор “Үндэсний байгалийн музей, театр, урлагийн цогцолборууд”-ыг байгуулж, соёлын үнэт зүйлс, биет болон биет бус өвийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулна.	1. “Чулуун соёлын өв” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017 - 2020			Засгийн газрын 2019 оны "Үндэсний хөтөлбөр батлах тухай" 69 дүгээр тогтоолоор "Чулуун соёлын өв" хөтөлбөрийг батлуулсан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг БСШУС-ын сайдын 2019 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн "Төлөвлөгөө батлах тухай" А/368 тоот тушаалаар баталж, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Соёл, урлагийн газар болон Соёлын өвийн үндэсний төвд хүргүүлсэн. Төлөвлөгөөний дагуу 2019 онд Чулуун соёлын өвийг бүртгэх арга зүйг шинээр боловсруулах, Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын нутагт орших Уушгийн өврийн буган чулуун хөшөө бүхий цогцолбор, Архангай аймгийн Өндөр-Улаан сумын нутагт орших Их Жаргалантын буган чулуун хөшөө бүхий цогцолбор, Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхар чулууг кадастрын бүртгэлд	100%

					бүртгүүлэх, Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт орших Баруун элэгний бичээс, Дундговь аймгийн Өлзийт сумын нутагт орших Дэл уулын хадны зураг, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших Жаргалантын ширээний хадны зургийн хэв хуулбар, дардсыг авч хадгалах, Хөтөч тайлбарлагчдад зориулсан сургалт зохион байгуулах гэсэн 8 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, өнөөдрийн байдлаар 100 %-ийн гүйцэтгэлтэй байна. Мөн 2019-2020 онд хэрэгжүүлэхээр 5 арга хэмжээг төлөвлөж, эхлүүлээд байна.	
152		2. “Соёлын биет бус өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017 - 2020		а) Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн “Төлөвлөгөө батлах тухай” А/235 дугаартай тушаалаар “Соёлын биет бус өвийг хамгаалах” /2019-2023/ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх дунд хугацааны төлөвлөгөөг боловсруулан баталсан. Төлөвлөгөөнд 5 жилийн хугацаанд 4 зорилтын хүрээнд 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 59 бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэхээр тусгагдсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2019-2023 онд нийт 11,8 тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоо гарсан болно. б) Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайдын 2019 оны 03 дугаар сарын 25-ны “Чиглэл хүргүүлэх тухай” а/2210 дугаартай албан бичгээр “Соёлын биет бус өвийг хамгаалах” үндэсний хөтөлбөрийг тогтоолын хамт 21 аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлж, уг тогтоолын 2 дугаар заалтад байгаа “орон нутагт дэд хөтөлбөрийг баталж, хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосон”-ыг уламжилж, хэрэгжилтийг хангаж ажиллах талаар үүрэг өглөө. в) БСШУС-ын сайдын 2019 оны "Төлөвлөгөө батлах тухай" А/235 дугаар тушаалаар "Соёлын биет бус өвийг хамгаалах"	100%

					үндэсний хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2019-2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөн баталлаа. Үндэсний хөтөлбөрт 4 зорилт 13 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээрх зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 59 бүтээгдэхүүн үйлчилгээний хүрээнд төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхээр батлан хэрэгжүүлж байна.	
153		3. “Соёлын баримтат өвийг хамгаалах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2017 - 2020		“Соёлын баримтат өвийг хамгаалах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: “Үндэсний бичиг үсгийн баяр - 2019” арга хэмжээг 05 дугаар сарын 03-12-ны өдрүүдэд зохион байгуулж, нэгдсэн хөтөлбөр, удирдамжийн дагуу 21 аймаг, нийслэлд 129 ажлыг хэрэгжүүллээ. Тус арга хэмжээнд 23.0 сая төгрөгийг зарцуулсан болно. “Соёлын баримтат өвийг хамгаалах” хөтөлбөрийн зорилго зорилтод нийцүүлэн "Монголын хөгжмийн зохиолчдын баримтат өвийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэх" төслийг хэрэгжүүлэхэд 10.0 сая төгрөг зарцуулаад байна. Мөн Монгол кино нэгтгэлийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа соёлын баримтат өв болох Монгол киноны дуу, хөгжмийн санг дижитал хэлбэрт шилжүүлэх, бүртгэлжүүлэх төслийг хэрэгжүүлэхээр яамны дэргэдэх Соёл, урлаг дэмжих сангаас 5.5 сая төгрөгийг зарцуулсан. /БСШУС-ын сайдын 2019 оны "Зардал батлах тухай" А/350 дугаартай тушаалаар баталсан./ Төсөлд Монголын хөгжмийн зохиолчдын холбоо, "Мөрдорж сан" болон Монгол Улсын консерватор хамтран оролцсон.	100%
154		4. Циркийн сургуулийн барилгыг шинээр барьж, Хөгжмийн их сургууль	2018 - 2020		Газар, зураг төсөл бэлэн болсон. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 1а/8949 тоот буюу “Боловсролын салбарт 2017-2020 онуудад хэрэгжүүлэх төрийн өмчит концессын төсөл, арга	70%

		шинээр байгуулах			хэмжээний жагсаалтыг хүргүүлэх тухай” албан бичгээр Сангийн сайдад санал хүргүүлсэн ч төсөв батлагдагүй. Төрийн өмчит Улсын цирк байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан, яамдаас санал авч нэгтгэн БСШУС-ын сайдын 2018 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1А/12694 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлэв. Монгол Улсын ардын жүжигчин, Төрийн шагналт С.Гончигсумлаагийн нэрэмжит Хөгжим бүжгийн коллеж 2017 оны долдугаар сарын 24-ний өдөр албан ёсоор Хөгжим бүжгийн их сургууль буюу консерватор болж, үйл ажиллагаа хэвийн явагдаж байна..	
155		5. Соёлын өвийн төвийн барилгыг барьж дуусгах	2017		Соёлын өвийн төвийн барилга угсралтын үндсэн ажил 2018 онд бүрэн дууссан. Гүйцэтгэгч "Заг" ХХК-иас 2019 онд барилгын доторх цахилгаан, холбоо, дохиоллын монтажийн ажил болон дотор засал чимэглэлийн үлдсэн ажлыг хийж гүйцэтгэлээ. Барилга угсралтын ажил 98 хувьтай. Эрүүл мэндийн яамны Төрөх шинэ эмнэлгийн барилгын гадна шугам сүлжээнээс холболт хийгдэхээр хүлээгдэж байна. 400 метр хашааны ажлыг гүйцэтгэхэд зориулан сайдын 2019 оны А/112 дугаар тушаалаар 50.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчийг шалгаруулан 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдөр улсын комисс хүлээн авсан.	100%
156		6. Үндэсний номын сангийн барилгыг барьж дуусгах	2017 - 2019		Үндэсний номын сангийн барилга угсралтын ажлын гүйцэтгэл 80 хувьтай хэрэгжиж байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулиар тус барилгын нийт төсөвт өртөг 18.9 тэрбум төгрөг болж, 2020 оны улсын төсвөөр санхүүжих дүн нь 10.2 тэрбум төгрөг болсон.	70%
157		7. Хүүхдийн төв	2018 -		Газрын асуудал нийслэлийн дахин төлөвлөлтөөр	40%

		номын сангийн барилгыг шинээр барих	2020			шийдвэрлэгдэхээр болсон. Тус номын сангийн барилгын газар чөлөөлөх болон зураг төслийн зардлыг улсын төсөвт тусгах саналыг 2017, 2018, 2019 онд Сангийн яаманд хүргэсэн боловч батлагдаагүй. БСШУСЯ-ны 2019 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн 1а/4417 тоот албан бичгээр ЗГҮАХХАХТ-өөс хасуулах саналыг ЗГХЭГ-т хүргүүлсэн. Мөн Засгийн газрын 2019 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанд танилцуулсан 2024 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөгөөний саналд тусгасан.	
158	3.2.58.Соёл, шинжлэх ухааны салбарын ажиллагчдын хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлнэ.	1. Соёл, урлагийн ажилтны цалинг үе шаттайгаар нэмэгдүүлэх	2018 - 2019			Соёл, урлагийн салбарын ажилчдын цалин хөлс төрийн үйлчилгээний бусад ажилчдаас харьцангуй доогуур байсныг Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолоор батлуулж, тус салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчилснээр соёл, урлагийн ажилтны цалин 16-36 хүртэл хувиар өссөн. Төрийн албан хаагчдын цалингийн сүлжээ болон доод жишгийг 2019 оны Засгийн газрын 24, 472 дугаар тогтоолоор тус тус 8 хувиар нэмэгдүүлснээр 2020 оны 1 дүгээр сараас соёл, урлагийн ажилтны цалин 32-52 хувиар нэмэгдлээ.	100%
159		2. Соёл, урлагийн ажилтны зэрэг, дэвийн нэмэгдлийг олгох журам батлуулж хэрэгжүүлэх	2018			Соёл, урлагийн ажилтны зэрэг, дэвийн нэмэгдлийг олгох журам батлуулж хэрэгжүүлэх ажлын хүрээнд: 1. "Соёл, урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл"-ийн төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолоор батлуулсан. 2. Соёл, урлагийн ажилтны мэргэшлийн нэмэгдэл олгох заалтыг Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгасан. 3. Засгийн газрын 2018 оны "Журам батлах тухай" 382 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон	100%

					үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл олгох журмыг хэрэгжүүлэх зорилгоор соёлын ажилтанд ур чадвар болон мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг боловсруулж, БСШУССайдын 2019 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 16/9563 тоот албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгаалын сайд С.Чинзоригт хүргүүлсэн.	
160	3.2.59.Үндэсний урлагийг дэмжих бодлогын хүрээнд Үндэсний урлагийн Их театр барих ажлыг эхлүүлнэ.	1. Үндэсний урлагийн Их театр барих ажлыг эхлүүлэх	2018 - 2020		Монгол Улсын Ерөнхий сайдаас 2019 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд, Сангийн сайд болон Засгийн газрын гишүүдэд Байгалийн түүхийн музей, Үндэсний урлагийн их театр барих ажлыг эхлүүлэх үүрэг өгсөн. Үүний дагуу Ерөнхий сайдын “Ажлын хэсэг байгуулах тухай” 44 дүгээр захирамжаар Байгалийн түүхийн музей, Үндэсний урлагийн их театрын газрын асуудлыг цогцоор нь шийдвэрлэх, барилгын зураг, төсвийг боловсруулах, холбогдох тооцоо, судалгааг хийх, барилгын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар Үндэсний урлагийн их театр, Байгалын түүхийн музейн шинэ барилгын зураг төсөл гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, Засгийн газрын 165 дугаар тогтоолоор 800.0 сая төгрөгийг Засгийн газрын нөөц сангаас гаргахаар шийдвэрлэв. “Үндэсний урлагийн их театрын барилгын зураг, төсөв боловсруулах” төслийг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээ үзүүлэх тендер зарлаж “Building’s technology” ХХК шалгаран барилгын зураг төслийн ажлыг гүйцэтгэж байна. Үндэсний урлагийн их театрын барилгын барих газрыг Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/794 дүгээр Захирамжаар Хан-Уул	40%

					дүүргийн 15 дугаар хорооны нутаг дэвсгэрт 4 га тайлбайг олгосон ч газрын асуудал шүүхийн маргааны улмаас зогсонги байдалтай байна. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тус театрын барилгыг 152,520.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, тус онд санхүүжих дүн 5,000.0 сая төгрөгөөр баталсан.	
161	3.3.7.Өндөр технологийн 2000 энтрепренёр мэргэжилтнийг бэлтгэнэ.	1. Мэдээлэл харилцаа холбооны технологийн чиглэлийн энтрепренёр бэлтгэх	2016 - 2020		Монгол Улсын БСШУСЯ, СЯ, БНСУ-ын Олон улсын хамтын ажиллагааны байгууллага (КОЙКА) хооронд байгуулсан хамтын ажиллагааны хэлэцээрийг 2019 оны 01 дүгээр сарын 15-нд хийсэн. Мэдээлэл холбооны технологийн салбарын чадавхийг сайжруулах, орчин үеийн өндөр технологийн лаборатори байгуулах зорилгоор "ШУТИС-ийн Мэдээлэл холбооны технологийн сургуулийн чадавхийг бэхжүүлэх төсөл"-ийг 2019-2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. 2019 онд Эрдэм шинжилгээ, инновацийн төв байр ашиглалтад орсон.	Үнэлэх боломжгүй
162		3. Их, дээд сургууль, МБСБ-ын төгсөгчдийг гадаад орны өндөр технологи эзэмшүүлэхтэй холбоотой хуул, эрх зүйн орчныг бүрдүүлэх	2016 - 2020		ШУТИС нь Европын кредит хөрвүүлэх системийг дүйцүүлэн олон улсын их, дээд сургуульд үргэлжлүүлэн суралцах нөхцөлийг хангах зорилготой PAWER төслийг хэрэгжүүлж байна. Ингэснээр ШУТИС-д шилжин суралцах бол Европын кредит хөрвүүлэх системийг, ШУТИС-ийн окутны үнэлгээг Европын их, дээд сургуулиудын үнэлгээнд дүйцүүлэн шилжүүлэх талаар сургалтууд зохион байгуулагдсан.	Үнэлэх боломжгүй
163	3.3.11.Багш, эмч, эмнэлгийн ажилтнуудын ажлын ачаалал, ур чадвар, мэргэшил, ажлын үр дүн, ажилласан жил	3. Багш нарын ажлын үр дүнг харгалзсан урамшууллын эрх зүйн орчныг боловсронгуй	2017 - 2020		Засгийн газрын 2019 оны 1 дүгээр сарын 16-ны 24, 25 дугаар тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" болон "Төрийн үйлчилгээний зарим албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай" баталсан.	100%

	зэргээс хамаарсан цалин хөлс, урамшууллын тогтолцоог бий болгоно.	болгож, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол олгох сургуулийн төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлийг шинэчлэх				
164	3.3.28.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн амьдралд хэвийн оролцох боломжийг бүрдүүлэх бодлого баримтална.	5. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлэх	2017 - 2020		Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоог дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3.3.1 дэх заалтын хэрэгжилтийг ханган ЕБС-ийн 100 багшид сургалтыг явуулсан нь ер дүнтэй болсон. “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй” сэдэвт сургалтад 50 багшийг хамруулж, багш нарт шаардлагатай мэдлэг ойлголт, ур чадварыг олголоо. 2019 оны 12 дугаар сард нийслэлийн 6 дүүргийн сургалтын менежер, нийгмийн ажилтан, багш нийт 500 хүнийг “Аутизмын хүрээний эмгэгтэй хүүхдийг боловсролд хамруулах нь” сургалтад хамруулж сургалтын материалыг DVD хэлбэрээр бүх аймгуудад хүргүүлсэн. мөн төлөвлөгөөний 2.1.10 дахь заалтыг хэрэгжүүлэн Брайль үсгийн стандартын төслийг боловсруулан Стандарт хэмжилзүйн газрын 2019 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн Эрүүл мэнд эмнэлгийн тусламж, үйлчилгээний стандартчиллын техникийн хороогоор хэлэлцүүлэн гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдэн 2019 оны СХЗГ-ын даргын С/58 тоот тушаалаар “Монгол брайль бичгийн стандарт” MNS6800:2019 батлагдсан. Энэ стандарт батлагдсанаар хараагүй болон харааны	Үнэлэх боломжгүй

					бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд бусад хүмүүсийн нэгэн адил тэгш оролцох, бусад хүмүүс харааны бэрхшээлтэй иргэдтэй брайль үсгээр дамжуулан харилцах, бие биедээ туслах, харилцан суралцах боломж бүрдэж, харилцааны чухал хэрэглүүр болох юм. Багш нарт брайль үсгийн анхан шатны мэдлэг олгох, насан туршийн боловсролын төвөөр дамжуулан бичиг үсэг тайлагдаагүй харааны бэрхшээлтэй хүнд бичиг үсэг заах зэрэг ажлуудыг хэрэгжүүлнэ.	
165	3.3.29.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үеийн найзуудтайгаа хамт суралцах нөхцөлийг бүрдүүлж, шаардлагатай дэд бүтцийг сайжруулна.	1. Бүх шатны боловсролын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцахад ээлтэй сургалтын орчныг бүрдүүлж, хүртээмжийг сайжруулахад шаардлагатай хөрөнгийг шийдвэрлүүлэх	2017 - 2020		2019 онд сургуулийн гадаад, дотоод орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал, ерөнхий шаардлага MNS2019:6782” стандарт, дотуур байранд амьдарч буй сурагчдын сурч хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлж, хүүхдийн эрхийг дээдэлсэн, тэдний сэтгэл хангалуун, амжилттай сурч хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор “ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын дотуур байрны орчин, үйлчилгээ, ерөнхий шаардлага MNS2019:6781” стандартыг Стандартчилал хэмжил зүйн газрын даргын 2019 оны 40 дүгээр тушаалаар тус тус батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2019-2020 оны хичээлийн жилд Дэлхийн банкны санхүүжилтээр ЕБ-ын 29,116 дугаар сургуульд 120.0 мянган долларын сургалтын хэрэглэгдэхүүний худалдан авалтыг хийсэн байна. Мөн 10 аймагт хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг дэмжих танхим байгуулахаар бэлтгэл ажил хийгдэж байна. Ерөнхий боловсролын 25.55.63.70.116 дугаар сургуулийн сургалтын орчныг сайжруулахад 30.0 мянган долларын санхүүжилт хийгдсэн байна.	Үнэлэх боломжгүй
166	3.3.30.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд	2. Хүүхдийн хөгжлийн	2016 - 2020		2019-2020 оны хичээлийн жилд 21 аймаг 9 дүүрэгт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд,	Үнэлэх боломжгүй

	сурах, хөгжих үйлчилгээ үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлнэ.	бэрхшээл, чадварыг илрүүлэх, тодорхойлох, хүүхдийн хөгжлийн цогц хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төв болон салбар комиссыг байгуулан, үйл ажиллагааг тогтмолжуулах				боловсрол, нийгмийн хамгааллын комисс" байгуулагдан тогтмол ажиллаж 8956 комиссын хуралдаанаар орсон байна. Эдгээрээс: ХБ –г тогтоосон: 7594 Байнгын асаргаа шаардлагатай болохыг тодорхойлсон 1628 Байнгын асаргаа шаардлагатай хугацаа сунгасан 5228 Байнгын асаргааг цуцлах шийдвэр 476 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд 2031 хүүхдийг Сургуулийн өмнөх боловсролд 508 хүүхдийг Ерөнхий боловсролын сургуульд 814 хүүхдийг Ерөнхий боловсролын тусгай сургуульд 242 хүүхдийг Боловсролын бусад үйлчилгээнд 570 хүүхдийг хамруулах шийдвэр гарган холбон зуучилсан байна. Мөн бүх аймаг, дүүрэгт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл" байгуулагдсан байна.	
167	3.3.31.Өрх толгойлсон болон бага орлоготой өрхийн гишүүдэд үзүүлэх дэмжлэг, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого баримтална.	1. Өрх толгойлсон эх /эцэг/ болон бага орлоготой өрхийг дэмжих эрх зүйн орчныг боловсронгуй болгож, өрхийн мэдээллийн нэгдсэн санг ашиглан тэдэнд үзүүлэх боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах нөхцөл боломжийг	2016 - 2020			Их, дээд сургуулийн оюутнуудад эрүүл мэндийн боловсрол олгох, окутанд хандсан нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх, эрүүл мэндийн даатгалд хамрагдахад зөвлөн туслах, анхан шатны тусламж үйлчилгээг их, дээд сургуулийн "Эрүүл мэндийн төв"-өөр дамжуулан хэрэгжүүлж байна.	Үнэлэх боломжгүй

		бүрдүүлэх					
168	3.4.2. Гэр бүлийн үнэт зүйлсийг бэхжүүлж, хүчирхийллийг бууруулах, хүчирхийлэлд өртөгчдийг хамгаалах, гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ.	2. Гэр бүлийн боловсрол олгох хичээлийг зааж эхлэх	2017 - 2020			2019 онд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын “Сургалтын хөтөлбөр шинэчлэн батлах тухай” 2019 оны А/390 дүгээр тушаалаар бага, дунд, ахлах ангийн сурагчдын судлах “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрийг баталсан. Дунд, ахлах ангийн “Иргэний ёс зүйн боловсрол” сургалтын хөтөлбөрт "Гэр бүлийн харилцаа", "Монголчуудын удам судар", "Ураг удмаа танин мэдэхийн ач холбогдол", "Ирээдүйн эцэг эхийн гэр бүлийн өмнө хүлээх үүрэг хариуцлага", "Гэр бүлийн гишүүдийг асарч, энэрэх", "Гэр бүлийн гишүүдэд туслах, тэднийг хүндлэх, ачийг хариулахын ач холбогдол" зэрэг сэдвүүд шинээр нэмэгдэж сурагчид судалж эхлээд байна. Мөн сургууль, багш нар нь "Иргэний ёс зүйн боловсрол" сургалтын хөтөлбөрийн дагуу эцэг эхчүүд, асран хамгаалагчдад зориулсан сургалт, зөвлөгөө, харилцан санал, туршлага солилцох ярилцлага, нэгдмэл ойлголт хандлага тогтоох арга хэмжээг хариуцан гүйцэтгэх эрх зүйн орчныг бүрдүүллээ.	Үнэлэх боломжгүй
169	3.4.6. Бага насны хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх, эцэг эхийн хариуцлагыг өндөржүүлж, хүүхдийн осол, эндэгдлийн түвшинг 2 дахин бууруулна.	2. "Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх" үндэсний хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх	2017 - 2020			Эрүүл мэндийн яамнаас боловсруулж буй “Осол гэмтэл, хүчирхийллээс сэргийлэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулах салбар хоорондын хамтарсан ажлын хэсэгт орж ажиллан, үндэсний хөтөлбөрт санал өгсөн. Хүүхдийг осол, гэмтлээс сэргийлэх эцэг, эхийн хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр “Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний цогц хөтөлбөр /2017-2021 он/-т дараах заалтыг тусгасан. Үүнд: • 3.1.1.3-т “хүүхдийн сэргийлж болох өвчин, эндэгдэлд /хатгалгаа, сүрьеэ, суулгалт, осол гэмтэл зэрэг/ нөлөөлөх хүчин зүйлсийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг аймаг, нийслэлийн Засаг даргын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн	Үнэлэх боломжгүй

					<p>чиглэлд тусган хэрэгжүүлэх”. • 3.1.4.3-т “Хүүхдийг ахуй болон зам тээврийн осол, гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх талаар эцэг, эх, асран хамгаалагч, багш нарын хариуцлагыг нэмэгдүүлэх сурталчилгааны ажлыг өрнүүлж, санамж сэрэмжлүүлэг түгээх” гэсэн заалт тусгаад байна. □ Эрүүл мэндийн сайдын тушаалаар байгуулсан “Осол, гэмтэл, хүчирхийллээс урьдчилан үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах салбар дундын ажлын хэсэгт ХНХЯ-ны төлөөлөл хамтран ажиллаж байна. □ Энэхүү хөтөлбөрийн төсөлд “Хүүхдийн осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, аюулгүй орчин бүрдүүлэн хүүхдийн осол гэмтлээс шалтгаалсан өвчлөл нас баралтыг бууруулах” гэсэн зорилт 2-ын хүрээнд хүүхдийн осол гэмтлээс сэргийлэх, аюулгүй орчин бүрдүүлэх хууль эрх зүйн орчин бүрдүүлэх, хүүхдийн түлэгдэлтийн эрсдэлт хүчин зүйлийг бууруулах, хүүхдийн бусад төрлийн /живэх, унаж бэртэх, хордох, хөлдөх, хахах/ осол гэмтэл, бэртлээс сэргийлэх 3 чиглэлийн хүрээнд 20 арга хэмжээг тусгаад байна.</p>	
170		3. Бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр эцэг эхчүүд, багш сурган хүмүүжүүлэгч, олон нийтэд чиглэсэн нөлөөлөл, сургалт сурталчилгааны ажлыг зохион	2016 - 2020		<p>Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2019 оны А/10 дугаар тушаалаар ЕБС-ийн Аюулгүй амьдрах ухааны сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх багшид зориулсан сургалтын багц боловсруулах ажлын хэсгийг байгуулсан. Тус ажлын хэсэг сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чиглэлээр туршлага болохуйц үйл ажиллагаа явуулж буй байгууллагын ажилтай танилцан, хөтөлбөрт багц үзүүлэх, материал хийх агуулгыг тусгайлан боловсруулж гаргалаа. Багшид зориулсан арга зүйн зөвлөмжийг боловсруулж, 2800 ширхэг DVD хэвлүүлж, сургуулиудад хүргэсэн. Энэхүү арга зүйн зөвлөмжид бага насны хүүхдийг осол гэмтлээс урьдчилан</p>	Үнэлэх боломжгүй

		байгуулах			сэргийлэхэд эцэг, эх, багш сурган хүмүүжүүлэгчийн хийж гүйцэтгэх ажил, тэдгээрийн арга зүй, хамтын ажиллагааны загваруудыг тусгасан бөгөөд ерөнхий боловсролын сургуулиуд энэ дагуу сургалт, сурталчилгааны ажлыг эцэг, эхийн зөвлөл, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хийж гүйцэтгэж байна. Мөн “Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль- хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээний үлгэрчилсэн загвар” боловсруулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/508 дугаар тушаалаар баталлаа. Уг гэрээг 2019-2020 хичээлийн жилээс эхлэн байгуулж, хэрэгжүүлэх бөгөөд бага насны болон сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдыг сургууль, олон нийтийн орчинд хамгаалахад сургууль болон гэр бүлийн зүгээс гүйцэтгэх үүргийг тодорхой тусгасан болно.	
171	3.4.11.Өсвөр үе, залуучуудад нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгож, халдварт өвчлөлийн тархалтыг бууруулна.	1. Оюутан, өсвөр үе, залуучуудад бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол олгох, тусламж, үйлчилгээ авах ээлтэй орчин бүрдүүлэх	2016 - 2020		Эрүүл мэндийн сайд, Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын сайдын хамтарсан 2018 оны 11 сарын 27-ны А/480, А/739 тоот “Оюутны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг зохион байгуулах тухай” тушаалын дагуу жил бүр оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аян зохион байгуулан ажиллаж байна. Энэ хичээлийн жилд эрт илрүүлгийн 6 төрлийн өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээг оршин суугаа харьяалал харгалзахгүй хамруулах ажлыг зохион байгуулж, шинээр элсэгчдийн 90 гаруй хувь нь хамрагдсан. Эдгээр оюутнуудын 54 гаруй хувь нь дотуур байранд амьдардаг оюутнууд байна. Мөн дээд боловсролын сургалтын байгууллагууд нь Оюутанд эрүүл мэндийн зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн үзлэгт хамрагдах, эрүүл мэндийн төв болон эмчтэй байхад анхааран ажиллаж суралцагчдынхаа эрүүл мэндийн даатгалыг төлүүлэх, хөнгөлөх, эрүүл амьдрахад нь зөвлөн	Үнэлэх боломжгүй

					хамтран ажиллаж байна. Тухайлбал 10 дугаар сарын 8-нд МУИС-ийн дотуур байрны оюутнуудад Сүхбаатар дүүргийн 6 дугаар хорооны “САЙН НАРАН” Өрхийн эрүүл мэндийн төвийн их эмч М.Нармандах “Бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвийн хүрээнд гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс хамгаалах аргууд болон ХДХВ/ДОХ, тэмбүү зэрэг бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар яриа, таниулга хийж оюутнуудын сонирхсон асуултад хариулан зөвлөгөө өгч ажилласан.	
172		2. Өсвөр үе, залуучуудын хөгжлийн цогцолбор, төвүүдийг үе шаттай байгуулж, төвөөр зорилтот бүлгийн өсвөр үе, залуучуудад чиглэсэн амьдрах ухааны боловсрол олгох, эрүүл мэнд, нөхөн үржихүйн ойлголт хандлагыг нэмэгдүүлэх, сургалт, зөвлөгөө, мэдээлэл хүргэх орчин нөхцөлийг бүрдүүлэх	2017 - 2020		"Эрүүл мэнд"-ийн сургалтын хөтөлбөр боловсруулж, БСШУС-ын сайдын 2018 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн А/467 дугаар тушаалаар батлуулан ерөнхий боловсролын нийт сургуульд хэрэгжүүлж байна. Түүнчлэн БСШУС-ын сайдын 2019 оны А/62 дугаар тушаалаар “Эрүүл мэнд” хичээлийн сурах бичгүүдийг сургалтын хөтөлбөрт нийцэж буй байдалд үнэлгээ хийж, дүгнэлт гарган 4-12 дугаар ангийн “Эрүүл мэнд” сурах бичигт саналыг бүрэн тусгалаа. Ерөнхий боловсролын нийт сургуулийн дунд, ахлах ангид хүчин төгөлдөр мөрдөж буй эрүүл мэндийн сургалтын хөтөлбөрөөр болон биологи, нийгмийн ухаан, иргэний боловсролын сургалтын хөтөлбөрөөр суралцагчдад гэр бүлийн боловсрол олгож байна. БСШУС-ын сайдын 2019 оны "Хөтөлбөр батлах тухай" А/756 дугаар тушаалаар "Насан туршийн боловсрол" хөтөлбөрийг батлан хэрэгжүүлж эхэллээ. Хөтөлбөрт Насан туршийн боловсролын салбарт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, өсвөр үеийнхэнд амьдрах ухаан, мэргэжлийн чиг баримжаа олгох Зөвлөгөө-мэдээллийн төвийг 2020 онд багтааж, 21 аймаг, 9 дүүргийн Насан туршийн төвийг түшиглэн байгуулахаар төлөвлөлөө.	Үнэлэх боломжгүй

Дөрөв. БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

173	<p>4.1.7.“Тогтвортой хөгжлийн боловсрол” хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлж, олон нийтэд эх дэлхийгээ хайрлах, уламжлалт ёс заншлаа дээдлэх мэдлэг олгож, байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.</p>	<p>1. "Тогтвортой хөгжлийн боловсрол" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх</p>	<p>2016 - 2020</p>		<p>Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.7 дахь зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10.3, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 56.1-д заасныг үндэслэн Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 04-ний өдрийн 209 дүгээр тогтоолоор “Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Тухайн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын 1-12 дугаар ангийн математик, мэдээлэл зүй, нийгмийн ухаан, гадаад хэл зэрэг 46 төрлийн хичээлд тогтвортой хөгжлийн үзэл санаа туссан байдалд үнэлгээ хийж дүгнэлт гаргалаа.Ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрт тогтвортой хөгжлийн боловсрол зорилго, агуулгын хувьд харьцангуй сайн тусгагдсан ч цөм хөтөлбөр бүрийн бүтэц, агуулга, боловсруулалт харилцан адилгүй жигд бус байгаа нь хэрэглэгчдэд ойлгомжгүй байдал бий болгож байна гэсэн дүгнэлтийг Боловсролын хүрээлэнгээс гарсан. Энэхүү үндэсний хэмжээний судалгааны дүгнэлтэд тулгуурлан бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг сайжруулан боловсронгуй болгож, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/492 дугаар “Хөтөлбөр батлах тухай” тушаалаар баталлаа. Тус сайжруулсан сургалтын хөтөлбөрөөр 2019-2020 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын нийт сургуулийн сурагчид хичээллэж байна. Сайжруулсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургалтад тогтвортой хөгжлийн үзэл санааг тусган хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг 2019 оны 8 сард аймаг, дүүрэг бүрд зохион байгуулж ерөнхий боловсролын</p>	<p>Үнэлэх боломжгүй</p>
-----	---	---	--------------------	--	---	-------------------------

					сургуулийн багш нарыг 100 хувь хамруулсан.	
174	4.4.4.Монгол Улсын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг гадаад улс оронд сурталчлах, маркетингийн үйл ажиллагааг төрөөс дэмжиж, жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.	4. Нүүдлийн соёл, аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	2016 - 2020		Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүхийн ивээл дор “Азийн ардын урлагийн их наадам” 2019 оны 06 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдлаа. Энэхүү наадамд Азийн 12 орны 200 гаруй, үндэсний 2028 ардын авьяастнууд ардын бүжиг, ардын дуу, ардын хөгжим, язгуур урлагийн чуулга, зан үйлийн чуулга гэсэн 5 төрлөөр ур ухаан, авьяас чадвараа сорин өрсөлдлөө. Их наадмыг ардын урлагийн наадмуудын Дэлхийн ассоциацаас томилогдсон мэргэжлийн шүүгчид шүүн тунгааж дараах байдлаар шилдгүүдийг шалгарууллаа. Наадмын шилдгийн шилдэг тэргүүн байранд Дорнод аймгийн хөгжимд драмын театрын “Туургатан” хамтлаг, хоёрдугаар байранд БНСУ-ын “Чончун” хамтлаг, гуравдугаар байранд БНХАУ-ын ӨМӨЗО-ны ардын авьяастан Атха нар тус тус шалгарч цом, мөнгөн шагнал, өргөмжлөлийг гардлаа. Мөн “Азийн ардын урлагийн их наадам”-ын 5 төрөл тус бүрээр 1, 2, 3-р байруудыг шалгаруулж шагнаж урамшуулсан юм.	Үнэлэх боломжгүй
ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО						
175	5.3.7.Бүх нийтийн эрх зүйн боловсролын хөтөлбөр хэрэгжүүлнэ.	1. Эрх зүйн анхан шатны мэдлэг, боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлагын судалгааг хийж, үр дүнг олон нийтэд танилцуулан,	2017		Монгол Улсын Засгийн газраас 2018 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 50 дугаар тогтоолоор “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталсан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Меркадо ХХК-иас хамтран “Эрх зүйн анхан шатны мэдлэг, боловсрол олгож буй өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээ, шаардлага” сэдэвт суурь судалгаа”-г хийж, судалгааны үр дүнг танилцуулах, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус уулзалт хэлэлцүүлэгт боловсролын салбарыг	Үнэлэх боломжгүй

		хэлэлцүүлэг зохион байгуулах				/Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам-2 хүн, Нийслэлийн боловсролын газар-3 хүн, түүний харьяа дүүргийн Боловсролын хэлтэс-18 хүн, Насан туршийн боловсролын үндэсний төв-3 хүн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт-3 хүн, Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын менежер-5 хүн, нийгмийн ажилтан, их, дээд сургуулийн багш нар-10 хүн/ төлөөлж нийт 30 гаруй төлөөлөл оролцсон. Тус судалгаанд нийт 8 аймаг, нийслэлийн 9 дүүргийн 5-24 насны 2000 иргэнийг хамруулсан байх ба судалгааны дүнд эдгээр насны иргэдийн эрх зүйн мэдлэг, боловсролын түвшин хангалттай бус хэмжээнд байна гэсэн дүгнэлт гарсан бөгөөд судалгаанд хамрагдсан бага насны хүүхдүүд эрх зүйн талаарх мэдлэг, мэдээллийг эцэг, эх, багш, сурган хүмүүжүүлэгч, зарим хүүхдийн нэвтрүүлгээс олж авч байгаа бол өсвөр насны хүүхдүүд болон 20-25 насны залуучууд гол төлөв өргөн дэлгэцийн нэвтрүүлэг, нийгмийн сүлжээ, ном, сурах бичгээс олж авч байна гэсэн үр дүн гарсан. Судалгааны дүнд үндэслэн Хууль зүйн хүрээлэнгээс зохион байгуулсан “Эрх зүйн хөтөч” бэлтгэх 2 өдрийн сургалтад бүх аймгуудын Насан туршийн боловсролын төвийн 21 багш, Насан туршийн боловсролын үндэсний төвийн 4 мэргэжилтэн, мөн нийслэлийн 8 дүүргийн Насан туршийн боловсролын төвийн 24 багшийг сургалтад хамруулав.	
176	5.4.4. Мөнгө угаах, хүний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан	1. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх	2017 - 2018			“Монгол Улсад үндэсний CERT хөгжүүлэх” зөвлөх үйлчилгээний төслийн хүрээнд 2019 оны 8 дугаар сарын 29-ний өдөр төрийн байгууллагууд, үүрэн холбооны операторууд, банкнуудын мэдээллийн систем, аюулгүй байдал хариуцсан ажилтан, албан хаагчдыг хамруулсан “Монгол Улсад үндэсний CERT хөгжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлгийг зохион	Үнэлэх боломжгүй

177	сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.	2. Цахим орчин болон нийгмийн сүлжээнд иргэдийн хувийн мэдээллийг хэрхэн хамгаалах талаар мэдлэг, ойлголтыг төлөвшүүлж, хэвшүүлэх	2018 - 2020		байгуулахад оролцсон. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн санхүүжилтээр “Иргэдийн мэдээллийн технологийн хэрэглээний өнөөгийн байдлын талаарх судалгаа” төслийн тодорхойлолт, тавигдах шаардлагыг боловсруулж, дараах чиглэлээр судалгаа хийсэн. • Иргэдийн мэдээлэл, харилцаа холбооны технологийн хэрэглээний өнөөгийн байдлын судалгаа • Нийгмийн мэдээллийн сүлжээний хэрэглээний талаарх судалгаа "МХХТ-ийн хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн контентийг олон нийтэд түгээх нэгдсэн төлөвлөгөө"-г батлуулж, уг төлөвлөгөөний дагуу үүрэн холбооны операторууд болох Юнител, Скайтел, ЖиМобайл, Мобиком-ийн сүлжээгээр улиралд 2 удаа ухаалаг төхөөрөмж, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх агуулга бүхий масс мессэжийг олон нийтэд хүргэсэн. “Мэдээлэл харилцаа холбооны технологийн хэрэглээний мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэгдсэн контентуудыг олон нийтэд түгээх” төслийг БНҮҮС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн ба гүйцэтгэгч байгууллагаар “Марчаахай” ХХК шалгаран 1 нэвтрүүлэг, 2 анимэйшн, 12 шторк, 6 нийтлэл, 3 постер хийж гүйцэтгэсэн. Контентуудыг олон нийтийн сүлжээгээр болон телевизүүдээр дамжуулан олон нийтэд хүргэж байна. Харвард их сургуулийн Беркман Клейн төвийн мэргэжилтнүүдийн боловсруулсан “Digital literacy library” буюу “Тоон бичиг үсгийн номын сан” хөтөлбөрийг 2019 оны 4 дүгээр сард хэрэгжүүлж эхэлсэн. Багш сурагчийн харилцан идэвхтэй хамтын оролцоонд тулгуурлаж явагддаг уг сургалтын хөтөлбөрийн хүрээнд цахим орчинг зохистой ашиглах, цахим орчинд хувийн мэдээллээ хамгаалах талаар мэдлэг, ойлголт өгөх хичээлүүдийг ерөнхий боловсролын 20 сургуулийн	Үнэлэх боломжгүй
-----	---------------------------------	---	-------------	--	--	------------------

					ахлах ангийн сурагчдад заасан.	
178	5.5.10.Цэргийн албыг иргэний төлөвшил, эх оронч үзэл, хүмүүжлийн үндэс байх бодлогыг хэрэгжүүлж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлэн, иргэдэд эх орноо хамгаалахад оролцох, цэргийн боловсрол, бэлтгэл эзэмшүүлэх боломжийг нэмэгдүүлнэ.	1. Бүх шатны боловсролын байгууллагын сургалтын хөтөлбөрт хүүхэд, залуучуудад цэрэг эх оронч үзэл, хүмүүжил олгох хичээлийн хөтөлбөрийг тусгаж, хэрэгжүүлэх	2016 - 2018		Засгийн газрын 2019 оны 200 дугаар тогтоолын дагуу Боловсрол, соёл, шинжлэх ухаан спортын сайд, Батлан хамгаалахын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан А/567, А/227, А/268 тоот тушаалаар ажлын төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. “Хүүхэд, залуучуудад цэрэг, эх оронч үзэл төлөвшүүлэх” үндэсний хөтөлбөрийг оюутнуудад танилцуулах, Монголын цэргийн түүх, өв соёл, монгол цэргийн энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож, Монгол хүн болж төрснөөрөө бахархах, үзэл төлөвшүүлэх зорилгоор МУИС, ШУТИС зэрэг их дээд сургуулиуд болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран сургалт зохион байгуулсан.	Үнэлэх боломжгүй
179		2. Төрийн өмчит их, дээд сургуулиудад "Цэргийн эрдмийн тэнхим" байгуулж, оюутан, залуучуудад цэргийн анхан шатны бэлтгэл, сургалт явуулах нөхцөлийг бүрдүүлэх	2018 - 2020		Цэргийн эрдмийн тэнхим санхүүжилтийн эх үүсвэргүйн улмаас байгуулагдаагүй байна.	Үнэлэх боломжгүй
180		3. Цэргийн шинжлэх ухаан, боловсрол, судалгаа, эрдэм шинжилгээний	2016 - 2020		БХЯ-ны захиалгаар 2019 онд 3 төслийг 179.3 сая төгрөгөөр санхүүжүүлсэн. ХЗДХЯ-ны захиалгаар Дотоод хэргийн их сургуулиас ШУТСангийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Гэмт хэргийн статистикийг боловсронгуй болгох асуудал” шинжлэх	Үнэлэх боломжгүй

		байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх			ухаан, технологийн төслийн эрдэм шинжилгээний ажлын тайланг Шинжлэх ухаан технологийн сан"-д 2019 оны 05 сарын 03-ны өдөр хүлээлгэн өгсөн. Тус төслийн хүрээнд гэмт хэргийн статистикийн онол, арга зүйн үндэслэлийг тодорхойлон, түүний үр дүнг сургалтын болон практик үйл ажиллагаанд нэвтрүүлэх, шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын гэмт хэргийн талаарх мэдээллийн сан бүрдүүлэх, статистикийн мэдээлэл эрхлэн гаргах арга зүй, аргачлал, мэдээллийн систем, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шийдлийг судлан гаргасан. Төслийн үр дүнд "Хуучин Эрүүгийн хуулиар оногдуулсан хорих ялыг шинээр батлагдан мөрдөгдөж буй Эрүүгийн хуульд дүйцүүлэн хасаж тооцоход хэрэглэх математик статистикийн аргачлал болон "Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны статистикийн үзүүлэлт тооцох аргачлал" тус тус батлагдсан.	
181	5.6.9.Хилийн чанадад ажиллаж, амьдарч, сурч байгаа иргэдийнхээ хууль ёсны эрх, ашиг сонирхлыг тууштай хамгаалж, эрх нь зөрчигдсэн тохиолдолд хууль, эрх зүйн туслалцааг шуурхай үзүүлж, иргэний бүртгэл, нотариатын болон консулын үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулна. Энэ	6. Хилийн чанадад амьдарч буй монгол иргэдийн хүүхдэд монгол хэл соёлын мэдлэг чадвар олгох сургалтын хөтөлбөр, цахим сурах бичиг боловсруулж, хэрэгжүүлэх	2016 - 2017		"Монгол хэл, соёлын сургалтын жишиг хөтөлбөр"-өөр 57 сургалтын төвд 1000 гаруй хүүхэд хичээллэн монгол хэл, соёлоо судалж байна. Мөн цахим сурах бичгийг сургалтдаа ашиглаж байна. Хилийн чанад дахь монгол хэлний сургалтын төвийн багш нарыг монгол хэл заах арга зүйг чадавхжуулах сургалтыг 2018 оны 8 дугаар сард Улаанбаатар хотод зохион байгуулж, сургалтад АНУ, ХБНГУ, БНСАУ, Япон, Чех, Швед, Швейцар, Канад, Бельги зэрэг оронд монгол хэл, соёлын сургалтын төвд ажиллаж буй 15 багш оролцлоо. Мөн 2019 оны 06 дугаар сард Шведийн Вант Улсын Стокгольм хотод болсон хилийн чанад дахь багш нарын "Гадаад хэлтэй орчинд монгол хэлийг заах онцлог" сэдэвт сургалтад 23 багшийг хамруулсан. БНСУ-ын "Монгол сургууль"-д БСШУС-ын яамнаас баталсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу 300 сурагч суралцаж байгаа	100%

	хүрээнд “Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сан”-ийн хөрөнгө, хүртээмжийг нэмэгдүүлнэ.				бөгөөд 2020 оны төсвийн төсөлд дээрх сургуулийн сурагчдад хувьсах зардлыг олгохоор төсөвт тусгаад байна. Мөн Энэтхэг Улсад Буддын шашны сүм хийдэд шавилан суугаа монгол хүүхдэд ерөнхий боловсрол олгох арга замыг шийдвэрлэх зорилгоор БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Монголын Бурхан шашинтны төв, Гандантэгчилэн хийдийн хамтарсан ажлын хэсэг очиж танилцан дүгнэлт гаргаад байна.	
182	5.6.10.Монгол Улсын түүх, соёлын өв уламжлал, эдийн засаг, нийгмийн салбарын ололт амжилт, хөгжил дэвшил, гадаад бодлого, харилцаа, хамтын ажиллагааг дэлхий нийтэд сурталчлан таниулах ажлыг эрчимжүүлж, Монгол Улсыг сурталчилсан үзэсгэлэн, яармаг, кино, соёл, урлагийн тоглолт, өдрүүд, уулзалт, ярилцлага зэрэг арга хэмжээг хилийн чанадад зохион байгуулна. Монгол судлалын хүрээг тэлэх, тогтвортой хөгжлийг	3. Соёлын биет болон биет бус өвүүдийг ЮНЕСКО-гийн өвийн жагсаалтад бүртгүүлэх	2016 - 2020		2019 онд "Хөхүүрийн айраг эсгэх уламжлал, холбогдох зан үйл" өвийг Хүн төрөлхтний соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад нэр дэвшүүлэхээр холбогдох баримт бичгийг боловсруулж, Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийн Нарийн бичгийн дарга нарын газарт хүргүүлсэн. Нэр дэвшүүлсэн өвийг Колумбын нийслэл Богато хотноо 2019 оны 12 дугаар сарын 9-14-ний өдрүүдэд зохион байгуулагдсан конвенцийн Засгийн газар хоорондын хорооны 14 дүгээр чуулганаар хэлэлцэж баталсан. Ингэснээр манай улс ЮНЕСКО-ийн Соёлын биет бус өвийн жагсаалтад 15 дахь өвөө амжилттай бүртгүүлсэн болно. Дэлхийн өвийн үндэсний урьдчилсан жагсаалтад орсон "Буган чулуун хөшөө бүхий хүрлийн үеийн цогцолбор" дурсгалыг дэлхийн өвийн жагсаалтад нэр дэвшүүлэх техникийн баримт бичгийг боловсруулж, 2019 онд Дэлхийн өвийн төвд хүргүүлсэн. Нэр дэвшүүлсэн дурсгалыг ИКОМОС-оос томилогдсон шинжээчид танилцуулах ажлыг 2019 оны 8 дугаар сарын 15-24-ний өдрүүдэд зохион байгуулж, Архангай, Хөвсгөл аймагт ажилласан. Мөн 11 дүгээр 23-ны өдөр ИКОМОС-ын шинжээчидтэй холбогдож нэмэлт мэдээллийг өгөөд байна.	100%
183	хангах үндсийг бүрдүүлнэ.	6. Монгол судлалыг	2017 - 2020		Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 4 дүгээр сарын 4-ний өдрийн 98 дугаар тогтоолоор "Монгол	100%

		хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх				судлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр"-ийг баталсан. Хөтөлбөр хэрэгжих хугацаа 2018-2021 он. Монгол судлалын үндэсний зөвлөлийн 2019 оны 5 дугаар сарын 01-ний өдрийн 01 тогтоолоор 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд шаардагдах 852.443.0 төгрөгийг, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 7 дугаар сарын 18-ны өдрийн “Зардал батлах тухай” А/456 дугаар тушаалаар Олон улсын Монгол судлалын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Монгол судлалыг сурталчлах зардлыг тус тус баталсан. Үйл ажиллагааны хүрээнд Олон улсын Монгол судлалын холбооноос Монколика сэтгүүлийг хэвлүүлэх, Монгол судлалын сонгодог бүтээл хэвлүүлэх, Дэлхийд тархсан Монгол өв цувралаас 1 ботийг хэвлэхэд шаардагдах материал бэлтгэх, каталоги хэвлэн нийтлүүлэх, Монгол судлалын мэдээллийн тогтмол үйл ажиллагаа, номын сангийн баяжилт хийх зэрэг ажлыг гүйцэтгэлээ. Монгол судлалын үндэсний зөвлөлийн тогтоолоор баталсан 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд 100 хувийн гүйцэтгэлтэй биеллээ.	
184	5.6.12.“Зөгийн үүр” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, гадаадад сурч, ажиллаж өндөр мэдлэг, боловсрол, технологи, ур чадвар эзэмшсэн залуучуудыг эх орондоо тогтвор суурьшилтай ажиллахад дэмжлэг	6. Эрүүл мэндийн чиглэлээр гадаад улсад суралцаж мэргэжил эзэмшсэн болон ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг эх орондоо ажиллахад дэмжлэг үзүүлэх	2017 - 2020			БСШУС-ын сайдын 2018 оны А/229 дугаар тушаалын дагуу ОХУ- их, дээд сургуульд эмч мэргэжлээр бакалаврын зэрэг эзэмшсэн 30 орчим төгсөгчийн дипломыг магистрын дипломтой дүйцүүлсэн. АШУҮИС-д Япон, Тайвань, БНХАУ, Нидерланд зэрэг гадаад оронд докторын зэрэг хамгаалсан 12 эмчийг ажилд авч, багшлуулж байна. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар АШУҮИС-ийн сургалтын эмнэлэг баригдан 2019 оны 04 дүгээр сарын 02-нд ашиглалтад орсон. Орчин үеийн өндөр хүчин чадалтай техник, технологиор бүрэн тоноглогдсон, эмчилгээний 104 ортой эмнэлэг бөгөөд одоогийн байдлаар 61 эмч үндсэн орон тоон дээр	Үнэлэх боломжгүй

	үзүүлнэ.				ажиллаж байгаагийн дотор ОХУ, БНХАУ, Унгар, Итали, ХБНГУ, БНСУ зэрэг оронд 11 доктор, 6 магистр зэргийн боловсрол эзэмшсэн нийт 17 эмч шинээр ажилд орсон. Тус эмнэлэгт өдөртөө амбулаториор 600, жилд 192 мянган хүнд үйлчлэхээс гадна хэвтэн эмчлүүлэхээр 4300 орчим хүнд үйлчилж, ойролцоогоор 2300 орчим мэс засал, 10 гаруй мянган дүрс оношлогооны ажилбарыг гүйцэтгэх боломжтой.	
185		8. Хөдөлмөрийн гэрээний хугацаанд ажлын байрандаа тогтвортой ажилласан иргэний мэргэжлийн ур чадварыг үнэлэн баталгаажуулах боломжийг бүрдүүлэх	2016 - 2020		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/50 дугаар тушаалын хавсралтаар "Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэжлийн түвшинг үнэлэх, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах" журмыг баталсан. Журмын хэрэгжилтийг хангахад ХНХЯ-тай хамтран ажиллаж байна.	Үнэлэх боломжгүй
186	5.6.13.Нарийн мэргэжлээр сурч, хилийн чанадад өндөр мэргэжлийн, академик ажил эрхэлж байгаа монголчуудад эх орныхоо хөгжилд алсаас хувь нэмэр оруулах боломж бүрдүүлж, Монгол Улс дахь эрдэм шинжилгээний	2. Гадаадад академик ажил эрхэлж байгаа Монгол эрдэмтдийн мэдээллийн сан бүрдүүлж, тэдгээрийг дотоодын судалгааны ажилд оролцох, хамтарсан төсөл хэрэгжүүлэх	2017 - 2020		"Хилийн чанадад нарийн мэргэжлээр сурч, академик ажил эрхэлж байгаа Монгол иргэдийн эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах боломжийг бүрдүүлэх" төсөл зарлан гүйцэтгэгчийг сонгон шалгарууллаа. Төслийн хүрээнд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд: 1. Хилийн чанадад академик ажил эрхэлж байгаа Монгол эрдэмтэд болон нарийн мэргэжлээр олон улсын нэр хүнд бүхий байгууллагад ажиллаж буй монгол иргэдийн мэдээллийн сан, нээлттэй цахим сүлжээг бий болгох, 2. Хилийн чанадад дахь Монгол эрдэмтэн, судлаачдыг дотоодын судалгааны ажилд оролцох, Монгол дахь эрдэмтэн судлаачидтай хамтарсан төсөл	100%

	байгууллага, их дээд сургууль, лабораторитой холбож өгнө.	боломжийг бүрдүүлэх			хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, туршлага солилцох дэд бүтцийг бий болгох, 3. Гадаадын шилдэг туршлага, технологийг Монголд нутагшуулахад хамтран ажиллах хөрөнгө оруулагчдын сүлжээг бий болгох, зөвлөх үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, 4. Судалгаа, шинжилгээний ажлын талаар туршлага солилцох, мэдээллээр хангах платформ бий болгох. Азын хөгжлийн банкны санхүүжилтээр шинжлэх ухааны нээлттэй мэдээллийн платформыг байгуулах ажлын даалгаврыг боловсруулж гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгарууллаа. Уг ажлын хүрээнд төслийн сонгон шалгаруулалт, төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг нээлттэй цахим орчинд байрлуулах, эрдэм шинжилгээний хурлын менежментийн системийн ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн. Засгийн газрын 2019 оны 162 тогтоолоор баталсан “Шинжлэх ухаан, технологи, инновацийн хүний нөөцийг үндэсний хөтөлбөр”-ийн 2.2.3-т заасан зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд гадаадад академик ажил эрхэлж байгаа Монгол эрдэмтдийг урьж ажиллуулах, хамтран ажиллах санал, санаачилгыг дэмжих, мэдлэг ур чадвараас нь суралцах асуудлыг тусгасан. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөлд эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулиудаас санал аван нэгтгэн ажиллаа.	
ЗУРГАА. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТАЛААР ТУСГАЙЛАН ОРУУЛАХ ЗААЛТУУД						
187	6.1.4.Аймгийн хүүхэд драмын театрын шинэ барилгыг гүйцээж ашиглалтад оруулна.	1. Архангай аймгийн Хөгжимт драмын театрын шинэ барилгыг гүйцээж	2017 - 2018		Хөгжимт драмын театрын шинэ барилгын ажлын гүйцэтгэгчээр "Акми холдинг" ХХК-ийг сонгож, 2013 оны 06-р сарын 28-нд барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан. 2019 онд 2752.4 сая төгрөгийн санхүүжилттэй ажиллаж барилга угсралтын ажлын	70%

		ашиглалтад оруулах				гүйцэтгэл 80 хувьтай байна. Монгол Улсын 2020 оны улсын төсөвт тус төсөл, арга хэмжээний төсөвт өртөг 13,492.2 сая төгрөг, санхүүжих дүн 3,543.8 сая төгрөгөөр батлагдсан. 2020 оны 2 дугаар улиралд ашиглалтад орно.	
188	6.1.5.Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг Хүүхдийн парктэй болгоно.	1. Архангай аймгийн Эрдэнэбулган сум дахь Хүүхэд залуучуудын цэцэрлэгт хүрээлэнг Хүүхдийн парктэй болгох зураг төсвийг хийж батлуулах	2017			Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан тус төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхийн тул 2017, 2018, 2019, 2020 оны улсын төсвийн санал тусгагдаж, Сангийн яаманд хүргүүлсэн боловч улсын төсөвт хөрөнгө батлагдаагүй болно. БСШУС-ын сайдын 2020 оны их засварын хөрөнгөөр зураг төсөл, болон ажил эхлүүлэх санхүүжилтийг шийдвэрлэхээр болсон. 2020-2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгаж, Засгийн газарт хүргүүлж, танилцуулсан.	40%
189		2. Хүүхдийн парк байгуулах	2018 - 2020			Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан тус төсөл, арга хэмжээний хөрөнгө оруулалтыг шийдвэрлэхийн тул 2017, 2018, 2019, 2020 оны улсын төсвийн санал тусгагдаж, Сангийн яаманд хүргүүлсэн боловч улсын төсөвт хөрөнгө батлагдаагүй болно. 2020-2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтад тусгаж, Засгийн газарт хүргүүлж, танилцуулсан.	Үнэлэх боломжгүй
190	6.2.2.Алтанцөгц, Цэнгэл, Алтай, Сагсай сумдад сургуулийн хүүхдийн дотуур байр барина.	1. Алтай, Сагсай сумдын дотуур байрны барилгыг ашиглалтад оруулах	2017			2016 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баян-өлгий Алтай, Сагсай сумдад сургуулийн хүүхдийн дотуур байрны барилга угсралтын ажлыг эхлүүлсэн ба 2016 оны 11 дүгээр сарын 28-өдөр Сагсай суманд 100 ортой дотуур байрны барилгыг барьж ашиглалтад өгсөн. Алтай сумын 150 ортой дотуур байрны барилгыг 2017 оны 12 дугаар сарын 01 өдөр	100%

					ашиглалтад өгсөн бөгөөд шаардлагатай тавилга тоног төхөөрөмжийг олгосон.	
191		2. Алтанцөгц, Цэнгэл сумдын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийх	2018		Монгол Улсын 2018 оны төсөвт Баян-Өлгийн аймгийн Цэнгэл сум Загас нуур багт 143.0 сая төгрөг батлагдсан бөгөөд Барилга засварын ажил хийгдэж дууссан. Алтанцөгц сумын сургуулийн барилгын засварын саналыг 2018, 2019 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн боловч батлагдаагүй.	40%
192		1. Соёлын төвийн барилга барих /Гурванбулаг сум/	2017 - 2018		Тус суманд 200 хүний суудалтай соёлын төвийн барилгыг 1197.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр барихаар төлөвлөж, 2018 онд 500.0 сая төгрөгийн хөрөнгө батлагдаж, ТӨБЗГ тендер зарлаж гүйцэтгэгчээр Хонгор буурал ХХК шалгарч барилгын ажил эхлүүлсэн. 2019 оны төсөвт үлдэгдэл санхүүжилт батлагдаж, барилга угсралтын ажил 70%-тай байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 500.0 сая төгрөг тусгагдсан. 2020 оны II улиралд ашиглалтад орно.	70%
193	6.3.3.Заг, Гурванбулаг, Хүрээмарал, Бууцагаан, Жинст, Баян-Овоо сумдад соёлын төв барина.	2. Соёлын төвийн барилга барих /Галуут сум/	2017 - 2018		2019 оны төсвийн тухай хуульд 1,230.0 төсөвтэй 2019 онд 869.0 сая төгрөг суугдсан. Барилга угсралтын ажлыг "Жи Жи Ай" ХХК шалгарч барилгын ажлыг эхлүүлсэн. Газар шороо болон суурийн ажил, 1 дүгээр давхрын хэв хашмалын ажил хийгдэж байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 1101.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	70%
194		3. Соёлын төвийн барилга барих /Хүрээмарал сум/	2018 - 2019		Баянхонгор аймгийн Хүрээмарал суманд 240 хүний суудалтай соёлын төвийн барилгыг 1749.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр барихаар төлөвлөж, 2019 онд 400.0 сая төгрөг батлагдсан. Тендерийн үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж, "Ганмөнхжин" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан. Газар шороо болон суурийн ажил хийгдэж байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 1349.6 сая төгрөг	70%

					тусгагдан батлагдсан.	
195		4. Соёлын төвийн барилга барих /Заг сум/	2018 - 2019		Тус суманд 240 хүний суудалтай соёлын төвийн барилгыг 1.767.7 сая төгрөгийн төсөвт өртгөөр барихаар төлөвлөж, 2019 онд 869.0 сая төгрөгийн хөрөнгө батлагдаж, орон нутагт тендер зохион байгуулж, "Алегортовар констракшн" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан. Барилга угсралтын ажлыг эхлүүлэх бэлтгэл ажил хийгдэж байна. Суурийн холболтын зураг төсөл хийгдэж байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 898.7 сая төгрөг тусгагдан батлагдсан.	40%
196		5. Соёлын төвийн барилга барих /Шаргалжуут тосгон/	2019 - 2020		БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр 2020 оны улсын төсвийн саналд тусган, Сангийн сайдад хүргүүлсэн боловч 2020 оны улсын төсөвт хөрөнгө батлагдаагүй.	Үнэлэх боломжгүй
197	6.3.4.Баянхонгор суманд усан бассейн бүхий спорт цогцолборыг барьж дуусгана.	1. Спорт цогцолбор, усан бассейны барилга барих /Баянхонгор сум/	2017 - 2018		2019 оны төсөвт барилгын өртөг 9.0 тэрбум төгрөг, 2019 онд 2.0 тэрбум төгрөг зарцуулахаар тусгагдан Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд хөрөнгө батлагдаж, орон нутагт тендер зохион байгуулж, "Эр Эм Би" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан. Барилгын гүйцэтгэл 40%-тай байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 2.0 тэрбум төгрөг тусгагдан батлагдсан.	40%
198	6.3.5.Баянхонгор суманд орчин үеийн 300 хүний суудал бүхий кино театр барина.	1. Кино театрыг барьж ашиглалтад оруулах	2017 - 2019		Баянхонгор суманд кино театрын барилга барих төсвийн 1000.0 сая төгрөгийг 2020 оны төсөвт суулгуулахаар БСШУС-ын сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
199	6.5.3.Сургуулийн барилга, спорт	1. Говь-Алтай аймгийн	2016 -		Говь-Алтай аймгийн Есөнбулаг суманд баригдаж байгаа ЭМШУИС-ийн харьяа 960 суудалтай салбар	100%

	заалны барилга, 960 суудал /Говь-Алтай, Есөнбулаг, ЭМШУИС-ийн харъяа Анагаах ухааны коллеж/	Есөнбулаг суманд баригдаж байгаа ЭМШУИС-ийн харъяа 960 суудалтай салбар сургуулийн барилгын ажлын үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэж, ашиглалтад оруулах	2020			сургуулийн барилга угсралтын ажил бүрэн дууссан. Үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэсэн. Сургуулийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байна.	
200		1. Сүмбэр сумын 1 дүгээр багт баригдаж буй Канад загварын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгах	2017			Сүмбэр сумын 1 дүгээр багт баригдаж буй Канад загварын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлыг дуусгахад 2017 оны төсвийн 2 дугаар тодотголоор 482.0 сая төгрөг батлагдсан Барилгын ажил дуусч ашиглалтад орсон.	100%
201	6.6.1.Сүмбэр, Шивээговь суманд шинэ цэцэрлэг барина.	2. Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгыг шинээр барих	2017 - 2019			Сүмбэр сумын 5 дугаар цэцэрлэгийн 150 хүүхдийн өргөтгөлийн барилгыг 1619.2 сая төгрөгөөр барихаар төлөвлөж 2019 оны төсөвт 819.2 сая төгрөг батлагдан, орон нутагт тендер зохион байгуулж, "Виритас Глобал" ХХК гүйцэтгэгчээр шалгарсан. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 800.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	70%
202		3. Шивээговь сумын 3 дугаар цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилгыг шинээр	2017 - 2020			Шивээговь суманд 3 дугаар цэцэрлэгийн 100 хүүхдийн өргөтгөлийн барилгыг 1200.0 сая төгрөгөөр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт суулгуулахаар Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч	Үнэлэх боломжгүй

		барих			УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	
203	6.6.2.Сүмбэр сумын 2 дугаар сургууль, Шивээговь сумын 3 дугаар сургуулийг хичээлийн шинэ байртай болгоно.	1. Сүмбэр сумын 2 дугаар сургуулийн 640 хүүхдийн барилгыг шинээр барих	2017		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1а/7248 тоот албан бичгээр Сангийн сайдад “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тайлбар, танилцуулга” хүргүүлсэн. 2018 оны улсын төсөвт батлагдаагүй, барилгын нийт төсөвт өртөг 5.629.4 сая төгрөг, 2019 онд 2.000.0 сая төгрөг санхүүжсэн. Гүйцэтгэгчээр "Идэр чандмань" ХХК шалгарч, барилгын гүйцэтгэл 50%-тай. А, Б, В, Г блокийн төмөр бетон карказ суурийн ажлууд хийгдсэн байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 2.629.4 сая төгрөг тусгагдан батлагдсан.	70%
204		2. Шивээговь сумын 3 дугаар сургуулийн 640 хүүхдийн барилгыг шинээр барих	2017 - 2018		Шивээговь суманд 3 дугаар сургуулийн 640 хүүхдийн хүчин чадалтай барилгыг 3600.0 сая төгрөгөөр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт 2500.0 сая төгрөгийг суулгуулахаар Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
205		1. Боржигон чуулгын шинэ барилга барих	2017 - 2020		Аймгийн төвд Боржигон чуулгын шинэ барилгыг 5,494.0 сая төгрөгөөр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт 1494.0 сая төгрөгийг суулгуулахаар Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна. 2019 онд Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Боржигон чуулгын гаднах талбайн тохижилт төсөл, арга хэмжээний 106.0 сая төгрөг батлагдаж,	Үнэлэх боломжгүй

					засварын ажил хийгдэж дууссан.	
206	6.7.4."Багш хотхон" болон "Боловсрол хотхон"-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ	1. "Багш хотхон" болон "Боловсрол хотхон"-ы бүтээн байгуулалтыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2017 - 2020		Монгол Улсын 2016-2019 оны төсвийн тухай хуулийн саналд Спортын ордон шинэчлэн барих хөрөнгийг тусгах санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна. Мөн 2020 оны улсын төсвийн төсөлд тусган Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн боловч батлагдаагүй.	Үнэлэх боломжгүй
207	6.8.3.Эрдэнэ суманд дотуур байр барина. /75 хүүхдийн/	1. Дотуур байр барих /Эрдэнэ сум/	2017		2019 оны улсын төсөвт XII.1.1.196 хуулийн дугаартай Дотуур байрын барилга, 80 ор /Дорноговь, Эрдэнэ сум/ 1.161.0 төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан, үүнээс 2019 онд 500.0 сая төгрөг батлагдсан. Гүйцэтгэгч компанитай 2019 оны 05 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил 60%-тай байна. Каркасан хийцийн угсралт, 1 давхрын дүүргэлтын ажил дуусч, 2-р давхрын дүүргэлтийн ажил үргэлжлэн явагдаж байна. Гадна инженерийн шугам сүлжээний ажил хийгдсэн. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 661.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	70%
208	6.8.7.Сайншанд суманд цэцэрлэг барина. /300 хүүхдийн/	1. 5 дугаар цэцэрлэгийн өргөтгөл барих /150 хүүхэд, Сайншанд/	2017		АНУ-ын буцалтгүй тусламжийн хөрөнгөөр Монголиан Пропертиз ХХК гүйцэтгэгчээр шалгарч тус суманд 50 ортой цэцэрлэгийн барилга барьж байна. 2020 оны 8 сард багтаан ашиглалтад оруулна.	70%
209		2. 8 дугаар цэцэрлэгийн өргөтгөл барих /Сайншанд/	2017		Монгол Улсын 2018 оны төсвийн саналд их засвар хийхээр 321.6 сая төгрөг, 2019 оны төсөвт 2019 онд санхүүжих 570.5 сая төгрөг байхаар хүргүүлсэн ч төсөв батлагдаагүй. Харин 160,0 сая төгрөгөөр засвар хийсэн.	70%

210		3. Цэцэрлэг барих /125 хүүхэд, Сайншанд, Зүүнбаян баг/	2018			Сайншанд сумын Зүүнбаян багт орших 7-р цэцэрлэг 100 хүүхдийн хүчин чадалтай байсан учир нэмэлт 125 хүүхдийн цэцэрлэг барих шаардлагагүй гэсэн орон нутгийн шийдвэр гарсан. Харин 50 хүүхдийн цэцэрлэгийн өргөтгөл хийгдэж, 2018 оны 12 дугаар сарын 8-ны өдрөөс эхлэн хэвийн үйл ажиллагаа явуулж байна.	100%
211		4. Цэцэрлэг барих /Сайншанд, 1 дүгээр баг/	2019			Сайншанд сумын 1 дүгээр багт 150 хүүхдийн ортой, 1.600.0 сая төгрөгний төсөвт өртөг бүхий барилга нь 2019 онд 100 ортой, төсөвт өртөг нь 962,0 болж өөрчлөгдсөн. Цэцэрлэгийн барилын гүйцэтгэгчээр "Гантулга" ХХК шалгарч, тус компанийн барьсан цэцэрлэгийн барилгыг худалдан авсан.	100%
212		5. Цэцэрлэг барих /Сайншанд, 6 дугаар баг/	2019			Сайншанд сумын 6 дугаар багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгыг 1600.0 сая төгрөгөөр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт суулгуулахаар Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
213	6.9.4.Аймагт Хүүхдийн ордон, Спортын ордон шинээр барина.	2. Спортын ордон шинээр барих	2017 - 2018			Дорнод аймгийн Хэрлэн суманд 5300.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй усан бассейн бүхий спортын ордон шинэ барилга барихаар төлөвлөж 2017, 2018, 2019, 2020 оны улсын төсвийн санал тусгагдаж, Сангийн яаманд хүргүүлсэн боловч улсын төсөвт хөрөнгө батлагдаагүй болно. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Дорнод аймгийн Чулуунхороот суманд Спорт заалны барилгын хөрөнгө оруулалт батлагдаж, БСШУСЯам 2019 оны 08 дугаар сарын 15-ны өдөр "Айнекс инженеринг" ХХК-тай барилга угсралтын ажлын гэрээг байгуулсан.	Үнэлэх боломжгүй
214	6.10.1.Луус, Адаацаг сумдад сурагчдын	1. Луус суманд сурагчдын дотуур	2019			2019 оны улсын төсөвт XII.1.1.197 хуулийн дугаартай Дотуур байрын барилга, 80 ор /Дундговь, Луус сум/	70%

	дотуур байр барина.	байр шинээр барих				973.0 төгрөг батлагдсан. Үүнээс 2019 онд 500.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгчээр "Ганцаг" ХХК шалгарсан. Барилгын суурь болон 1 дүгээр давхрын өрлөгийн ажил хийгдэж дууссан. Хучилтын ажил хийгдэж байгаа бөгөөд барилгын ажлын гүйцэтгэл 45 хувьтай байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 473.0 сая төгрөг тусгагдан батлагдсан.	
215		2. Адаацаг суманд сурагчдын дотуур байр шинээр барих	2020			Дундговь аймгийн Адаацаг суманд 2097.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй сурагчдын дотуур байр шинээр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт суулгуулахаар Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
216		1. Дэлгэрхангай суманд спорт заалны барилга шинээр барих	2017			2018 оны улсын төсөвт 2.377.0 төгрөг батлагдсан бөгөөд Урагшлах ХХК гэрээ 2228,8 сая төгрөгийн өртөгтэйгөөр гэрээ байгуулсан. 2018 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилтээр барилгын ажил эхэлсэн. Сургууль, спорт зал 2-ыг холбох хүзүүвчний барилгын санхүүжилтийг нэмэлтээр шийдвэрлэсэн, барилгыг 11 сард ашиглалтад хүлээлгэн өгсөн.	100%
217	6.10.2.Дэлгэрхангай, Адаацаг, Сайхан-Овоо, Луус, Говь-Угтаал сумдад спорт заал барина.	2. Адаацаг суманд спорт заалны барилга шинээр барих	2018			Дундговь аймгийн Адаацаг суманд 1200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй спорт заалны барилга шинээр барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт суулгуулахаар Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
218		3. Сайхан-Овоо суманд спорт заалны барилга	2019			Монгол Улсын 2016-2019 оны төсвийн тухай хуулийн саналд Спортын ордон шинэчлэн барих хөрөнгийг тусгах санал хүргүүлсэн боловч хөрөнгө	Үнэлэх боломжгүй

		шинээр барих				шийдвэрлэгдээгүй байна. Мөн 2020 оны улсын төсвийн төсөлд тусган Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн боловч батлагдаагүй.	
219		4. Луус суманд спорт заалны барилга шинээр барих	2020			Монгол Улсын 2016-2019 оны төсвийн тухай хуулийн саналд Спортын ордон шинэчлэн барих хөрөнгийг тусгах санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдвэрлэгдээгүй байна. Мөн 2020 оны улсын төсвийн төсөлд тусган Сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн боловч батлагдаагүй.	Үнэлэх боломжгүй
220		5. Говь-Угтаал суманд спорт заалны барилга шинээр барих	2018			Барилгын ажил 2019-2020 онд хэрэгжихээр 1000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 онд 500.0 сая төгрөгийн санхүүжилттэй "Бум констракшн" ХХК-тай гэрээ хийсэн. Барилгын суурийн ажил хийгдэж байна.	40%
221	6.10.3.Говийн ирээдүйн цогцолбор сургуульд спорт заал барина.	1. Говийн ирээдүйн цогцолбор сургуульд спорт заал шинээр барих	2017			Монгол Улсын 2019 оны төсвийн хуульд Говийн ирээдүйн цогцолбор сургуулийн спорт тоглоомын талбайн тохижилтод 200,0 сая төгрөг суугдаж, ажлыг "Мандал шигтгээ" ХХК гүйцэтгэн 100% ашиглалтад оруулсан. Спорт заалны барилгын ажил 2020-2021 онд хэрэгжих бөгөөд 800.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй. 2020 оны улсын төсөвт 320.0 сая төгрөг тусгагдсан байна.	70%
222	6.10.5.Төв Халхын дуулалт жүжгийн театрын барилгын ажлыг дуусгана.	1. Төв Халхын дуулалт жүжгийн театрын шинэ барилгын ажлыг дуусгах	2017 - 2019			Дундговь аймгийн Сайнцагаан суманд Төв халх дуулалт жүжгийн театрын шинэ барилга 6800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 онд 2000.0 сая төгрөгийн санхүүжилттэй "Суурь" ХХК-тай гэрээ хийсэн. Барилгын суурийн ажил хийгдэж дууссан. Гүйцэтгэл 20 хувьтай байна. 2020 оны улсын төсвийн саналд нэмэлт ажлын 2780.0 сая төгрөг тусгах санал хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан. Тус ажил 2021 онд ашиглалтад орохоор	70%

					2020 оны улсын төсөвт тусгагдсан.	
223	6.10.6.Адаацаг, Цагаандэлгэр, Баянжаргалан, Өндөршил, Дэлгэрцогт сумдад соёлын төвийн барилга барина.	1. Адаацаг суманд соёлын төвийн барилга шинээр барих	2019		Дундговь аймгийн Адаацаг суманд 1737.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй соёлын төвийн барилга буулгаж, 240 суудалтай шинэ барилга барихаар төлөвлөсөн. Иймд 2020 оны улсын төсөвт суулгуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр 2020 оны улсын төсвийн саналд тусган Сангийн сайдад хүргүүлсэн ч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
224		2. Цагаандэлгэр суманд соёлын төвийн барилга шинээр барих	2018 - 2019		Монгол Улсын 2019 оны улсын төсвийн тухай хуульд Дундговь аймгийн Баянжаргалан суманд баригдах 240 судалтай соёлын төвийн барилгын төсөвт өртөг 1,230.0 сая төгрөг батлагдсан. Худалдан авах ажиллагааг орон нутагт зохион байгуулахад гүйцэтгэгч шалгараагүй тул төсвийн жил дуусч, хөрөнгө буцаан татагдсан. 2020 онд орон нутагт шинээр дахин тендер зарлана.	40%
225		3. Баянжаргалан суманд соёлын төвийн барилга шинээр барих	2019 - 2020		Дундговь аймгийн Баянжаргалан суманд 1000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй соёлын төвийн барилгыг буулган, 200 суудалтай шинэ барилга барихаар төлөвлөсөн. Иймд 2020 оны төсөвт суулгахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн ч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	Үнэлэх боломжгүй
226		4. Өндөршил суманд соёлын төвийн барилга шинээр барих	2020		Дундговь аймгийн Өндөршил суманд 1269.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй соёлын төвийн барилга буулгаж, 250 суудалтай шинэ барилга барихаар төлөвлөж, 2020 оны төсөвт суулгуулахаар Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268	Үнэлэх боломжгүй

					тоот албан бичгээр Сангийн сайдад 2020 оны улсын төсвийн саналд тусган хүргүүлсэн ч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан байна.	
227		5. Дэлгэрцогт суманд соёлын төвийн барилга шинээр барих	2018 - 2019		Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 8 дугаар сарын 14-ний 1/а 9577 албан тоотоор 2019 оны төсвийн төслийг Сангийн яаманд хүргүүлэхдээ Дэлгэрцогт суманд соёлын төвийн барилга шинээр барихад 1,2 тэрбум төгрөгөөр тооцсон ч төсөв батлагдаагүй. 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 1а/7268 тоот албан бичгээр төсвийн саналыг Сангийн сайдад хүргүүлснээр Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд тус соёлын төвийг 1,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2020 онд санхүүжих дүн 500.0 сая төгрөгөөр баталсан.	40%
228	6.12.1.Сургууль, цэцэрлэгийг шаардлагатай багуудад шинээр барина. /Цагаанчулуут, Рашаант, Булаг, Шанд, Уртын гол, Яргуйт, Даваат, Согоот/	1. Сургууль, цэцэрлэгийг шаардлагатай багуудад шинээр барих /Цагаанчулуут, Рашаант, Булаг, Шанд, Уртын гол, Яргуйт, Даваат, Согоот/	2016 - 2020		Цагаанчулуут багт 280 хүүхдийн цэцэрлэг баригдсан 2019 оны 04 сард ашиглалтад орсон. Рашаант багт 250 хүүхдийн сургуулийн барилгын гүйцэтгэгчээр 1900,0 сая төгрөгийн гэрээний үнийн дүнгээр Жам ХХК шалгарсан. Барилгын суурийн ажил хийгдэж байна. 15 хувийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны улсын төсөвт саналд нэмэлт ажлын 600.0 сая төгрөг тусгагдан батлагдсан. Булаг багт 150 хүүхдийн цэцэрлэг баригдаж байна. Бодьхангай ХХК гүйцэтгэгчээр шалгарсан, барилга 100 хувийн гүйцэтгэлтэй 2019 оны 12 дугаар сард ашиглалтад орсон байна. Яргуйт багт 150 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гүйцэтгэгчээр Ээлт-Өлгий ХХК шалгарсан. Барилгын явц 80 хувьтай байна. Согоот багт 150 хүүхдийн 2 цэцэрлэг баригдаж байна. 2019 оны 9 сарын 01-нд болон 2020 онд ашиглалтад орно. Уртын гол, Даваат багт тус бүр 150 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилгын төсвийг тус бүр 1,600.0 сая төгрөгний төсөвтэй тооцон,	70%

					2019.08.14-ны өдрийн 1а/7268 тоот албан бичгээр 2020 оны төсвийн төсөлд санал хүргүүлсэн ч батлагдаагүй.	
229	6.12.2.Алслагдсан багуудад соёл, спортын төвүүдийг шинээр байгуулна.	1. Алслагдсан багуудад соёл, спортын төвүүдийг шинээр байгуулах	2016 - 2020		Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд Орхон аймгийн Баян-Өндөр сумын Даваат багийн соёлын төвийн 250 суудалтай барилгын төсөвт өртөг 1500.0 сая төг буюу 2019 онд 650 сая төгрөг батлагдсан. Барилга угсралтын ажил 20 хувийн гүйцэтгэлтэй байна. 2020 оны улсын төсөвт нэмэлт ажлын 850.0 сая төгрөг тусгагдан батлагдсан. Мөн Орхон аймгийн Баян-Өндөр сумын Наран багийн соёлын төвийн барилга 1000.0 сая төгрөгийн өртөгтэй, гүйцэтгэгчээр Наян констракшн ХХК шалгарч, барилга угсралтын ажил эхэлсэн. Орхон аймгийн Баян-Өндөр сумын Баянбулаг багийн спорт заалны барилга 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2019 онд 300.0 сая төгрөг батлагдаж, гүйцэтгэгч сонгон барилга угсралтын ажил хийгдэж байна. Барилгын үндсэн карказ дууссан. Гадна өнгөлгөөний өрлөг дууссан, дотор засал, цонх суулгах ажил хийгдэж байна. Барилга угсралтын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй байна. Үлдэгдэл санхүүжилт болох 279.4 сая төгрөгийг Сайдын 2019 оны 12 сарын 06 өдрийн А/775 “Санхүүжилтийн өөрчлөлт оруулах тухай” тушаалаар зохицуулалт хийж шийдвэрлэсэн.	70%
230	6.12.6.Стандартын шаардлага хангасан музейн барилга барьж, үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлж, хадгалалтыг сайжруулна.	1. Стандартын шаардлага хангасан музейн барилга барьж, үзмэрийн сан хөмрөгийг нэмэгдүүлж, хадгалалтыг сайжруулах	2016 - 2020		Орхон аймгийн Баян-Өндөр суманд 3912.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй музейн барилга шинээр барилга барихаар төлөвлөж, Монгол Улсын 2017, 2018, 2019, 2020 оны улсын төсвийн саналд тусгаж, Сангийн яаманд хүргүүлсэн боловч УИХ-аар хэлэлцүүлэх саналаас хасагдсан. /Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2017 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн 1а/7248 тоот албан бичгээр “Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын	Үнэлэх боломжгүй

					салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн төсөл, 2018-2019 оны төсвийн төсөөллийн тайлбар, танилцуулга"-ыг, 2018 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 1/а 9577 албан тоотоор, 2019 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 1а/7268 тоот албан бичгээр тус тус төсвийн төслийг Сангийн сайдад хүргүүлсэн.	
--	--	--	--	--	--	--